

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-8

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

9-90

-
- | | |
|---|----------------|
| 1.“Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох” асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт | 10-21 |
| 2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/ | 21-22 |
| 3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Аудитын сэдэв батлах тухай/ | 22-51
66-67 |
| 4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/ | 51-54
67-68 |
| 5.Нийцлийн аудитын тайлан /Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах тухай/ | 55-66 |
| 6.Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох | 68-90 |

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 10-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Б.Заяабал;
Чөлөөтэй: Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Пүрэвдаваа;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, П.Мөнхтулга.

Нэг. “Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох” асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн газрын мэргэжилтэн О.Золбоо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болормаа, мөн газрын улсын ахлах бүртгэгч Э.Отгонтунгалаг, Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэл зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор Ш.Одонсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Нийслэлийн тойргийн нотариатч Ч.Баянжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох” асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ногдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн газрын мэргэжилтэн О.Золбоо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болормаа, мөн газрын улсын ахлах бүртгэгч Э.Отгонтунгалаг, Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэл зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор Ш.Одонсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Нийслэлийн тойргийн нотариатч Ч.Баянжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Наранбаатар: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Аудитын сэдэв батлах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Аудитын сэдэвтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Да.Цогтбаатар, П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, Р.Батболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Түвшин, П.Сайнзориг, Д.Жаргалсайхан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийн 9-д тусгагдсан Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал сэдэвт аудитын сэдвийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	15
Бүгд:	18

16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Үндэсний аудитын газраас нийслэлийн үйл ажиллагаа, төсөв дээр аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл, түүний үр дүн, үр өгөөжид аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан, Гадаадын нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд гүйцэтгэх аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, “Шинэ хоршоо”, “Чинээлэг малчин” хөтөлбөрийн зээл, зарцуулалт, эргэн төлөлт, мал аж ахуйн салбарт гарсан чанарын үзүүлэлт, үр нөлөөнд аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайханы гаргасан, Улаанбаатар хотын хэсгийн ахлагч нарын цалин хөлс олголтын байдалд аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, ОНӨҮГ-ын үйл ажиллагаа, үр өгөөжид аудит хийлгэх гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн тайлбар хийж, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг асуудлыг түр хойшлуулав./14:47/

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэвт өөрчлөлт оруулах тухай саналыг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар уг асуудлыг хойшлуулав./15:08/

Тав.Нийцлийн аудитын тайлан /Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Д.Нямжаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Энхбаатар, Барилгын хөгжлийн төвийн Ерөнхий инженер З.Энх-Оргил, мөн төвийн Барилга, байгууламжийн зураг, төслийн магадлалын хэлтсийн мэргэжилтэн Г.Сансар, Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар, П.Сайнзориг, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Ч.Номин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нийцлийн аудитын тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 15 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Аудитын сэдэв батлах тухай/ асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Н.Наранбаатар: “Аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Тогтоолд өөрчлөлт оруулах тухай/ асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Н.Наранбаатар: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16

62.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, мөн газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан болон Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар, П.Сайнзориг, Ч.Номин, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн Макро эдийн засгийн бодлогын

газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, П.Сайнзориг, Б.Түвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайд болон Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 45 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 25 минут.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

7 дугаар тойрог Наранбаатар ирсэн, 11 дүгээр тойрог Норовын Алтанхуяг ирсэн, 3 дугаар тойрог Тилеуханы Аубакир ирсэн, жагсаалт Ринчиндоржийн Батболд ирсэн, жагсаалт Хөххүүгийн Болормаа ирсэн, 7 дугаар тойрог Гомбын Ганбаатар ирсэн, жагсаалт Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн, 11 дүгээр тойрог Пүрэвжавын Сайнзориг ирсэн, жагсаалт Баатаржавын Мөнхсоёл ирсэн, 2 дугаар тойрог Загджавын Мэндсайхан ирсэн, 2 дугаар тойрог Банзрагчийн Түвшин ирсэн, 1 дүгээр тойрог Ганзоригийн Тэмүүлэн ирсэн, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа ирсэн, 1 дүгээр тойрог Даваагийн Цогтбаатар ирсэн, 2 дугаар тойрог Баттогтохын Чойжилсүрэн ирсэн.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ноогдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

2.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл “Аудитын сэдэв батлах тухай”.

4.Байнгын хорооны тогтоолын төсөл “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”.

5.Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах тухай сэдэвт нийцлийн аудитын тайланг хэлэлцэх.

6.Монгол Улсын 25 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дүгээр асуудал, эхний асуудал.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ноогдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Болормаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэнэбаяр Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэл зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Одонсүрэн Монгол Улс ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор, Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сайханчулуун Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга, Баярмаа Татварын ерөнхий газрын Татвар төлөгчдийн үйлчлэх газрын Бүртгэлийн хэлтсийн дарга, Отгонтунгалаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын Улсын ахлах бүртгэгч, Золбоо Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүний микрофоныг өгөөрэй.

П.Сайнзориг: Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын иргэн Отгоны Батхүүгээс үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг үүсгэн уг өргөдлийг 100176 иргэн дэмжсэн асуудлыг Төсвийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Төсвийн байнгын хорооны 2025 оны 21 дүгээр тогтоолоор үл хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу үл хөдлөх хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн орлогод ноогдуулах албан татварын ажлуудыг судалж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5 дахь хэсэгт заасан хүрээнд санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн миний бие ахалж, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Д.Батбаяр, Р.Батболд, Б.Заяабал, Б.Мөнхсоёл, Д.Мөнхтулга, Ч.Номин, Б.Түвшин, Д.Цогтбаатар нар ажиллалаа.

Ажлын хэсэг нийтийн гаргасан өргөдлийн асуудлаар онол, практикийн түвшинд нарийвчлан судалж, үл хөдлөх хөрөнгө борлуулсан орлогод ноогдуулдаг албан татвартай холбоотой хууль тогтоомж, харьцуулсан судалгаа, лавлагаа, мэдээлэлтэй танилцан дараах асуудлыг Байнгын хороонд танилцуулж байна.

Үл хөдлөх хөрөнгө борлуулах, шилжүүлэхэд төлөх татварын асуудал нь дан ганц татварын асуудал биш бөгөөд татварын бодлого, орон сууцжуулалтын бодлого, хөрөнгийн зах зээлийн бодлого, мөн мөнгө угаах терроризмаас санхүүжүүлэх гэдэгтэй холбоотой асуудалтай нягт холбоотой байна.

Тодруулбал, татварын бодлогын хувьд үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдон татварын бодлогыг оновчтой тодорхойлж, шударга, үр ашигтай байдлаар хэрэгжүүлэхийн тулд аливаа эд хөрөнгийн мөчлөгийн буюу худалдан авах, эзэмших, борлуулах харилцааг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, харилцаа тус бүр нь үзүүлж буй татварын хэмжээ их, эсхүл бага хувь хэмжээтэй байх нь нөгөөдөө шууд нөлөөлдөг тул үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой татварын харилцааг салангид бус уялдаатай багц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн улс орнуудад эдгээр үе шат бүрд нийтлэг байдлаар татвар ноогдуулж, өөрийн улс орны онцлогт тааруулан тухайн төрлийн татварыг ялгаатай хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд үл хөдлөх хөрөнгө эд хөрөнгийг борлуулах үед үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийн борлуулалтаас олох орлогод хувь хүний орлогын албан татварын 2 хувиар ноогдуулж байгаа бөгөөд энэ нь үл хөдлөх хөрөнгийн борлуулсан үнийн тодорхой хувиар тооцдог шилжилтийн шилжүүлгийн татварын шинжтэй байна.

Харин үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшиж байх хугацаанд буюу өмчилж байх үед үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 0.6-2 хувиар ноогдуулж үл хөдлөх эд хөрөнгийн худалдан авах үед шилжүүлгийн татварыг ноогдуулдаггүй байна.

Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д албан татвар гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ноогдуулж, хариу төлбөргүйгээр улсын төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг гэж, 10 дугаар зүйлийн 10.1-д татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэлбэрүүдийг заасан байх бөгөөд татварын хувь хэмжээг хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээнд татвар ноогдуулах заалтыг бүхэлд нь хүчингүй болгохтой шууд холбоогүй байна.

Өөрөөр хэлбэл, Хувь хүний орлогын албан татварын хуулийн 21.2.1-ийн дэх заалтыг хүчингүй болох татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхтэй шууд адилтгах боломжгүй бөгөөд бодлогын үр нөлөө, татварын суурь шударга, тэгш байх зарчимд нийцүүлэн тусгайлан авч үзэх шаардлагатай юм.

Мөн нийтийн гаргасан өргөдлийн дагуу үл хөдлөх эд хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох тооцооллыг хийхэд сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн орлого 115 тэрбум төгрөгөөр буурч, сум, дүүргүүдийн нийтийн үйлчилгээ, зам засвар, хог хаягдлын менежмент, гэрэлтүүлэг, орчны тохижилт, орон нутгийн дэд бүтэц зэрэг өдөр тутмын

үйлчилгээг санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж төвлөрсөн төсөвт илүү ихээр хамааралтай болж, бие даасан бодлого хэрэгжүүлэх боломж буурахаар байна.

Уг өргөдөлтэй холбоотойгоор орон сууцын бодлого буюу орон сууцын бүртгэл, орон сууцын зах зээлийн хувьд ямар нөлөө үзүүлэх талаар мэдээллийг хүргэе.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон сууцжуулах бодлогыг өрхийн орлогод, боломжид нийцсэн хүртээмжтэй орон сууц нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, инженерийн дэд бүтцийг сайжруулах, зорилтот бүлгийг орон сууцаар хангах механизмыг өргөжүүлэх, гэр хорооллын суурь орчныг үе шаттай сайжруулах зэргээр цогц байдлаар тодорхойлон холбогдох арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бүхий л мэдээллийг агуулах цахим бүртгэлийн систем төдийлөн сайн хөгжөөгүй байна.

Өөрөөр хэлбэл, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах, холбогдох төрийн байгууллага болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй мэдээлэл солилцох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн байна.

Иргэн тухайн орон сууцыг өмчлөн өөрөө амьдарч байгаа эсэх, бусдад түрээсээр хөлслүүлж байгаа эсэх, амьдран суух зориулалтаар ашиглаж байгаа эсэх түүнийг нотариатаар хэрхэн бүртгэдэг эсэх, мөн гэрээний төрлүүд зэрэг бүртгэлтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болоогүй байгаа нь иргэн орон сууцаа ямар зорилгоор борлуулсан эсэхийг бодитойгоор ялган тогтоох боломжгүй байна.

Мөн манай улсад оршин суугаа хаягийн бүртгэл үнэн, зөв бус түрээслэгч, түрээслүүлэгч, түрээслэгчийн бүртгэл сул хөгжсөн, орон байрны өмчилдөг иргэдийн хөрөнгийн бодит ашиглалтын зорилго тодорхой бус тул иргэдийн орон сууц борлуулалтын зорилгыг нотлох, ангилах нөхцөл бүрдээгүй байна.

Мөн Монгол Улсын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаа бөгөөд зах зээлийн үнэлгээ сүүлийн 10 жилд 8.7 дахин, сүүлийн 5 жилд 4.3 дахин өсөж, 2024 онд 13 их наядад хүрсэн байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн татварыг дангаар нь чөлөөлөх нь хөрөнгийн нийт зах зээлд татварын гажуу нөлөө үүсгэж, үл хөдлөх хөрөнгө рүү хэт төвийлгөх хандлага бий болгодог бөгөөд ингэснээр хувьцаа, бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн бусад хэрэгслүүдийг хөрвөх чадвар сулрах, хөрөнгийн төрөлжилт буурах, цаашлаад үнийн өсөлт, зээлийн хүүгээс давсан үед богино хугацааны ашиг олох скапляц нэмэгдэж, орон сууцын үнэ хөөрөгдөж, эрэлтийн хэлцэл олширно.

Үүний улмаас бодит хэрэглээний худалдан авагч зах зээлээс шахагдаж, орон сууцын хүртээмж буурч, санхүүгийн эко систем тогтворгүй болох эрсдэлтэй байна. Мөн аль нэг төрлийн хөрөнгийг хөрөнгө борлуулсны орлогын татвараас чөлөөлж давуу байдал үүсэх нь эдийн засгийн салбар хоорондын хөрөнгө оруулалтын хэвийн хуваарилалтыг алдагдуулж, инновац, үйлдвэрлэл зэрэг бүтээмж өндөр салбаруудад чиглэх ёстой хөрөнгө оруулалт, үл хөдлөх эд хөрөнгийн салбарт шилжих нөхцөлийг бүрдүүлэхээс гадна урт хугацааны эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжилттэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа үйл ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллага гүйлгээний талаар мэдээлэх үүргийг хүлээсэн бөгөөд энэ нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын мөнгө угаах эрсдэлд өндөр этгээд гэдгийг хуулиар тодорхойлжээ.

Үл хөдлөх эд хөрөнгө нь дэлхий даяар хууль бус орлого, аливаа авлига, татвараас зайлсхийх замаар олсон хөрөнгийг нуун дарагдуулах, цэвэр мэт харагдуулах хамгийн түгээмэл хэрэгсэлд тооцогддог бөгөөд олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ нь үл хөдлөх эд хөрөнгийн салбарыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй салбар гэж тодорхойлдог.

Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогыг татваргүй болгох нь өмчлөл хөрөнгийн урсгалын талаарх татварын мэдээллийг давхар хяналтыг сулруулж, гүйлгээний ил тод байдлыг бууруулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх бөгөөд ФАТФ-аас онцолдог үл хөдлөх эд хөрөнгийг мөнгө угаах зорилгоор түгээмэл ашигладаг үл хөдлөх эд хөрөнгийн үнийг зориудаар өндрөөр, эсхүл багаар тогтоох замаар гүйлгээнд оруулах. Гуравдагч этгээдийг гуравдагч этгээдийн ашиглан жинхэнэ өмчлөгчийг нуун дарагдуулах, хөрөнгийн эх үүсвэрийг нуухын тулд үл хөдлөх эд хөрөнгийн бэлэн мөнгөөр худалдаалах, худалдан авах, үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж аваад маш богино хугацааны дотор дахин худалдах замаар хөрөнгийг цэвэршүүлэх зэрэг мөнгө угаах өндөр эрсдэлтэй аргуудыг илүү хялбараар үйлдэх боломжийг нэмэгдүүлэхээр байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн татварыг чөлөөлөх асуудал нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн эрхийн бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Орон сууцын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль болон холбогдох бодлогын бичиг баримтаар зохицуулагдаж байна.

Иймд ажлын хэсэг нь дээр дурдсан хууль тогтоомжийн судалгаа, мэдээллийг тооцоход үндэслэн нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1 дэх заалтад заасны дагуу холбогдох бодлогын бичиг баримт, хууль, тогтоолын төсөл боловсруулах асуудлаар “Засгийн ажилд чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Уг тогтоолын төсөлд Монгол Улсын хөгжлийн баримт бичигт туссан орон сууцжуулах бодлоготой уялдуулан иргэнийг анх удаа орон сууц худалдаж авах, өмчлөх анхны болон ипотекийн зээлээр худалдан авсан орон сууцаа борлуулах, орон сууцын нөхцөлөө сайжруулахад татварын дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулж, холбогдох төрийн байгууллага болон нийтийн эрх зүйн этгээдтэй мэдээлэл солилцох асуудлыг тодорхойлох, иргэдийн орлогод нийцсэн орон сууцын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг оновчтой тодорхойлж, үл хөдлөх эд хөрөнгийн болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээний хууль, эрх зүйн орчныг сайжруулах, үл хөдлөх эд хөрөнгийн татвараас чөлөөлөх, татвар ноогдуулахтай

холбоотой зохицуулалтыг оновчтой болгох, эд хөрөнгийн өмчлөл, хөрөнгийн урсгалын талаарх татварын мэдээллийн давхар хяналтыг сайжруулах, гүйлгээний ил тод байдлыг хангах, мөнгө угаах терроризмыг санхүүжих эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, энэ хүрээнд тусгай хамгаалалттай газруудад баригдсан орон сууцад татвар ноогдуулах, төсвийн орлого нэмэгдүүлэх, татвараас чөлөөлөхгүй байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг асуудалтай холбогдуулан хуулийн төслийг боловсруулж, Татварын багц хуулийн төсөл, эсхүл үзэл баримтлалыг тусад нь тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар тусгасан болно.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан байгаа болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. Санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн асуулт асууя.

Н.Алтанхуяг: Надаар таслах ч юу байх юм. Энэ гишүүд чинь байхгүй юм байна шүү дээ. Хэдхэн хүн байх юм. Энэ Сайнзориг гишүүн орон сууц худалдан борлуулахтай холбогдсон 2 хувийн татвар гээд Батхүү гээд хуульч санал гаргаад 100 гаран мянган гарын үсэгт одоо манай ажлын хэсэг юм уу Их Хурлаас ийм л хариу өгөх гэж байгаа юм уу? Би энэ л цаасыг хэлж байгаа юм. Сайнзориг оо энэ цаасыг хэлж байгаа юм. Ийм л хариу өгөх гэж байгаа юм уу тээ? Одоо ер нь нэг сонин байдал үүсчихлээ дээ. Энэ их иргэдээс санал авна гэж баахан шуугиулаад л. Би одоо 3 кэйс ярих гэж байгаа юм.

1 дүгээрт нь энэ Занданшатар Их Хурлын дарга байхдаа НӨАТ-ын 2 хувийг 5 болгон ч билүү нэг юм яриад л тэгээд жонхуураад л юу ч биш болоод хаялаа. Энэ Нямбаатар нөхөр машины татвар 3 дахин нэмснийг бас жонхууруулж жонхууруулж бараг жил болгож байгаад л буцаагаад баахан урт өгүүлбэртэй нэг ийм цаас шидсэн. Одоо энэ дээр бас ингээд цаас шидээд л орхиод байдаг их буруу. Бид нарыг хий төрийн байгууллага, Улсын Их Хурал их буруу л жишиг рүү яваад байна. Иргэдийг баахан хошхируулж баахан саналууд авчхаад буцаагаад Засгийн газарт чиглэл маягийн ийм олон хуудас цаас өгөөд энэ нь тэгээд бас хэзээ буцаж орж ирж ажил хэрэг болох юм? Ийм ойлгомжгүй байна л даа. Тэгэхээр энийг жаахан анхаараад би та нарын энэ “Засгийн газарт чиглэл олгох тухай” тогтоолыг харж байна л даа. Энэ дотор чинь нэг л их баахан юм биччихэж.

Би энэ хэлэлцүүлгийн явцад маргааны явцад бас юу ойлгоод байгаа вэ гэхлээр энийг 2 хувийн татварыг хүчингүй болгочихвол энийг худалдан борлуулдаг байнгын үйл ажиллагаа янз бүрийн юм хийдэг хүмүүс дээр бас хожил үүснэ гээд иймэрхүү юм яригдаад байгаа. Тиймэрхүү байж магадгүй. Тэгэхээр энэ дээр бичиж байгаа шиг иргэн анх удаа орон сууц худалдан авах, өмчлөх гээд энийгээ ингээд

цэгцэлнэ гээд ингээд хаячихдаг байхгүй юу. Одоо манайх энэ жилийн дараа ч юм уу орж ирэх ч үгүй аягүй бол.

Тэгэхээр иргэдийн тавьсан саналд ийм байдлаар хариу өгөөд байдаг энэ муу жишгийг арилгаж болохгүй юм уу Сайнзориг гишүүн та залуу хүн ажлын хэсэг ахалж байгаа юм чинь энийг дахиж жаахан янзлаад тэгээд тодорхой юм хэлмээр байна шүү дээ. Төдний дотор энэ асуудлыг шийдэж орж ир, эсвэл иргэн, иргэдээс ингээд асуудал тавиад энийг нь авч хэлэлцэхээр болчихсон тохиолдолд шуурхай ажлын хэсэг гаргаад одоо таны бичээд байгаа энэ шийдлийн зарим шийдлийг нь шийдэж орж ирээд, 2 хувийн татварыг хүчингүй болгох ийм нөхцөл байхгүй учраас энэ энийг нь ингэе ингэе ингэе гээд. Тэгээд ийм конс.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмж авах уу, дараа нь? 1 минут нэмж өгье Алтанхуяг гишүүнд.

Н.Алтанхуяг: Ийм конструктив байдлаар Улсын Их Хурал иргэдийн санал, хүсэлтэд хандмаар байна л даа. Би жаахан харамсаад байна. Би тэр 3 дахин автомашины татвар нэмсэн юман дээр бас хэлсэн шүү дээ. Одоо тэгээд л алга болсон тэр чинь. Тэгэхээр энэ татварын энэ Сайнзориг гишүүнээс гадна энэ та нар маань яг ямар зовлон учирчаад энийгээ ингээд урт цаас болгоод хувиргаад байгаа юм бэ? Энэ бол Их Хурал ажлаа хийхгүй байна. Сохор, дүлий Их Хурал юм шиг харагдаж байна. Асуудал таны энэ саяын уншсан юм чинь бид нарт тараагдаагүй. Энэ дотор маш их буруу өгүүлбэр явж байна. Төсвийн орлого тасрах гээд байгаа учраас энэ асуудал ярихгүй гэсэн утгатай. Ер нь бид нар төсвийн орлого бүрдүүлэх чинь зорилго юм уу? Ард иргэдийнхээ ахуй амьжиргаанд дарамт учруулаад байгаа тэр их олон татвар, тэр их олон хураамж, нийгмийн даатгал элдвийн юмаа янзлах чинь зөв юм уу? Нөгөө концепц чинь хүртэл ингээд буруу боллоо шүү дээ. Тэгээд л юм болохоор л иргэн буруутай.../минут дуусав./

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Алтанхуяг даргын ярьж байгаа зөв. Би тантай санал нэг байна. Яг энэ анхны нийтийн өргөлийг гаргасан хүн маань ингээд гаргачихсан юм байна лээ. Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох шаардлагатай байна. Хүмүүс байр, орон сууцаа авахдаа ихэвчлэн зээлээр авдаг. Зээлийн хүү, төлбөр төлөхдөө өөрийн цалин орлого, татварыг төлсөн мөнгөөрөө төлдөг. Мөн байр, орон сууц нь хүний анхдагч хэрэгцээ. Дэлхийн орнуудад амьдарч суугаа байшин, байр орон сууцаа зарахад татвар төлдөггүй. Учир нь энэ ашиг орлого, бизнес олох зорилго биш. Иймд 2 хувийн татварыг цуцлах бодлоготой гээд Батхүү өөрөө хэлдэг ажлын хэсэг дээр энэ санаагаа хэлж байгаа.

Гэтэл цаана нь энэ Хувь хүний орлогын албан татварын 21.2.1-ийг хүчингүй болгохоор бусад үл хөдлөх хөрөнгүүд нь яах вэ гэдэг асуудал нь дарга орхигдчихоод байгаа юм. Олон орон сууцтай буюу энийг яг ашиг олох зорилгоор буюу нөгөө ченжүүд гэдэг зүйлүүд хамрагдвал яах вэ гэдэг асуудал байгаа. Газрыг зориулалтын бусаар ашиглаад тусгай хамгаалалттай газар нутаг дээр орон сууцууд бариад, зараад байгаа үйл ажиллагаа яах вэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ бүх ингээд зүйлүүд нь бас орж ирэх гээд байгаа учраас энийг зайлшгүй бас судлах шаардлага буюу энэ өргөн хүрээнд авч үзсэн.

Дээрээс нь татварын бодлогын хувьд уялдуулаад төсөв дээр буюу орон нутгийн төсөв дээр ийм татвар 115 тэрбумаар буурах зүгээр эрсдэл байна гэдэг би зүгээр дүгнэлтдээ оруулсан болохоос биш одоо ингээд буурах гээд байгаа учраас татгалзаж байна гэж ерөөсөө яриагүй. Мөнгө угаах, санхүүжүүлэхийн эрсдэлээс бас ийм байна. Дээрээс нь яах вэ хөрөнгийн зах зээлийн эрсдэлүүд ийм байна гэдэг зүйлийг бүх талаас нь судалсан гэдэг зүйлийг л санал дүгнэлтээ уншсан.

Эцсийн шийдвэр дээр юу вэ гэхээр анхны болоод ипотекийн зээлээр авч байгаа энэ орон сууцын борлуулсан тохиолдолд татвараас хөнгөлөлт, чөлөөлөх асуудлыг нь шийд, бусад үл хөдлөх хөрөнгүүдээ борлуулбал хамаагүй шүү. Ялангуяа тэр оффисын барилга ч байдаг юм уу, бусад.

Дээрээс нь энэ татварын байгууллага, улсын бүртгэлийн байгууллага, нотариатууд мэдээлэл солилцох харилцаа бас харилцан сайнгүй байна. Зөрүүтэй байна. Reel time биш. Энэ асуудлаа шийд ээ.

Дээрээс нь яг бусад үл хөрөнгүүдээр бас авч болно. Орон сууцаас бусад тэр оффис дээр 2 хувийн татвар авах гээд. Тэгэхээр хөрөнгийн үнэлгээний маргаан гараад байгаа юм байна. Хөрөнгийг яаж үнэлэх вэ гэдэг энэ асуудлаа маш юу гэдэг юм олон улсын жишигт нийцүүлээд иргэдэд ээлтэй байдлаар шийдэж орж ир гэдэг зүйлийг хугацаатай оруулж ирж өгч байгаа Алтанхуяг дарга 4 сарын 1-ний дотор. Тэгээд таны шүүмжлээд байгаа зүйл дээр би нөгөө Дэгийн хуулиа л барьж байгаа юм дарга. Бид нарт Улсын Их Хурлын чуулганы дэгийн хуулиар нийтийн ийм өргөдөл гараад ирэх юм бол 5 хувилбар л байна. 5 хувилбарын нэг нь Засгийн газарт чиглэл өгөх хуулийн төсөл санаачилгаар.

2 дахь хувилбар нь болохоор хууль тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх. Тэгэхээр одоогоор хууль тогтоомжийг хэрэгжүүлж зөрчлийг арилга гэдэг тохиолдол энэ дээр үүсээгүй байгаа шүү дээ. 1 дүгээрт тийм байгаа.

3 дахь хувилбар нь Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах. Ийм тохиолдол бас үүсээгүй.

4 дэх хувилбар нь юу гэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1-д заасны дагуу дахиад ажлын хэсэг гаргаж хуулийн төсөл боловсруулж санал гаргах. Тэрнээс биш би дангаараа бас шийдээд явчихгүй юм байна.

Тэгэхээр тэр санал гаргахаар хууль тогтоомжийн дагуу доод тал нь дахиад 90 хоног санал авна энэ тэр гээд процессууд, ажлууд үүсчхэж байгаа юм. Тэгэхээр ийм нөхцөл байгаа.

5 дахь нь болохоор олон нутгийн хэлэлцүүлэг буюу нийтийн сонсгол зохион байгуулах. Тэгэхээр энэ 5 хувилбараас хамгийн боломжтой, түргэн шуурхай шийдэх буюу Засгийн газар Татварын багц хуулийг өргөн барих гэж байгаа. Үүнтэйгээ нэгтгээд яаралтай оруулаад ир, эс үгүй бол бие даасан байдлаар үзэл баримтлалыг нь Хууль тогтоомжийн хуулийн дагуу тодруулаад яаралтай оруулж ирээч гэдэг зүйлийг л энэ Улсын Их Хурлын тогтоолоор 4 сарын 1-ний дотор гэж хугацаатай үүрэгжүүлж өгч байгаа. Та бас нэг бүтнээр нь харвал.

Тэгээд бид хэд тал талынхаа материалуудыг авч үзлээ. Энэ Улсын Их Хурлын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Засгийн газрын байгууллагаас гадна

Санхүүгийн зохицуулах хороо нийтийн эрх зүй этгээдтэй буюу Нотариатын танхим хүртэл орж ирсэн. Энэний цаана янз бүрийн тэр эрсдэлүүдийг нь хаасан. Тэгэхдээ иргэддээ ээлтэй. Ялангуяа өргөдөл гаргагч Батхүүгийн хэлээд байгаа ипотекийн зээлээр аваад байгаа бол анхны орон сууцаа зарж байгаа хүмүүсээс 2 хувийг нь татвар авч байгааг болиулъя гэдэг үндсэн концепцыг хадгалаад, бусад харин үл хөдлөх хөрөнгүүд дээр яах вэ гэдэг асуудлыг ярьж байгаа. Гишүүд маань бас газар зүйн байршлын хувьд бас анхаараач гэсэн. Төвлөрөл их байгаа газар.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье Сайнзориг гишүүнд.

П.Сайнзориг: Далайн Батбаяр гишүүн маань хэлээд байгаа юм. Улаанбаатар хотод жишээ нь ийм татвар, энэ дэмжлэг үзүүлэх шаардлагагүй. Ялангуяа алслагдсан захын 3 дүүрэгтэй үзүүл, 21 аймгийн төвүүддээ үзүүл. Ерөөсөө л ийм зүйлийг жишээ нь ингээд ярьж байгаа. Тэгээд бид хэд ажлын хэсэгт ажилласан гишүүдийнхээ санал, энэ цуглуулсан материалын дагуу өргөдөл гаргагчийн анхны санааг алдагдуулахгүйгээр тэгэхдээ энэ асуудлыг яг бүрэн цогц байдлаар нь нэг шийдье гэхээр 20-оод хуулийн асуудлыг хөндөж байгаа. Тэгээд бид хэд бас урьдчилсан байдлаар бүх зүйлүүдийг судлаад одоо ингээд Засгийн газрын ажлын хэсэгт өгчихсөн. Энийг яаралтай Хууль тогтоомжийн хуулийн дагуу яаралтай оруулж ирээч гэдэг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд байгаа бид нарт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд л санал, дүгнэлтээ гаргаж байгаа юм Алтанхуяг даргаа. Тэрнээс биш асуудлыг хаая гэдэг ч юм уу нэг ийм зайлсхийгээд байгаа тал байхгүй шүү гэдгийг та бас зөвөөр ойлгоорой.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Алтанхуяг гишүүнд тодруулъя.

Н.Алтанхуяг: Би ер нь санааг чинь ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр Улсын Их Хурал тэр 4 сарын 1-ний дотор Сайнзориг гишүүн одоо би бол ийм ойлголттой шүү дээ. 4 сарын 1-ний дотор 2 хувийн татварыг алинаас нь авах юм, аль алинаас нь болих юм гэдэг ийм хуулийн төсөл орж ирнэ гэж ингэж ойлгож болох уу? Одоо тэр Засгийн газрын ажлын хэсэг гэдэг нь хэн юм? Яг иймэрхүү концепц санаагаар юм явж байгаа юм уу? Тэр бусад энэ дотор биччихээд байгаа юм чинь засгийн л ажил шүү дээ. Та нар ажлаа хийгээч тэр бүртгэлээ цэгцэл, давхардлаа арилга, худлаа хэлцэл хийгээд хянадаг ямар арга механизмууд байна энэ дэлхийн бүх улс орон л яг энэ замаар чинь хөгжчихсөн шүү дээ. Тэгээд хүний туршлагаасаа хэрэгтэйг нь аваад манайд нутагшуулаад жаахан шуурхай ажилламаар байгаа юм.

Би юунд жаахан дурамжхан байгаа вэ гэхээр үгүй энэ Их Хурал гэж үл мэдэх юм олигтой цугладаг ч үгүй. Цугласан тэгээд асуудал шийддэг ч үгүй хойш нь шийддэг нэг ийм л дүр зураг олон нийтэд.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хэдэн номер хариулах вэ? Хэн хариулах вэ? 6 номер. Нэр, албан тушаалыг хэлээд хариулна.

Б.Тэлмүүн: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Тэлмүүн. Бид нар өнгөрсөн хугацаанд ажлын хэсэгт орж ажилласан. Засгийн газрын зүгээс энэ өргөдөл гарахаас өмнө ч гэсэн ер нь иргэдийн орон сууцжуулалтыг дэмжих нэлээн олон арга хэмжээг, шийдвэрүүдийн төслүүдийг нөгөө зохицуулалтуудын төслүүдийг ингээд яриад явж байгаа. Тэгэхээр энэ өөрөө зөвхөн иргэд орон сууцаа зараад буюу нөхцөлөө сайжруулаад орлого олоход дэмжих үү үгүй юү гэдгээсээ илүү өргөн хүрээтэй асуудал гэж бид хараад байгаа.

Ер нь Монгол Улс орон сууцжуулалтыг дэмжих аль болох иргэдээ олон орон сууцтай болгох гэдэг энэ бодлогыг бид нар нэг талаасаа санхүүжилт талаасаа орон сууцжуулалтын банк ч гээд ярьж байгаа. Нөгөө талаасаа татварын бодлогын хувьд үл хөдлөх хөрөнгө, орон сууцтай холбоотой 4, 5 татварын асуудал яригддаг. Тэгэхээр бид нар эдгээрийг судалж байгаад ер нь бид нарын хувьд зарчмын хувьд иргэд орон сууцтай болох.../минут дуусав./

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн нэмж хариулъя.

П.Сайнзориг: Дарга бас хэлээд байгаа зөв. Энд асуудлыг тэгэхдээ бид нарт байгаа хууль, эрх зүйн орчин нь ийм байгаа. Энэ Засгийн газарт өгч байгаа чиглэл ерөнхийдөө орон сууцжуулах бодлогыг илүү их дэмжсэн байдлаар орон сууцын нөхцөлөө сайжруулах асуудлыг нь дэмжиж орж ирээч гэдэг чиглэл өгч байгаа.

Бид хэд анхны орон сууцаа авч байгаа хүмүүс дээр 6 сая төгрөг хүртэлхийг буцаан олголтыг өгч байгаа. Үүнд жилд улсын төсвөөс 180 тэрбум төгрөг зарцуулдаг юм байна. Үл хөдлөх хөрөнгөтэй байгаагийнх энэ хувьд эхний 2 орон сууцыг энэ үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлдөг юм байна. 3 дахиад нь эхлээд орон нутаг бас тодорхой хэмжээний татвар авдаг юм байна. Одоо борлуулж байгаа дээр нь яах вэ гэдэг дээрээ сая хэлээд байгаа. Ипотекийн зээлээр авсан орон сууцаа зарж байгаад чөлөөлье. Дээрээс нь анхны орон сууцаа зарж байгаа бол чөлөөлье гэдэг байгаа. Харин бусад үл хөдлөх хөрөнгүүд дээрээ ехсертон хийж орж ир, тодорхой өөр өөр зохицуулалтуудыг нь оруулж ирье гэдэг зүйлийг л энэ Засгийн газрын чиглэлээр өгч байгаа.

Тэгэхээр орон сууцыг нөгөө худалдаж авч, хадгалж эзэмшиж, өмчлөхөөсөө гадна борлуулах хүртэл энэ уялдаатай энэ харилцаан дээр нь одоо байгаа энэ татваруудын хууль, эрх.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн ажлын хэсгийн гишүүн хэнээс асуух юм? Тэгвэл дараагийнх дээр, үгэн дээр оруулъя. Үгэн дээр.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Юуны өмнө энэ Байнгын хорооны хурал ч бай, чуулган ч бай, ажлын хэсэг ч бай энэ ирцийн асуудал дээр гишүүд санаа зовж хэлцгээж байна. Тэр дээр би бас санал нэг байгаа. Мэдээж шалтгаантай бас гишүүд байгаа шүү дээ. Жишээлбэл, Оюун толгойн талаарх хэлэлцүүлэг болж байна тэнд бас зарим гишүүд маань орчихсон байгаа гэх мэт.

Энд маш чухал асуудал дээр богино хугацаанд ажиллах ажлын хэсэг гарсан. Гэхдээ бид нар бас нэг хугацаа алдсан зүйл байгааг ажлын хэсэгт оруулчихсаны хувьд хэлэх хэрэгтэй. Тэр нь юу вэ гэхээр нөгөө Монгол Ардын намын дотоод хямрал тэр нь эргээд чуулган бусад байдалд нөлөөлсөн шүү. Тэр учраас бид нар бас цаг алдсан. Ирц бүрдэхгүй байсан ийм явдлууд бий.

2 дугаарт би бас энэ улсын иргэн хүнийхээ хувьд энэ борлуулалтын 2 хувийн хөнгөлөлт, чөлөөлөлт дээр бас Батхүү хуульчийг ер нь дэмжсэн. Тэгээд ингээд судлаад энэ дэд ажлын хэсгийнхнийхээ танилцуулга энэ тэрийг сонсоод явж байхад тэгээд одоо энэ хууль, эрх зүйн орчныхоо хүрээнд энэ ажлын хэсгийн ахлагч Сайнзориг гишүүний саяын уншсан тогтоолын төсөл гарч байгаа юм шүү. Тэгэхээр хамгийн боломжит дээд хэмжээндээ дэмжиж байна гэсэн үг.

Өөрөөр хэлэх юм бол цаг хугацаа алдахгүйн тулд энэ асуудлыг цаашид хууль, эрх зүйн орчинд бүрэн хэмжээнд шийдэхийн тулд Засгийн газарт ийм чиглэл өгч байгаа. Ер нь энэ үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, үнэлгээний асуудал дээр ч бас анхаарах ёстой энэ чиглэл хүртэл орчихсон байгаа шүү дээ. Тэгээд анх удаагаа орон сууц авч байгаа иргэдээ энэ борлуулалтын 2 хувийн татвараас чөлөөлөх энэ тэр гээд чиглэл орчихсон байгааг бас зориуд хэлэх нь зүйтэй байх.

Тэгэхгүй бол Монголд нэг аюул байна. Аливаа зөвхөн сонгогч иргэдэд таалагдахын төлөө биш аливаа бүх төрлийн асуудалд ялангуяа судалгаа, нотолгоотой, статистик тоо баримттай хандах гэхээр дандаа нэг зүг рүү чулууддаг, шиддэг. Тэгэхээр нөгөө яг ажил хийх ийм боломж, бололцоо харьцангуй багасчих гээд байна шүү.

Жишээлбэл, нийгэмд юу асууж байна гэхээр нэг талдаа төсвийн орлого 2 их наяд гэж ярьж байсан. Одоо бараг 3 их наяд руу орж байна. Төсвийн орлого бүрдэхгүй байна гээд.

Гэтэл нөгөө талдаа зарим нэг намуудаас Татварын өршөөлийн хууль гаргахаар ажиллаж байгаа гээд ингээд одоо нөгөө цалин энээ тэрээ нэмнэ гэхихээр зах зээл дээр хүлээлт үүсээд эргээд нөгөө хэрэглээний үнийн индекс буюу нөгөө инфляцыг өсөхөд нөлөөлчихдөг. Тэгэхээр энэ байдал өөрөө эргээд бид нар бүгд энэ улсын иргэн шүү дээ. Их Хурлын гишүүн нь байна уу, Сангийн яамных нь байна уу, хэн байна уу бүгд нэг завин дээр бий буюу нэг эх оронд амьдарч байгаа. Бүгд л мөнгөний үнэ цэн унавал, инфляц өсвөл бүгд л хохирно шүү дээ. Бүх айл өрх бүгд л цалингаараа, орлогоор амьдарч байгаа шүү дээ.

Тэгэхээр аливаа юманд нэг ийм ул суурьтай ханддаг энэ хандлага, төлөвшлийг Их Хурлын гишүүдээсээ эхэлмээр байна. Тэгэхгүй бол Их Хурлын гишүүний ажлыг зөвхөн нөгөө улс төрийн оноо авах талаасаа явчихаар улс эх орон чинь бас хэцүүдчих гээд байна шүү. Тэгэхээр миний төр оршихуй доор татвар байна гээд нэг ийм үг байна шүү дээ. Татвар төлж байгаа хүмүүстээ бизнесийн таатай, шударга орчныг л бүрдүүлэх ёстой. Тэр нь өөрөө тэгш шударга үйлчлэх ёстой.

Нэг хэсэг нь танил талтай, улс төрч танилтай гээд чөлөөлөгдөөд нөгөө хэсэг нь шударга зарчмаа бариад төлөөд яваад хохироод байвал энэ чинь өөрөө эргээд зах зээлийг доргиож байна.

2 дугаарт, засаглал сайн байх хэрэгтэй байна тухайн улсын. Сайн засаглалтай байх ёстой, аливаа шийдэл, гүйцэтгэл ил тод байх ёстой, авлига, хээл хахуулиас ангид байх ёстой гээд энэ олон асуудлаа бид нар цогцоор нь ярьж сурахгүй бол миний хувьд улс төр болон энэ бодлого хоёр тэнцвэртэй зөв оршин тогтнохгүй бол цаашдаа энэ улсын нөхцөл байдал хэцүүдэх вий гэдэг дээр санаа зовоод явж байгаа ийм хүн учраас ингээд базаад ийм үг хэлчихье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Баярлалаа. Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Би тэгээд ажлын хэсгээ ахалсан учраас гишүүддээ бас энэ санал, дүгнэлтийг хүлээж авч, дараагийн удаа дараагийн 2 дугаар асуудал дээр хэлэлцэх “Засгийн газарт чиглэл өгөх” энэ тогтоолыг бас яаралтай бас Байнгын хорооноос дэмжээд чуулганаар Наранбаатар даргыг бас энэ 7 хоногт Даргын зөвлөл дээр хэлэлцүүлээд оруулж өгөөч ээ.

Бидэнд байгаа хууль, эрх зүйн орчин нь сар бүрийн сүүлийн 7 хоногийн чуулганы хуралдаанаар нийтийн өргөдлийг хэлэлцэнэ гээд хэлчихсэн юм байна. Тэгэхээр энэ 26, 27-ны чуулган болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ бас зүйлүүдийг хоёр 7 хоног ч гэсэн хэмнээд явъя. Сая Мөнхсоёлын хэлж байгаа дээр яах вэ зарим нэг зүйлүүд бодитой. Яг энэ өргөдлийг гарсантай холбоотойгоор улсын төсвүүд явж байсан, үндсэн чиглэлүүд ийм зэрэг асуудлаас болоод ажлын хэсэгт ажиллаж байгаа гишүүд маань төсөв дээр ажиллаж байсан ч юм уу, зарим нэг ийм хоёр 7 хоног энэ тэр бас ирц бүрдэх, бүрдэхгүй тохиолдлууд байсан. Тэгээд энэ Улсын Их Хурал буюу байгуулж, Байнгын хорооноос байгуулсан энэ нийтийн өргөдлийг авч хэлэлцэж байгаа хэлтэс, ажлын хэсэг маань 5 хувилбараас 1-ийг нь л сонгох ёстой.

Тэгэхээр энэ 5 хувилбарын хамгийн оновчтой гэж ярьж болох холбогдох бодлогын бичиг баримт, хууль тогтоолын төслийг боловсруулахаасаа Засгийн газарт саналыг нь л хүргүүлж байгаа юм. Тэгээд бид нар маш тодорхой асуудлуудаар Засгийн газарт хүргүүлж байгаа. Энэ дээрээс улсын төсөвт буюу орон нутгийн төсөвт учруулж нөлөөлөх 115 тэрбумыг яах вэ, мөнгө угаах терроризмоос эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд бас тодорхой ийм асуудлуудыг ер нь энэ төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээд болох Нотариатын танхим, магадгүй энэ бас чиглэл дээр тодорхой хэмжээний хяналтыг бас тавьж орж ирж байгаа Санхүүгийн зохицуулах хороо ч гэдэг юм уу энэ үйл ажиллагаануудыг уялдуулж, мэдээлэл солилцох энэ асуудал нь бас иргэдийн энэ өдөр тутмын үйл ажиллагаанд бас дэмжлэг үзүүлэх юм байна лээ. Хөнгөлөх юм байна лээ.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг нэг ултай суурьтай бас бүрэн шийдчихье гэдэг байдлаар бас ингэж санал, дүгнэлтийг боловсруулж Улсын Их Хуралд бас оруулж ирж байгаа гэдэг зүйлийг хэлэлцүүлээд Засгийн газарт яаралтай чиглэл өгье гэж орж ирж байгаа шүү гэдэг зүйлийг бас дахин нэг товчхон хэлье. Тэгээд бас та бүхнийг бас дэмжиж өгөхийг хүсье ээ.

Н.Наранбаатар: 1 гишүүн үг хэлсний дараа санал хураалттай учраас гишүүд танхимдаа орж ирээрэй. Одоо Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: 1 дүгээр асуудал, энэ Улсын Их Хурлын үйл ажиллагаа гэдэг юм жаахан буруу л яваад байна даа. Хэн энэ манай Байнгын хороо, бусад Байнгын хороо ч гэсэн материал гэдэг юм ерөөсөө өгөхгүй байх юм. Энэ Сайнзориг гишүүн та дараа нь бид нар асуудалд орж мэднэ шүү дээ. Сайнзориг оо энэ та нар жишээлэх юм бол таны сая уншсан юм чинь албажиж тараагдсан юм уу? Би асуулт асууж байгаа юм биш. Би зүгээр танд анхааруулга өгч байгаа юм. Албажиж тараагдсан юм уу, үгүй юм уу? Одоо би энийг чинь тэндээс очиж авч үзлээ шүү дээ. Ингээд л асуудал болно л доо. Ажлын хэсгийн гишүүд чинь гарын үсгээ зурсан, зураагүй, албажсан, албажаагүй, тийм цаас оруулж ирж ярьсан гээд

энэ Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагаа гэж нэг юм байдаг юм л даа. Тэр маань сүүлийн үед ер нь л жаахан замбараагүй алдагдаж байна л даа. Өчигдөр бас Хууль зүйн байнгын хороон дээр ингээд л Засгийн газрын алдааг засдаг байгууллага Улсын Их Хурал ч бас биш л дээ гэх мэтчилэн би энийг бас жаахан хэдэн оймс илүү элээсний хувьд хэлэхгүй бол арай жаахан замбараа алдаж байна.

Наранбаатар дарга та бас анхаар. Наранбаатар даргын буруу байхгүй л дээ. Манай Тамгын газрынхан энэ хууль номынхоо дагуу энэ асуудлуудаа, цааснуудаа яг зөв, зохистой оруулахгүй бол дараа нь маргаан үүсээд тэгээд бид нарын нөгөө баахан ярьсан хурал чинь хүчингүй болж, цаас чинь хүчингүй болж мэдэх байна шүү.

Би энийг ингэлээ Сайнзориг оо, Сайнзориг гишүүн ээ энэ Засгийн газрын тэр хариуцлагатай ажлын хэсэг нь байгаа юм байна. 4 сарын 1 гэхэд энэ 2 хувийн татварын асуудлыг нэг мөр болгож, ард иргэдэд ойлгомжтой тийм хуулийн төсөл орж ирэх юм байна. Зөвхөн 2 хувийн татвар биш үл хөдлөх борлуулсны. Ер нь энэ орон сууцжуулахтай холбоотой их л сайхан цаас, хууль орж ирэх юм байна гэж ойлгож байна.

Ер нь тэгэхдээ сонгуульд амлаж баахан юм амлаж гарчхаад хугацаа чинь дуусаж өгнө шүү. Нөхдүүд жаахан ажил хий л дээ. Одоо юмаа сайжруулж оруулж ирээд гийгүүлнэ гэдэгт би жаахан эргэлзэж л байна. Одоо тэгэхдээ яая гэх вэ. Сая сардаа нэг удаа ярьдаг юм гээд ингээд хэлчхэв үү дээ Сайнзориг гишүүн. Тэгэхлээр энийг чинь би гараа өргөх гэхээр одоо энэ чинь албажаагүй юм оруулж ирсэн учраас хүндрэл учирч байна. Та нар тэгээд саналаа хураахдаа анхаараарай.

Тэгээд ер нь 4 сарын 1 гэхэд би ард иргэдэд ойлгомжтой хэлж байна шүү. Энэ 2 хувийн татвар чинь болсонгүй биш болгох талаас нь яриад, зөв болгох талаас нь яриад 4 сарын 1 гэхэд мундаг хууль оруулж ирээд батална гэж ингэж ойлголоо шүү.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Төсвийн байнгын хорооны 25 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод ноогдуулах албан татварын асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

2 дахь асуудалдаа орно.

13.04 цаг

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох асуудлаар гаргасан нийтийн өргөдлийн дагуу хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод

ноогдуулах албан татварыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.5.2-т заасныг үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан ирүүлснийг та бүхэнд тараасан.

Өмнөх асуудалд оролцсон ажлын хэсэг хэвээрээ.

Тогтоолын төслийг тарааж өгсөн. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүн байна уу? Нэрсээ өгье.

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар дэмжигдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч П.Сайнзориг танилцуулна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

3 дахь асуудалдаа оръё.

13.06 цаг

“Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Занабазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий

аудитораас Төрийн аудитын байгууллагын 2026 онд хуулийн дагуу болон бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийг батлуулахаар ирүүлснийг Байнгын хорооны гишүүдэд цаасаар болон цахимаар хүргүүлсэн байгаа.

Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Үндэсний аудитын газраас 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг боловсруулан Төсвийн байнгын хороонд хүргүүлж, та бүхэнд танилцуулж байна.

Аудитын сэдвийг боловсруулахдаа улсын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, төрийн санхүү, төсвийн хөрөнгийн хяналтыг сайжруулах, энэ үйл ажиллагаанд гарах эрсдэлийг тодорхойлон түүнийг бууруулах, иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, аудитын үр дүнгээр иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор хэд хэдэн эх сурвалжаас ирүүлсэн санал, өөрсдийн цуглуулсан мэдээлэл зэргийг үндэслэн боловсрууллаа.

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу тухайн сэдвээр урьдчилсан судалгаа тооцоолол хийгдсэн байх, төсөв санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхтай байх, иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн, зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх, төрийн аудитын байгууллагын аудитын сэдэвт санал авах хугацаанд иргэд, олон нийтээс ирүүлсэн санал зэргийг харгалзан үзлээ.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу хуулиар болон бодлогоор гүйцэтгэх, мөн өмнөх оноос үргэлжлүүлэн гүйцэтгэх зэрэг 27 сэдвийг судалж ийнхүү танилцуулж байна.

Энэ дотор хуулийн дагуу гүйцэтгэх 16, төрийн аудитын бодлогоор гүйцэтгэх 9, өмнөх оноос үргэлжлүүлэн он дамжин хэрэгжих 2, нийт 27 сэдвийг ийнхүү танилцуулж байна.

Санхүүгийн аудитын хуулиар хэрэгжүүлэх сэдвийн хүрээнд санхүүгийн аудитын голчлон сэдвүүд байгаа. Энэ сэдэв нь болохоор зэрэг нийтдээ 16 сэдэв нь Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хугацаатай, цаглаварт хугацаатай ийм сэдвүүд байгаа.

Үүнийг бид нар 16 сэдвээр багцалж, танилцуулж байгаа. Бодлогоор гүйцэтгэх сэдвийн тухайд бид нийтдээ 9 сэдвийг танилцуулж байгаа. Энэ сэдвүүдийг бид санал авахад 37 санал ирсэн. Үндэсний аудитын газар болоод бусад төрийн аудитын байгууллагуудын нийлсэн 20 санал, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын байгууллагаас 5 санал, иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн санал, хүсэлтээс 1 санал, E-Mongolia платформд ирсэн саналаас 11 санал ирсэн.

Эдгээрээс бид нар үнэлгээ хийж үзээд 10 саналыг сонгосон. Ингээд нийтдээ 27 сэдвийг та бүхэнд танилцуулж байна. Бусад үлдсэн сэдвүүдийг бид нар сэдвийн нөөцөд үнэлж авсан байгаа.

Тухайлан энэ дотроос авч үзэх юм бол төрийн мэдээллийн нэгдсэн систем E-Mongolia платформоор ирсэн саналаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэгж хувьцаанд олгосон ноогдол ашгийн хуваарилалт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийхээр эхний ээлжид авч үзсэн.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн саналаас голчлон халаалт, ус, дулаан, орон сууцтай холбоотой, цахилгаан хангамжтай холбоотой ийм асуудлууд байсан учраас нэгтгэж үзээд Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчдийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн сэдвээр авсан.

Мөн бид нар энэ удаа Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал сэдвийг бид нар энэ урьдчилсан аудитын сэдвийн хүрээнд энэ жилээс анх удаа ингэж тусгаж оруулж байгаа.

Мөн зарим гишүүдийн санал тухайлбал, Уур амьсгалын олон улсын болон хоёр талт Даян дэлхийн байгаль орчны сангуудын зарцуулалт, Монгол Улсын төлөөлөх эрх, үүрэг, шийдвэрийн хэрэгжилт гэсэн сэдвийг авсан.

Засгийн газраас агаар, орчныг бууруулах чиглэлээр 21-ээс 24 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг бид нар энэ жилийн нөөц боломжийг хүрэлцээгүйн улмаас 25 оны сэдвээс хасаад 26 оны сэдэвт оруулахаар дараагийн хэлэлцэх асуудалд оруулсан байгаа. Энэ саналаа бид нар 10 сарын 17-нд Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байгаа.

Сонгосон сэдвийн хүрээнд сэдэв бүрээр судалгаа, танилцуулга бэлтгэж, холбогдох мэдээллийг Үндэсний аудитын газрын хэмжээнд ярьж, нягталсны үндсэн дээр энэ сэдвүүдийг өнөөдөр танилцуулж байгаа юм.

Аудитыг гүйцэтгэхэд гол асуудал бол хүн хүчний нөөц, төсөв хөрөнгийн нөөц, цаг хугацааны болоод бусад хүчин зүйлийг харгалзан үзэх зайлшгүй шаардлага байгаа. Энэ асуудлуудыг бид гишүүдийн асуултын хариултын явцад тодорхой тодруулж хэлэх ийм зүйлүүд байгаа.

Тухайлах юм бол бид нар энэ дипломат төлөөлөгчийн газруудад явж шалгалт, хяналт хийх ёстой. Гэтэл үүнийгээ бид нар энийг хийж чадахгүй байдалд хүрсэн гээд бас олон асуудлуудыг хэлж болохоор байгаа юм.

Ингээд энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг гишүүдээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэнд баярлалаа.

Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулга болон аудитын сэдэвтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгье.

Алтанхуяг гишүүнээр, Батсуурь гишүүнээр тасаллаа. Мэндсайхан гишүүн.

З.Мэндсайхан: Энэ 26 онд гүйцэтгэх аудитын сэдвийг батлах тухай тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгэхээр ер нь энэ төрийн өмчит үйлдвэрүүд ашиггүй байна, төрийн өмчит үйлдвэрүүд маш хэмнэлтгүй байна. Ингээд улсын төсөв рүү татвар төлөлтөд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй ийм хулгай зэлгээний газар болж хувирлаа гэж яриад байгаа. Тэгээд үүний нэг жишээ танай энэ 2025 оны 3 сарын 14-нд Үндэсний аудитын газраас гаргасан шаардлага байна л даа. Дархан руу Хүнс, хөдөө аж ахуйн яамыг шилжүүлэхтэй холбоотой зардал тухайн үед гараад явсан. Үүнтэй холбоотойгоор Хөдөө аж ахуйн бирж гэж компанийн хуримтлагдсан ашгаас Хөдөө аж ахуйн яамны 45 хүнд, тэр агентлагийнх нь 7 хүн гээд нийтдээ 52 хүнд 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, орон сууцын урьдчилгааг өгсөн байна.

Тэгээд энийг 9 сарын гэхэд энэ зөрчлийг арилгах ёстой гэдэг ийм даалгавар гарсан. Тэгээд энэ танайх ийм даалгавар гаргаад шалгалтынхаа энэ өгсөн үүрэг, биелэлт нь ер нь хэрхэн хангадаг юм бэ? ТӨК-ийн хуримтлагдсан ашгаас ажилчдадаа орон сууц авч өгөөд ингээд байж байдаг энэ асуудал дээр та бүгд маань ямар байр суурьтай байдаг юм? Энэ дүгнэлт, гаргасан энэ зөвлөмж чинь хэрэгжиж байгаа юу? Тэр нэг биржийн захирлын гаргаад байгаа шийдвэр биш шүү дээ. Энэ Ж.Энхбаярын гаргасан сайдынх нь гаргасан шийдвэр байгаа шүү дээ. Тэгээд сайдад нь тухайн үед та нар ямар зөвлөмж өгч байсан юм? Энэ асуудал ер нь хэрхэн шийдэгдсэн юм? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон. Магнайцэрэн дарга.

С.Магнайсүрэн: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчит үйлдвэрийн газруудын тухайд бид 23 онд энэ үр ашиг, засаглалыг сайжруулах чиглэлээр аудит сэдвээр ороод ингээд гүйцэтгэлийн аудит ороод үр дүнгээ Байнгын хороодод ирүүлээд хэлэлцүүлсэн, ирүүлсэн ийм аудит хийж гүйцэтгэсэн учраас энэ удаад сэдэвт ороогүй.

Ер нь бүх төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн аудит манай нөгөө цаглаварт хугацаагаар жил болгон төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүрээнд хийгдэж байгаа.

Дархантай, Дарханы биржтэй холбоотой асуудлаар манай өгсөн 3.1 тэрбум төгрөгийн албан шаардлага энэ аудитын шийдвэртэй холбоотой асуудлаар хэлэхэд одоо манайх ингээд завсрын аудит ороод 12 сарын 15 гэхэд бид тайлан, үр дүнгээ нэгтгэдэг. Энэ хүрээнд энэ биелэлтүүд яаж гарч ирсэн бэ гэдэг 1 дүгээрт гарч ирнэ.

2 дугаарт, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг заавал хангах ёстой. Хэрвээ энийг хангахгүй бол дараагийн шатын арга хэмжээнүүд буюу сахилгын арга, хэмжээ ажлаас чөлөөлөхтэй холбоотой бүүр цаашлаад яавал нөгөө хууль хяналтын байгууллагад шалгуулахад хүрэх ийм үр дагавартай учраас энэ заавал биелэгдэх чанартай. Бид бол энэ асуудлыг энэ 12 сарын 15 гээд завсрын аудитын дүнгээр танд тусгайлаад энэ асуудлаар танилцуулга, мэдээлэл өгөх бололцоотой. Одоогоор аудит хийгдэж байгаа гэж ийм товч хариулт өгье.

Н.Наранбаатар: Мэндсайхан гишүүн тодруулъя.

3.Мэндсайхан: Үгүй ээ энийг хуулийн байгууллагад өгөх ёстой шүү дээ. Тэр Хөдөө аж ахуйн биржийн захирал хуримтлагдсан ашгаараа яамны ажилчдад байр авч өгдөг тийм сэтгэл байхгүй шүү дээ. Тийм сайхан сэтгэл буюу шоронд явах үйлдлийг хийхгүй шүү дээ. Наана чинь сайд нь хийлгэж байгаа шүү дээ. Тэгээд тэр дээр нь та нар яагаад зөвлөмж өгдөггүй юм? Ямар шийдвэрээрм тэр Биржийн захирал тийм шийдвэр гаргадаг юм? Хөдөө аж ахуйн биржийн захирал, Хөдөө аж ахуйн яам, ЖДҮ-лэлийн агентлагийн хүмүүст байр авч өгөх шийдвэр гаргаад явж байдаг ийм зүй тогтол байх уу? Үгүй тэгээд тэр даргыг хуулийн байгууллагад өгөх асуудал биш шүү дээ наадах чинь. Шийдвэр нь хаанаас эх үүсвэр нь гарсан юм гэдгийг нь та нар яагаад тогтоодоггүй юм бэ?

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 5 номер хариулья.

С.Магнайсүрэн: Сайдын багцад нь Үндэсний аудитын газраас хязгаарлалттай дүгнэлт өгсөн байдаг. Тухайн зөрчил дээр албан шаардлага өгөөд одоо энэний биелэлтийг бид ингээд нэгтгэж биелэлтийг нь тооцохоор завсрын аудит орсон байгаа. Тэгээд энэ асуудлын биелэлтийг би тусгайлан танд танилцуулья.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Танай дүгнэлтээр 145 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудит хийгээд 31.3 хувь нь үндэслэлгүй гэж дүгнэсэн байна шүү дээ тайланд. Өөрөөр хэлэх юм бол захиалагчаас ирүүлсэн.../минут дуусав./

Н.Наранбаатар: Энэ өөр асуудал яриад байна дараагийн асуудал. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ нийслэлийн төсөв гэдэг асуудалд аудит хийдэг үү? Нийслэл, Монгол Улсын Засгийн газар хоёрын ажлын уялдаа, холбоо гэж бас л алд дэлэм зөрдөг. Нөгөө Тавантолгойн төмөр зам хэдэн метр зөрчихсөн гэдэг шиг л ийм зөрүүтэй ажлууд сүүлдээ болж хувираад байна. Ганцхан жишээ нь нийслэл метро барина л гэх юм, хурдны зам барина л гэх юм.

Гэтэл энэ Эмээлтээс авхуулаад Зам, тээврийн яам чинь энэ төмөр замыг хотоосоо гаргаад урдуураа шийдчихээд байтал дахиад нийслэл чинь Туул гол дээгүүрээ зам тавина гээд байх юм. Энэ төмөр замын вокзал энэ төмөр зам дагасан замууд тэр чигээрээ сулраад гараад ирчих л юм шиг санагдаад байх юм. Байгаа нөөц бололцоогоо зөв ашиглахгүй Засгийн газар нь шал өөр юм ярьдаг, нийслэл нь шал өөр юм ярьдаг. Үр дүнд нь 2.7 их наяд төгрөгөөр нийслэл хурдны зам гэдэг юм Туул гол дээгүүр байна шүү дээ бүүр барьж тоглох гээд байх юм. Энэ дээр аудит хийх үү? Энэ дээр хийвэл хийгээд эртхэн шиг Засгийн газарт энэ нийслэлийн ажил хөдлөөд мөнгө төгрөгөө үрж барахаас нь өмнө асуудлаа шийдмээр байна гэдэг нэг ийм асуудал байна.

2 дугаарт нь энэ зээлийн хүүг бууруулах бодлого, стратегийн үр дүн гэсэн асуудал бас нэлээн хожуу яригдаад байна. Гэтэл бид нарт одоо юу хэрэгтэй байна? Хувийн хэвшил, бизнесийнхэнд зээл хэрэгтэй байна. Зээл маш өндөр хүүтэй байна. Энийг бууруулах чиглэлд та нар ажиллана гэж байгаа юм бол одоо,

өнөөдөр ажиллаж эхлээд 2026 он гарангуут үр дүнгээ танилцуулаад явахгүй бол 2026 оны 9 сараас 12 сарын хооронд хийнэ гэхээр зээлийн хүүг бууруулах стратеги төлөвлөгөө, бодлого гэдэг юм үндсэндээ дахиад нэг жилээр хүлээхээр л юм шиг ойлгогдоод байна.

Ер нь хариуцлагын асуудал ерөөсөө хангалтгүй байгаад байгаа юм. 2024 оны аудитын гүйцэтгэл орж ирж байхад бас л ярьж байсан 120 их наядын хөрөнгийг Монгол Улсын Засгийн газар төсөв болон төсөвт төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулж эргэлдүүлээд 12-оос 15 их наяд төгрөгийн алдаа, дутагдал гарчхаад байхад хэн ч ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тэр аяараа хулгай, тэр аяараа авлига. Гааль тэр аяараа авлига, татвар тэр аяараа авлига. Хэдэн дарга нар баяждаг энэ цагаан байраар дүүрэн дарга нар баяжаад л хоцроод байдаг. Хувийн хэвшил чинь тэр чигээрээ ядууралд өртөөд татварынхаа дарамтад сөгдөж унаад байхад энэ хариуцлагын асуудлыг та нар яагаад сөхөж орж ирэхгүй байгаа юм бэ? Сая Мэндсайхан гишүүн энд нэгээс нь, зах зухаас нь ярьчхаад гараад явчихлаа. Хариуцлага ерөөсөө үр дүнд хүрэхгүй байна. Энэ чиглэлдээ түлхүү анхаарч ажилламаар байна гэдэг бас нэг та хэдийн саналыг авмаар байна.

Дээрээс нь энэ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн сэдвийг энэ асуудал дээр нэмж оруулах ийм саналтай байгаа. Энэ дээр Төсвийн байнгын хорооны дарга хариулах уу аудит хариулах уу?

Н.Наранбаатар: 5 номерын микрофон Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Нийслэлийн төсөвтэй холбоотой манайх төсвийг нь батлахад дүгнэлт өгч байгаа. Мөн санхүүгийн аудитаа цаглаварт хугацаанд Нийслэлийн Аудитын газар энэ дээр хариуцаж бүрэн ажилладаг. Таны хэлсэн энэ Туулын хурдны замын асуудлыг бид нар энэ сэдэвтээ оруулчихсан байгаа. Тэгэхдээ эхлээгүй ажил ч гэсэн бид урьдчилсан аудитыг хийж эхэлье гэдгээр энэ жил анхны урьдчилсан аудитын сэдэвт энэ Туулын хурдны зам 679 сая доллар байсан байх аа энэ 32км замын энэ асуудлыг энэ ТЭЗҮ-гээс нь эхлээд энэ зураг төслөөс нь авхуулаад ингээд ямар ч байсан хийж эхлэх нь зүйтэй гэж үзээд энэ жил бид нар урьдчилсан аудитын сэдэвт анх нэг сэдэв орсон нь энэ сэдэв байгаа.

Хариуцлагын асуудал дээр бид онцгойлон анхаарч ажиллаж байгаа. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар гэж манайх тусдаа зохион байгуулалтын ийм бүтцийн нэгжтэй болсон. Энэ бол олон улсын аудитын дээд байгууллагаас өгсөн зөвлөмж, зарчмын дагуу энэ бол ийм зайлшгүй хийгдэх ёстой шийдэл байсан. Бид ингээд үндсэндээ 10 хэдэн оноос хойших бүх хариуцлагын шийдлүүдээ гаргаж үзээд өнөөдөр бид нарт 3 мянга орчим биелэгдээгүй ийм шийдвэртэй үлдсэн. Энэ дотор хамгийн том нь гэмт хэргийн чанартай ийм асуудлууд хууль хяналтын байгууллагаас шилжсэн асуудал хэрхэн шийдвэрлэгдэж вэ, дээр нь сахилгын арга хэмжээ буюу ажлаас халах ийм шийдвэрүүд хэрхэн хэрэгжиж вэ гээд бүгдийг нь нэг бүрчлэн гаргаад одоо бид нар энэ завсрын аудитаар тойроод бүх хэрэгжилтийг нь гаргаж ирж 12 сарын 15 гэхэд нэгтгэж танилцуулна.

2 дугаарт, Төсвийн байнгын хороонд би өчигдөр Төсвийн байнгын хорооны даргад танилцуулсан энэ Үндэсний аудитын газрын хийж байгаа бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт болон цаашид хийх ажил, хараат бус байдал, тэгээд энэ аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр би танилцуулга бэлтгэсэн. Ойрын хугацаанд би Төсвийн байнгын хороонд тусгайлан гишүүддээ танилцуулъя гэж ингэж төлөвлөж ярьсан.

Яагаад гэвэл урьд нь бас Төсвийн байнгын хороон дээр ийм асуудал оруулж ирүүл гэсэн. Бид нар бас зарим Эрүүгийн хууль болоод Шүүхийн шийдвэр гүйцэтгэл зарим хууль дээр энэ аудитын шийдвэртэй холбоотой зарим өөрчлөлтүүд бэлэн болгосон байгаагаа. Та бүхэнд танилцуулна гэж ингэж тооцоолж энэ хариуцлагын асуудлуудыг хууль номын хүрээнд заавал шийдэгддэг байхаар асуудал ингээд бэлтгэж танилцуулахаар бэлдсэн байгаа гэдгийг хэлье.

ЖДҮ-тэй холбоотой асуудал дээр бид нар сэдэв хийгээд энэ 11 сарын 15-нд гүйцэтгэлээр тайланг хийгээд энд ирүүлчихсэн байгаа. ЖДҮ-ийн сангаар. Тэгэхээр Төсвийн байнгын хорооноос энэ тодорхой хугацаанд төлөвлөөд энэ асуудал хэлэлцэгдчих тэр хүрээнд тодорхой яригдах ийм асуудлууд байгаа. Сэдвээр хийгээд тайлангаа ирүүлчихсэн байгаа. Зээлийн хүүг бууруулах стратегитай холбоотой асуудлыг энэ удаа бид нар энэ сэдэв рүүгээ хөндөж оруулж ирээгүй байгаа. Ирүүлсэн саналынхаа хүрээнд бид нар судалгаа, тооцоолол хийж үзээд энэ бодлогоор 9 сэдвийг сонгосон байгаа.

Н.Наранбаатар: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Энэ аудитын сэдэв батлах энэ асуудал дээр бас яг Төсвийн байнгын хорооны гишүүд бас идэвхтэй оролцох зайлшгүй шаардлагатай байх. Энд яг хоосон улс төржихгүйгээр бас бодит мэдээлэл дээр дүгнэлт өгөөд цаашдаа яах вэ гэдэг зөвлөмж ерөнхийдөө гардаг гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ бас жоохон ач холбогдол өгье. Би ер нь аудитын сэдэв дотор бас уг нь зах зээлийн зарчмаар явж байгаа энэ асуудал энэ тэрийг орох дэмий л гэж бодож байгаа юм. Энэ зээлийн хүүг бууруулах бодлого, стратеги, хэрэгжилт, үр дүн гээд энэ бүүр ингээд мөнхийн сэдэв боллоо. Яг эцсийн дүндээ энэ дээр аудит хийгээд нэг их тийм тоймтой юм гарахгүй. Зүгээр бизнесийн хууль, эрх зүйн орчин яаж сайжирч байгаа вэ гэдэг ерөнхий л юм цаана нь яригддаг юм шүү дээ. Тэгээд ингээд эрэлт, нийлүүлэлт бол мөнгөний үнэ ханшаасаа шалтгаалж байгаа юмыг ингээд л их сүр бадруулаад л ингээд л аудитын сэдэв дээр бодлогын хувьд бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвүүд дотор орж байгаа байхгүй юу. Энэ их тийм үндэсний аудитын байгууллага энэ тэрд нэг их шаардлагатай юу, үгүй юу.

2 дугаарт ингээд баригдаагүй төслүүдийг ингээд аудит урьдчилсан хийнэ гээд. Энэ ингээд буруу зүг рүүгээ явж мэднэ шүү. Сүүлдээ энэ том төслүүдийг хэрэгжүүлэхгүй байх. Тэгээд гишүүд маань нэг зүйлийг ойлго. Улсын төсвөөр хийх ажил, орон нутгийн төсвөөр хийх ажил чинь бас ялгамжтай байгаа.

2 дугаарт, энэ Засгийн газар буюу яамнууд юу хийх вэ, орон нутаг юу хийх вэ гэдэг чиг нь хууль тогтоомжоор зааглачихсан. Тэгээд бид хэдийн хандлага болохоор энэ Улсын Их Хурал дээр л аливаа зүйлүүдийг төвлөрүүлж шийдэх гээд л эндээс л ярилцахгүй бол бүгдийг нь дэмжихгүй гээд. Энэ чинь орон нутгууд чинь бас өөрт оногдсон чиг үүргийнх нь дагуу ажлуудаа хийж байгаа шүү дээ. Нэг ийм зүйлийг би бас зайлшгүй хэлмээр байна.

Тэгэхээр энэ Туулын хурдны зам дээр чинь ингээд хэрэгжиж байгаа юм дээр тендер зарлах гэж байгаа юм дээр одоо ингээд наа нь баахан бужигнуулж хаях вий дээ. Энэ чинь. мэргэжлийн байгууллагууд нь яагаад зураг төсвийг нь батлаад явуулж байгаа шүү дээ. Энэ тэгээд бас зөв зүйл үү үгүй юу мэдэхгүй байна.

2 дугаарт, би Магнайсүрэн даргыг болон энэ аудитыг юу хэлж байна гэхээр энэ Газрын хууль тогтоомжийн нийцлийг энэ сэдэв болгож оруулмаар байна. Энэ Газрын хууль гэдэг чинь Монгол Улсын төрийн байгууламжийн үед нэгдмэл байх эдийн засгийн суурь капитал байхгүй юу. Энэ өөрөө эргээд эдийн засаг болон төрийн аюулгүй байдал энэ тэрийг дэмжиж байгаа юм байгаа юм уу? Энэ мал аж ахуй байдаг юм уу, аялал жуулчлал, уул уурхай бүх юм чинь энэнээсээ уялдаад ингээд гацчихаад байна. Энэ дээр сэдэв болгож оруулмаар байна.

Монголбанкны бүтэц, тэр дундаа хүний нөөцийн асуудлыг сэдэв болгож оруулмаар байна Энэ бүтцээ одоо аль ч төрийн институцээр батлуулдаггүй ганц байгууллага. Би нэг хавар асуудлуудыг хөндсөн чинь бүх ажилчдадаа мэдэгдэл өгсөн байгаа байхгүй юу. Чөлөөлнө гээд. Тэгэхдээ 1-ийг ч чөлөөлөөгүй. Ингэж даапаалж болдог юм уу? Гишүүд нэг юм ярихаар ингээд нэхэж магадгүй гэнгүүтээ бүх ажилчдадаа чөлөөлөх хуудас өгсөн байгаа байхгүй юу. Тэгэхдээ 1-ийг ч чөлөөлөөгүй. Энэ хүний нөөц дээр ямар дарга, цэрэг ямар шалгуураар орж ирсэн хүмүүс байдаг юм. Энэ дээр нэг аудит хиймээр байна Монголбанкин дээр хүний нөөцийн бодлого дээр нь.

2 дугаарт, энэ шүүхийн төсөв Монгол Улсад энэ маргаан таслах асуудал болоод хүний эрхийг хамгаалахад жигд хүрэлцээтэй.../минут дуусав./

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Шүүхийн төсвийн хүрэлцээтэй байдлын асуудлыг аудитын сэдэв болгож ормоор байна. Танай байгууллага бас яг Төсвийн байнгын хорооноос өгсөн саналын дагуу төсвөө тавиулдаг. Шүүх эрх мэдэл гээд гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагатай эн тэнцүү эрх мэдлийн төсвийг Хууль зүйн байнгын хороо батлаад өгөхөөр хасдаг. Тэгэхээр энэ төсвийн харилцаан дээр та нар бас нэг дүгнэлт өгмөөр байна. Энэ хүний эрхийг хангах, шүүн таслах, шүүх эрх мэдлийн байгууллага хэвийн үйл ажиллагаа хангахад энэ болж байна уу? Яг та нартаа бас ижил зарчмаар хандангуут Сангийн яам төсвийнх нь талыг нь тастаад хаячихдаг. Та нарынхыг тастахгүй байгаа юм байна лээ. Ийм ялгамжтай байдалд байна уу, энэ чиг үүрэг зорилгодоо хүрч байна уу гэдэг энэ аудитын сэдэв болгож оруулмаар байна.

2 дугаарт, энэ аудит дээр төрийн чиг үүргийн давхардлыг анхаарч, эрх мэдлийн төвлөрлийг задалмаар байна. Орон нутагт нь өгмөөр байна шүү дээ. Орон нутаг асуудлуудаа шийдээд явахаар тийм бүтээн байгуулалт хийлээ, тэрүүгээрээ тэтгэвэр нэмээч гээд байгаа юм. Үгүй тэгээд энэ орон нутагт чинь бас хүмүүс амьдарч байгаа шүү дээ. Эрүүл, аюулгүй орчин, тохь тухтай орчинд амьдармаар байна. Чиг үүрэг болон төсөв нь өөр юм байхгүй юу. Тэгээд ингээд улс төрийн хоосон сэдэв болгоод тэрийг нь татаж авчирч энд болохгүй шүү дээ. Энэ хариултаа авчихъя.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 5 номер.

С.Магнайсүрэн: Сайнзориг гишүүний асуултад би товч товч хариулаад явчихъя. Газрын хуулийн асуудлаар бид нар сэдэв сонгож ярилцаад энэ аймгууд, нийслэл дээрээ бид нар сэдэв болгож оруулсан байгаа. Яагаад гэвэл одоо энэ Төсвийн байнгын хорооноос сэдэв батлагдахаар бүх аймаг, нийслэлээсээ сэдвээ аваад эндээс батлагдсан сэдэв дээр нэмээд ингээд том төлөвлөгөө баталдаг. Тэгэхээр энэ удаа бид нар аймаг, нийслэл дээр энэ Газрын хууль тогтоомж, газрын

төлбөрийн бие хуулийн биелэлтийн асуудлаар сэдэв бүх аймаг, нийслэл дээр оруулаад ингээд нэгтгээд тэгээд Байнгын хороондоо өгье гэдэг ийм байдлаар аймаг, орон нутгийнхаа төлөвлөгөө дээр тавьчихсан байж байгаа.

Өнгөрсөн жил гэхэд бид нар аймаг, нийслэл дээрээ нийтдээ 30 сэдэв бид нар батлаад өнөөдөр биелэлт нь 90 гаруй хувьтай ингээд явж байгаа юм. Энэ бол манай сэдвийн хүрээнд байгаа гээд ойлгочхож болно.

2 дугаарт, энэ Туулын хурдны зам дээр энэ урьдчилсан аудит л бид нар хийх юм. Энийг бид нар нөгөө ТЭЗҮ, зураг төсөв, төлөвлөлттэй холбоотой асуудлыг нь урьдчилсан байдлаар хийгээд тэгээд бодит цагийн аудит тухайн үед нь хийгээд хийгээд явчихъя гэсэн ийм байдлаар оруулсан байгаа. Ер нь олон орон энэ урьдчилсан аудитыг хийдэг туршлагатай. Энэ нь 2 талтай. Нэг нь нэгэнт хийгээд буруу, зөрүү юм хийгээд өнгөрөөд үр дагавар эсрэг болохоос, сөрөг болохоос сэргийлэх нэг талтай.

Нөгөө талаараа бас энэ нөгөө эхлэх гэж байгаа юмны бас саад болох ийм нэг болгоомжлол бас төрүүлдэг ийм талтай. Тэгэхээр бид нар энэ аль алийг нь бодолцоод ямар ч байсан бусад улс орон амжилттай явуулаад байгаа энэ юмаа, энэ том асуудал, том төсөл дээр ер нь эхлүүлэх нь зүйтэй байх гэдэг ийм байдлаар өгсөн.

Бид нар ямар нэгэн байдлаар энэ дээр хууль тогтоомж зөрчиж юм уу асуудалд нь саад болох биш, байгаа бичиг баримтынх нь хүрээнд яагаад ингээд зөвлөмжөө өгөөд явчих ийм бололцоотой гэж харж байгаа.

Дараагийн асуудал нь энэ түрүүн Цогтбаатар гишүүний асуусан тэр зээлийн хүүгийн стратеги дээр би энэ 25 онд байхгүй, 26 онд бид нар ингэж хойшлуулж оруулж ирж байгаа гэж хэлэх гэж байгаа жоохон яасан. Энэ 25 онтой андуураад яаж. Тэр бол сэдэвт байгаа.

Хүний нөөц Монголбанктай холбоотой асуудлаар Монголбанк тусдаа хуультай учраас энэ юм ер нь орж байгаагүй юм байна лээ. Санхүү, тайлан руу нь ч бид нар орж байгаагүй ийм байгаа. Энийг Төсөв, эдийн засгийн байнгын хороон дээр ярих ийм асуудал байх. Тэгэхээр бид нар энэ сэдвийг яаж чадаагүй. Энэ талын юм хөндөж чадаагүй.

Шүүхийн төсөвтэй холбоотой асуудлаар бид нар нөгөө төсвийнхөө хуульд ингээд дүгнэлтээ өгөөд зөвлөмжөө өгчихдөг. Манайх ч гэсэн ялгаагүй энэ жил бас л 6.2 тэрбумаар хасагдаад ингээд манай юу бол ингэж хасагдаж батлагдсан. Тэгэхээр ингээд тусгайлан нэг байгууллагын төсөв рүү бид нар оролцох асуудал нь Их Хурлын баталчихсан Төсвийн хууль учраас бид энэ дээр сэдэв гэж лав бид нарт санал ирээгүй. Бид сонгож ийм сэдэв судалж оруулж ирээгүй байгаа.

Төрийн чиг үүргийн давхардалтай холбоотой асуудлыг ямар ч байсан хүний нөөцийн тухайд бид нар энэ Төрийн албаны хуулийн хэрэгжилттэй холбоотой маш том гүйцэтгэлийн аудит хийгээд ингээд Төсвийн байнгын хороонд ирүүлчихсэн 8 сард байх бид нар ирүүлчихсэн ингээд одоогоор хэлэлцэгдээгүй хүлээгдэж байгаа юм. Яг байгууллагуудын чиг үүргийн давхардалтай холбоотой асуудлыг хөндөж үзээгүй.

Орон нутгийнханд бид нар нэг сэдэв оруулж байгаа. Тэр нь юу вэ гэхээр зэрэг орон нутагт ингээд олон ийм орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байгуулаад, компаниуд байгуулаад ингээд яваад байна. Энийг нь бид нар орон нутгийнхаа нөгөө аймаг, нийслэлийнхээ аудитынхаа хэмжээнд, сэдэвт нь оруулж батлуулаад тэгээд нэгтгээд Төсвийн байнгын хороодод танилцуулаад байдал нь нэг ийм байна. Тэн дээр давхардлууд байгаа учраас бид нар хийлгэх гээд байгаа нэг ийм сэдвээ л бид нар энэ жил сонгосон байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Магнайсүрэн даргаа тэгэхээр газрын асуудал дээр нэгдсэн байдлаар тэгээд ямар ч байсан орж ирэх юм байна. Тэгэхдээ хэт бас төлбөр талаасаа биш яг үнэхээр энэ газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа эрхийн төрлүүд чинь оновчтой байна уу гэдэг асуудлаа гаргаж ирж, тусгай хамгаалалттай орон нутагтайгаа хэрхэн яаж уялдаж байгаа юм. Үнэндээ хэлэхэд газрын асуудал чинь 7, 8 байгууллага дээр байгаа байхгүй юу. Сүүлд манай хил хамгаалах байгууллага хүртэл яг хилийн бүсийнхээ зоон дээр яачихсан. Мал өвөлжүүлнэ, өвөлжүүлэхгүй, хадлан тэжээл хийлгэнэ, хийлгэхгүй гээд энэ чинь бүүр их замбараагаа алдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг нэг цэгцэлмээр байна.

Шүүхийн төсвийг ирэх жил нэг бодчихооч ээ. Ер нь энийг нэг анхааралдаа авахгүй бол шүүх төрийн эрх мэдлийг ингээд 3 салаа мөчирт хуваачхаж байна гэсэн мөртөө энэ төсөв мөнгөөр нь бид нар байнгын боох юм. Энэ дээр дүгнэлт гаргаж ирж цаашдаа шийдмээр байна.

Тэгээд энэ төрийн чиг үүргийн давхардлын асуудал дээр уг нь бид сүүлийн үед хандлага байна. Хэрэгжүүлэгч агентлагийг тохируулагч агентлаг болголоо энэ тэр гээд шийдвэр гарч байна гээд байгаа байхгүй юу. Ийм инээдтэй юм байж болохгүй. Хэрэгжүүлэгч агентлаг гэдэг дээрээ яамтай агентлаг хэлдэг юм. Тохируулагч агентлаг гэдэг чинь дээрээ яамгүй агентлаг хийж хагас бодлогын шинжтэй байдаг байхгүй юу. Гэтэл ингээд ерөөсөө ингээд юмныхаа учрыг бид хэд олохгүй байна. Тэгээд энэ дээр бас нэг дүгнэлт хиймээр байна.

Н.Наранбаатар: Дараагийн Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Би энэ аудитын сэдвүүдийг дэмжиж байна аа. Би харин Цогтбаатар гишүүнтэй санал нэг байна. Магнайсүрэн дарга та үзээд энэ нийслэлийн төсөв гэдэг юмыг нэг яаж та нарын төлөвлөгөөнд байна уу үгүй юу? Ер нь нийслэлийн төсвийг нэг хянамаар байх юм. Одоо 500 сая долларын бонд гэдэг тоглоом биш байхгүй юу. Тэгэхээр надад энэ дээр тодорхой хариулт өгөөдхөөч. Байхгүй бол оруулдаг ямар арга байна. Оруулаад нийслэлийн төсвийг нэг сонсмоор байна.

2 дахь нь бас нийслэлтэй холбоотой асуудал байна. Над дээр энэ иргэдээс ингээд нэг ийм гомдлууд ирээд байх юм энийг та нар маань энэ шалгах гэж байгаа юман дотор чинь орчихдог байна уу яадаг байна. Орон нутгийн өмчийн энэ баахан юм үзнэ гээд байна шүү дээ. Тэр дотор орчхож магадгүй гэж би бодох юм. Би зүгээр тодотгоод хэлчихье.

Энэ байрны метр квадратын асуудал, СӨХ-ны төлбөрийн асуудал би 4 асуудал хэлэх юм. Ус, дулааны асуудал, цахилгааны асуудал 2 асуудал байгаа энэний цаана.

1 дүгээрт, манай хэрэглэгчид иргэд юу гэж бид нар хэрэглэснийхээ хэмжээгээр төлмөөр байна. Тэгээд хэрэглэж байгаа юмыг маань хэмжээ нь мэдэгдэхгүй, тэрийгээ өгөхгүй, өгөхгүй гэдэг нь ихэнх нь юугаар байгаа юм байна лээ л дээ сайт руу ороод үздэг барьдаг. Тэгээд тэрийгээ хэлдэггүй нэг ийм мөнгөн дүн шийдээд байдаг. Энэ мөнгөн дүн нь тэгээд яаж баталгаажиж байгааг бид нар ерөөсөө хэлэхэд хэцүү байна гэж байгаа юм. Энийг яаж хянадаг юм бэ? Энэ ер нь эрх зүйн зөв байна уу буруу байна уу? Одоо цахилгааны төлбөр юу гэж байна вэ гэхлээр шууд Улаанбаатар цахилгаан руу өгчихдөг. Ус, дулаан болохоор ингээд дамжаад нэг хувийн компаниар дамжаад явдаг. Энэ ер нь эрх зүйн хувьд яах ёстой юм бэ? Ер нь та нар энэ дээр нэг анхаарал тавиад юм хийх боломж байна уу? Байвал их сайн байна. Байхгүй бол надад бас арга зам хэлж өгөөч ээ.

3 дахь нь бас дахиад энэ нийслэлийн төсвөөс сургуулийн байшин худалдаж авч байгаа байхгүй юу манай СХД дээр болсон. Би бүтэн жил энэ асуудлаар яваад ямар ч үр дүн байхгүй. Эцэг, эхчүүд нь жагсаал цуглаан хийгээд байхгүй. Тэгээд худалдаад авчихсан бандан тас. Ийм ийм асуудлуудыг одоо бас яах юм бэ? Боловсролын яамны байшин, сургуулийн байшин тэр нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй гэдэг асуудалтай байхгүй юу. Энийг бас нэг би хаашаа хандахаа мэдэхээ байчихаад байгаа юм. Танайд иймэрхүү асуудлаар бас тухайлсан асуудлаар хандчихаж болох уу болохгүй юу?

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт энэ нийслэлийн төсөвтэй холбоотой асуудлаар энэ хуульд заагдсан 16 сэдвийн хүрээнд манай Нийслэлийн аудитын газар гэж байгаа 50 гаруй хүнтэй. Энэ байгууллага маань голчлоод ингээд ажилладаг. Сэдвийн тухайд сэдвийг энэ нийслэлийн төсөвтэй холбоотой асуудлаар тодорхой сэдэв байвал бид нар нөгөө эндээс сэдэв батлагдсаны дараа нийслэл аймгуудынхаа сэдвийг нэгтгээд ингээд том сэдэв болгож төлөвлөгөө баталдаг юм. Энэ хүрээ энд ингээд оруулчих бололцоотой.

Ялангуяа таны саяын хэлдэг энэ байрны метр квадрат, СӨХ, ус, дулаан, цахилгааны асуудлыг нийслэл дээр тодорхой сэдэв болгож ингэж Нийслэлийнхээ аудитын газарт хийлгэхээр оруулж болно. Бид нар бодлогын хүрээнд Улаанбаатар хотын дулаан хангамжийн бэлэн байдал, хэрэглэгчийг дулаанаар хангах, түгээх үйл ажиллагааны үр дүн гэдэгт ийм том сэдэв оруулсан.

Дараачийн асуудал. Таны нийслэлийн төсвөөс сургуулийн байр энэ тэр гээд энэ асуудлаар бид нар ингээд нөгөө 3 сараас хийгээд 4 сард хийгээд 6 сарын 15 гэхэд хуулийн хугацаанд бид нар Улсын Их Хуралд хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг ингэж бид нар томоор оруулж ирдэг. Энэ хүрээнд бид нар бүгдийг нь үзээд ингээд дүгнээд, холбогдох шийдлүүдээ гаргаад ингээд ороод ирдэг. Энэ хүрээнд шийдчих бүрэн бололцоотой.

Одоо бол санхүүтэй холбоотой асуудлаар нь манай санхүүгийн аудит ингээд завсрын аудит орчихсон яваа. 12 сарын 15-нд ингээд юмаа гаргаж нэгтгэж гаргана. Та тодорхой асуудлууд байвал манай энэ явцад бид нар тэрийг тодруулах маягаар ингээд мэдээллүүд угаасаа иргэд өгдөг, мэдэж аваад ингээд явц явцад нь тэр тэрийг тодруулаад тодруулаад явдаг ийм явц байгаа, боломж байгаа.

Н.Наранбаатар: Алтанхуяг гишүүн тодруулъя.

Н.Алтанхуяг: Тэгэхээр би 2, 3-ыг нь боломжтой байна. Нийслэлийнхээ хэмжээнд саяын тэр иргэдийн тавиад байгаа ус, дулаан, цахилгаан явчих юм байна гэж ойлголоо шүү дээ. Тэр нэг байшин худалдаж аваад байгаа, сургуулийн нэртэй байшин аваад байгаа юмыг бас болчих юм байж.

Нийслэлийн хувьд байна шүү дээ. Би нэг юманд найдахгүй байгаа. Яг энүүхэндээ ярихад нийслэлийн аудит нийслэлийнхээ юмыг шалгаад тэрнийх биш болоод байгаа. Ер нь эрх мэдлийн хувьд бид нар хяналтын хувьд бас би нэг эрх зүйн асуугаад байгаа юм. Нийслэлийн төсвийг энэ Төв аудит л хиймээр санагдах юм даа. Тэгж болохгүй юу? Эрх зүйн болохгүй юу? Яагаад байна? Тэр доторх байгууллагуудаа тэр нийслэлийнх нь аудит хийдэг юм байгаа биз. Хамаа алга л даа тийм. Ойлгогдож байна уу миний асуулт? Нийслэлийн төсвийг заавал энэ Төв аудит Үндэсний аудитын газар л хиймээр санагдаад байгаа юм. Тэнд чинь дахиад сонирхлын зөрчил явна.../минут дуусав./

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Асуултад нэмээд хариулъя. Нийслэлийн төсөв дээр ингээд ер нь Аймаг, нийслэлийн хуулиараа аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллага, аймаг, нийслэлийнхээ төсөв, хуулиар заагдсан энэ сэдвүүдийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулах ийм үндсэн чиг үүрэгтэй. Бид таны саналыг анхаараад чанарын энэ хяналт талаасаа эрсдэл, чанарын талаасаа манай Үндэсний аудитын газар энэ дээр манай нэгж байдаг учраас энэ дээр бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаад ингээд явчих бололцоотой.

Ер нь цаашдаа бид нар энэ нийслэлийн төсөв нэлээн ахиж байгаа учраас Үндэсний аудитын газрынхаа Санхүүгийн аудитын газар гүйцэтгэл-нийцэл бусад нэгжийн чиг үүргүүдээ ингээд хүч нэмээд дэмжин туслах байдлаар ажиллуулаад эцсийн чанарын баталгаажуулалт нь манай дээр бас хийгдээд явах ийм бололцоотой. Энэ хүрээндээ бид нар ажлынхаа дотоод зохион байгуулалт дээр анхаараад ажиллачихад үр дүн гарна гэж ингэж хэлж чадах байна.

Н.Наранбаатар: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ хуулийн дагуу гүйцэтгэх аудитын сэдвийн тэр 13, 14 дүгээр ажлууд нэг ажлууд биш юм уу? Би бас сайн ойлгосонгүй. Тэр 13, 14-өө та нар нэг хар даа. Тэр газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой тэр нэг заалтууд байна шүү дээ. Энэ 2 юугаараа ялгаатай юм гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь бодвол яах вэ энэ нөгөө газрын тосны үйлдвэр орох гэж байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулалт, газрын тосны хэмжээ, борлуулалт энэ бүгдийг нь л үзэх гэж байгаа юм болов уу. Тэрнээс уг нь энэ чинь хувийн байгууллагууд төрийн аудитаас энэ рүү орж байгаа шалтгаан нь юу юм гэдэг 2 дахь асуулт.

3-д нь үүнтэй холбоотойгоор нөгөө үлгэр домог болж байгаа нөгөө 10 жил болж байгаа энэ чинь 27 онд орно гээд байгаа шүү дээ. 17 оноос хойш нөгөө алдартай газрын тосны үйлдвэртэй холбоотой, харин тэнд үйл ажиллагаатай

холбоотой харин хийх байсан юм биш үү? Та нар энэ чиглэлээр ер нь аудитаас, ер нь энэ аудит энэ чиглэлээр орсон уу манай Дорноговь аймагт явагдаж байгаа тэр газрын тосны үйлдвэр дээр? Яах вэ тэр удирдаж байгаа хүн нь сайн газрын тосны сайн мэргэжилтэн байх л даа. Сайн ч инженер байхлаар Германд төгссөн юм байна лээ. Гэхдээ тэр том төслийг удирдах үр чадвар нь дутаад байх шиг байгаа юм.

Дээрээс нь тэр төслийн менежмент гэдэг чинь их өөр ойлголт шүү дээ. Тэгээд тэнд яг ажил яаж явж байгааг сүүлийн үед нэг арай л гайгүй л болж байна. Тэгэхдээ л ер нь энэ чинь 17 онд тууз хайчилснаас хойш чинь ингээд 2 жилийн дараа 10 жил боллоо шүү дээ. Энэ чиглэлээр юу бодож байна вэ гэж Аудит?

2 дахь нь Шинэ хоршоо хөтөлбөр. Энэ яг одоо энэ луйвар дээр нь аудит нэг зоригтойхон аудит хийх болсон. 848 тэрбум бараг их наяд шахуу төгрөг гарчхаад байна шүү дээ. Уг нь үүгээр бараг тусгай хууль гаргаад хөдөө аж ахуйн хоршооллын банк байгуулчихсан бол өдийд хамаагүй үр дүнтэй байх байсан. Энэ Шинэ хоршооллын чиглэлээр аудит ямар ажил явуулж байгаа вэ гэж?

3 дугаарт нь түрүүн өөрийн чинь ярианд тэр аудитын харин шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой алба байгуулаач. Энэ өмнө нь байгаагүй юм уу? Ерөөсөө тэр гүйцэтгэлдээ хяналт тавьдаггүй байсан гэсэн үг үү? Тэгээд хэдэн оноос хойш гэххэв би халти сонсож байсан 2, 3 мянган шийдвэр одоо болтол хэрэгжээгүй бололтой юм ярьчих юм. Тэрийг нэг тодруулаадахъя.

Сүүлийн асуулт нь уржигдрын Ардчилсан намын бүлэг дээр Төрийн албаны зөвлөлийн мэдээллийг сонссон юм. Тэгээд тэр Төрийн албаны зөвлөл дээр яригдаж байсан асуудал юу гэхлээр энэ зарим хууль байгууллагууд, ялангуяа хуулийн байгууллагууд бүүр хууль захиалагчид хуулиа лоббидож байгаад хууль гаргуулж байгаад төсөв, орон тоогоо нэмдэг асуудал гарлаа гэж. Энэ чиглэлээр аудит дээр анхаарч ажиллаж байгаа юм байна уу? Энэ 4 асуулт.

Н.Наранбаатар: 5 номер.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Олон асуулт би товчхон шиг хариулаад явъя. 1 дүгээрт энэ 13, 14 дүгээр сэдэв Газрын тосны тухай хууль, 2 хууль байдаг. Энэ хуулиар заавал манайхыг нөгөө аудит хийж энэ санхүүгийн тайлан гүйцэтгэлд нэгтгэхээр ингээд орчихсон ийм хууль, 2 ийм хуулийн заалттай. Нэг нь хайгуул байгаа. Нөгөөдөх нь ашиглалт байгаа. Тэгээд ингээд 2 сэдэв нь тусдаа хуульчлагдсан байдаг учраас бид нар жил болгоны энэ нөгөө хуулийн хийх сэдэвт орж ирдэг. Энэ хувийн байгууллагад хийнэ гэхээсээ илүү хууль дээр заагдсан байдаг нөгөө зардлуудтай холбоотой асуудлыг үнэлж, дүгнэж ингэж орж ирдэг. Одоо ч бид нар тэндээ хийгээд сэдвүүд явж байгаа.

2 дугаарт, энэ газрын тосны үйлдвэрийн чиглэлээр бид нар энэ жилийнхээ сэдэвт одоогоор оруулж ирээгүй байна. 27 онд ашиглалтад орно гэсэн ийм юутай байгаа юм байна лээ. Ер нь газрын тосны үйлдвэр гэдэг гээд ТӨК гэдгээрээ нөгөө санхүү нь манай энэ хуулиар хийгдэж байгаа завсрын болоод бүтэн жилийн аудитад орж байгаа. Гүйцэтгэл-нийцэл талаасаа одоогоор бид нар төлөвлөөгүй байна. Ер нь бид нар энэ жил нөгөө урьдчилсан аудитыг зөвхөн Туулын хурдны зам дээр оруулж байсан. Цаашдаа энэ дээр бид нар хийх сэдэв талдаа анхаарах бололцоотой.

Шинэ хоршоон дээр бид нар энэ жилдээ сэдэв сонгож орж ирээгүй. Нөгөө юу төлөх, зээл төлөлтийн хугацаа нь арай болоогүй байгаа юм байна гэсэн ийм мэдээлэлтэй байна. Тэгээд энийг Хөдөө аж ахуйн яам холбогдох юуных нь хүрээнд эд нар энэ завсрын аудит юугаараа нэг үзчихээд. Тэгээд тэрнээсээ харж байгаад больё гэсэн ийм байдлаар орхисон байж байгаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар өмнө нь байгаагүй. Тэгээд энэ жил тусгайлж гаргаж ирээд бид нар бүүр 12 оноос хойших бүх шийдвэрүүдийг нэгтгэж байгаад биелсэн, биелээгүйгээр сая ялгаж зааглахад 3 мянга орчим ийм шийдвэр үлдсэн байна лээ. Тэгээд энэ нь төлбөрийн акт, зөвлөмж, албан шаардлага, сахилгын шийтгэл, гэмт хэрэг гэсэн ийм гэмт хэргийн чанартай гэсэн ийм 5 байдлаар бид нар багцалж датагаа эцсийн байдлаар цэвэрлэж аваад одоо энэний хэрэгжилт рүү бид нар онцгойлон анхаарч ингэж ажиллаж байгаа гэж болно. Олон шалтгаанууд байгаа. Бид нар Төсвийн байнгын хороон дээр энийгээ дэлгэрэнгүй танилцуулна.

Хуулийн байгууллагууд ингээд хууль гаргаж байгаа асуудал шийддэг гээд. Энэ дээр одоогоор бид нар ямар нэгэн юм танд мэдээлэл өгч чадахааргүй байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Уг нь манай энэ Үндэсний аудитын газар гэдэг байгууллага чинь бидний нэг жоохон байгаа төсөв санхүүгийн, энэ улсын нэг жоохон төсөв санхүүгийн нөөц, байгаа нөөцөд л хэр, хэрхэн үр дүнтэй зарцуулагдаж байгаагаа л хяналт тавих ёстой юм л даа. Гэхдээ би яах вэ та бүхэнд харин тэр нэг тийм шийдвэрийнхээ гүйцэтгэлд хяналт тавих байгууллагатай болсонд нь талархаж байна. 2012 оноос хойш 3 мянга гаруй шийдвэр одоо болтол хэрэгжээгүй гэдэг. Тэгэхлээр энэ яах вэ хөөн хэлэлцэх хугацаа яригдах уу? Тэр 3 мянга гаран шийдвэр хэрэгжээгүйн чинь хэд нь эрүүгийн хэд нь энэ чиглэлээр нь ангилаад ялгасан юмнууд байдаг уу? Яг үндсэндээ наад дотор чинь л нөгөө төсөв, төрийн мөнгөний гол юмнуудын л гогцоо наана чинь л явж байгаа даа. Тэн дээр жоохон тодруулах юм байна уу?

Н.Наранбаатар: 5 номер.

С.Магнайсүрэн: Нэмж хариулъя энэ шийдвэрүүдийг бид нар бүүр нэг бүрчлэн гаргаад ингээд нөгөө цаад хариуцах эзэнтэй нь гаргаад саяын 5 хэлбэрээр ангилчихсан гэмт хэргийн чанартай, сахилгын шийтгэл хүлээж ажлаас халагдах ёстой, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага гээд. Энэний миний санаж байгаагаар 208 жишээлбэл гэмт хэргийн чанартай гээд ингээд шилжчихсэн байгаа. Энэнээс шийдэгдсэн нь маш цөөхөн байгаа юм. Хэрэгсэхгүй болсон, шалгах явцад байхгүй хэрэгсэхгүй болсон ийм юмнууд нь нэлээн голлох.

Гэтэл манайх яах вэ өмнө нь энэ дээр тэрийг тэгээд гүтгээд орхичихдог, цаашаа давж заалдаад дараагийн шат руугаа 1 дүгээрт яваагүй. 2 дугаарт гэмт хэргийн чанартай биш юм бол манай түвшинд буюу төрийн аудитын байгууллагын түвшинд ядаж сахилгын шийтгэл ноогдуулаад ингээд явах ёстой. Гэтэл тэр зүйлүүд нь орхигдчихсон ийм зүйлүүд байсан. Энэ болгон дээр бид нар анализ хийгээд ингээд шийдлүүдээ бэлэн болгосон байгаа.

Н.Наранбаатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Би аудитын сэдэв батлуулна гэхлээр ирэх онд аудит хийх л юугаа батлуулах гээд байна гэж харж байгаа юм. Тэгэхлээр улсын болон орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалт эднүүдийг бас шалгаад байдаг. Энэ хөнгөлөлттэй зээлүүдээр хийгдэж байгаа энэ том том байгууламжийг ер нь шалгаж үзэж байна уу? Одоо ирэх жил ер нь юу байна аа? Жишээлэх юм бол хөдөөгийн 10 аймгийн дулааны станц маш том хамрах хүрээтэй маш том төсөл. Солонгосын компани нь дампуурсан гээд л ингээд л байж байдаг. Баруун 5 аймгийн цэвэрлэх байгууламж гэдэг. Мөн Төв цэвэрлэх байгууламж.

Саяхан телевизээр Туул коллектор Налайхаас баруунд шинэ цэвэрлэх байгууламж хүртэлх 28 онд ашиглалтад орно гэж байна. Энэний өмнөх тэр зээлийн асуудлууд энэ тэр ер нь шалгагдсан зүйл байдаг юм бол уу? Шалгах төлөвлөгөөнд орсон зүйл байдаг юм бол уу? Би мэдээж улсын төсөв, орон нутгийн төсвөөс гадна энэ зээлээр, хөнгөлөлттэй зээлээр санхүүжиж байгаа энэ том хөрөнгө оруулалтуудыг ер нь яаж орсон байдаг юм оо гэж нэг сонирхох гэсэн юм.

Дээр нь энэ Төрийн албаны зөвлөлийн буюу шүүхийн шийдвэрээр энэ албан тушаалтны буруутай үйлдлээс баахан төлбөрүүд гарсан байдаг. Тэгээд тэрийг нь байгууллагууд нь төлчихсөн. Гэм буруутай яг тэр албан тушаалтан ерөөсөө төлөөгүй маш их мөнгө байдаг. Энийг ер нь улсын хэмжээнд төлүүлэх ийм шийдвэр аудитын байгууллага ер нь гаргасан уу? Миний мэдэж байгаагаар л 1, 2 хүн гэхэд л бараг маш олон хүн 10, 20-оор нь халсан. Тэрний жил, 2 жилийн төлбөр гэхэд 200 гаруй сая төгрөгийн ийм хохирол тэгээд тэрийг нь албан байгууллагаас нь төлчихсөн байдаг. Тэгээд тэр чинь үгүй тэрийг халсан, хууль буруу хэрэглэсэн хүн нь өөрөө төлөх ёстой шүү дээ. Ийм зүйл ер нь улсын хэмжээнд хэдий хэмжээний төлөгдөөгүй зүйл байдаг юм оо гэсэн ийм хэдэн зүйлийг асуумаар байна.

Дээр нь энэ ЖДҮ гээд нэг хэсэг шуугьж байгаад орхисон. Энэ улсын хэмжээний ЖДҮ-д ер нь түрүүнд хэн байлаа Ганбаатар гишүүн хоршоод л гээд асуучихлаа. Би хоршооллоос гадна ЖДҮ-д ЖДҮ ч янз бүрийн ЖДҮ-ийн газраас өгнө, аймаг өгнө, сумууд өгч байгаа. Эдгээрийг ер нь нэгдсэн байдлаар шалгах ийм төлөвлөгөө байдаг юм болов уу гэсэн ийм асуулт асууя.

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Энэ хөнгөлөлттэй зээл, тусламжтай холбоотой асуудлаар хэд хэдэн байдлаар үзэж байгаа юм.

1 дүгээрт, бүх төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа. Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ зээл тусламжийн төслүүд дээр санхүүг нь бид нар энэ цаглаварт хуулийнхаа хугацаагаар завсрын болоод бүтэн жилээр нь үзээд ингээд санхүүгийн тайланд, Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгэчихэж байгаа юм.

2 дахь асуудал нь бид нар 2024 онд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн сэдвээр хийгээд одоо Байнгын хороонд ирүүлчихсэн тайлангаа энэ жил болохоор буюу 25 онд хөдөө аж ахуйгаас бусад төсөл хөтөлбөрийн, хөдөө аж ахуйгаас бусад салбар дахь энэ гаднын зээл, тусламж төсөл, хөтөлбөртэй холбоотой асуудлыг сэдвээр хийгээд энэ онд дуусгаад та бүхэнд танилцуулга авчирч хэлэлцүүлнэ. Энэ ингээд хийгдчихэж байгаа гэж ойлгож болно.

Төрд учирсан хохиролтой холбоотой асуудал энэ нэлээн онцгойлон анхаарахгүй бол болохгүй байгаа ийм асуудал байгаа юм. Тэгэхээр манайх саяын завсрын аудитаар хэд хэдэн юмыг онцгойлон гаргаж ирэхээр ийм тусгайлсан ийм шоглоом, хүснэгт гаргаад манай завсрын аудитынхан орсон. Нэг нь төрийн албан тушаалтны буруутай хууль үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг нэг бүрчлэн хэзээ, яаж, хэн яасан бэ тэрийг нь гаргаж ир гэсэн байгаа.

2 дахь нь энэ бүх салбарт энэ цахим гээд аягүй олон ийм бид тус тусдаа ийм аягүй их хөрөнгүүд зарчихсан байдаг юм байна. Хэвлэл мэдээлэлд бас зардаг юм байна. Олон нийттэй харилцах чиглэлээр зардаг юм байна. Гадаад арга хэмжээ гээд. Ингээд бид нар нэг ийм хүлээн авалт гээд нэг хэсэг ийм хэдэн ийм Их Хурлын гишүүдийн саналын дагуу ийм нэг тийм асуудлуудыг гаргаж ирж нэгтгэж бид нар бас харахаар энэ ингэж явж байгаа.

Өчигдрийн байдлаар бид нар энэ Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газартай хамтраад нэг зүйлийг тогтож байгаа юм. Тэр нь болохоор зэрэг энэ төрд учруулсан хохирлын асуудлыг бүгдээрээ ингэж мэдээллээ нэгтгээд хуулиараа Улсын Ерөнхий прокурор төрийн нэрийн өмнөөс энэ хохирлыг барагдуулах асуудлаар хуулийн чиг үүрэгтэй Төрийн албаны зөвлөл бас асуудлыг авч явах, асуудал шийдүүлэх ийм чиг үүрэгтэй. Манай дээр болохоор зэрэг бид нар гаргаад тэгээд тэр 2 байгууллагадаа өгдөг. Шүүх рүү ингээд асуудал тавиулахаар өгдөг. Дүн мэдээг нь ингээд манай 3 байгууллага дээр бүгдийг нь нэгтгээд ингээд нэг нэгтгэсэн дүн мэдээлэлтэй байхаар ийм хэд хэдэн зүйлээр бид нар тохироод ингээд ажиллаж байгаа. Цаашдаа энэ дээр ямар нэгэн асуудал гарахааргүй түвшинд одоо ажлаа ярьж байгаа.

Яагаад вэ гэхээр бид нар өнөөдөр эндээс нь ингээд нэг нөхрийг тэгсэн байна гээд халчихдаг. Нөгөө газар очоод ингээд бас ажилд орчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас манай энэ байгууллагууд ингэж мэдээллээ нэгтгэж ингээд шүүлтүүр хийхгүй бол нэг газраас нь гараад манайхаас ажлаас халагдлаа, манайх хал гээд тэгэнгүүт халчихлаа гээд тэгэнгүүт өөр газар дахиад ингээд бүүр дэвшээд ч орчихсон байх ийм тохиолдлууд бас олон байгаад байгаа учраас бид нар энэ дээр онцгойлон анхаарч ажиллаж байгаа.

Жижиг, дунд дээр бид нар хийгээд хэзээ билээ, 11 сард сая сэдвээ жижиг, дунд тайлангаа өгчихсөн байгаа. Сэдвээр хийгээд ирүүлчихсэн байгаа.

Н.Наранбаатар: Тодруулъя Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Энэ би нэг зүйл илүү тодруулчих уу? Жишээлэх юм бол би жишээ юуг ирүүлээч гэж бодож байна. 16-аас 20 онд жишээ нь Сүхбаатар аймгийн Тамгын газрын даргаар өөрөө хууль бус томилогдоод маш олон хүнийг халаад ингээд тэр төлбөр нь шүүхээр гараад тэрийг нь зүгээр төрөөс олгочихсон. Энэ тооцоогоо тэр гэм буруутай этгээд нь төлдөггүй ийм үйлдэл байдаг.

Тэгэхлээр энийг надад юугаар ирүүлээч нийт хэдий хэмжээний шүүхийн шийдвэр гарсан юм байгаа юм. Энийг тухайн хүнд нь төрөөс хэдэн төгрөг олгочихсон байдаг юм байгаа юм. Гэм буруутай этгээд нь хэдийг нь төлсөн байдаг юм, хэдийг нь төлөөгүй байгааг ирүүлээч. Би яг үүгээр юу хэлэх гээд байна вэ гэхлээр улсын хэмжээнд яг энэ шүүхийн шийдвэрээр буцаж ордог бүүр тийм юуны бөмбөг тоглож байгаа юм шиг болж байгаа юм л даа. Тэгээд буцаагаад жил, 2 жил

болоод ажилласан жил нь ч нөхөгдөөд цалингаа ч авчихдаг. Сул авдаг.../минут дуусав./

Н.Наранбаатар: Санал уу? Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Төрийн аудит бол татвар төлөгчдийн мөнгийг зөв, үр дүнтэй зарцуулагдаж байгаа эсэхэд л хянан баталгаажуулдаг газар байгаа. Тэр ч үүднээсээ энэ Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ томоохон төсөл, хөтөлбөрүүд дээр хяналт тавих нь зөв байна. Тэгээд л бид нар нэг томоохон төслүүд эхэлдэг, ямар үр дүнтэй, үр дүнгүйг нь дараа нь ингээд хэлэлцээд сууж байдаг нь үндсэндээ өнгөрсөн борооноор нь бас цув нөмөрч байгаатай ялгаагүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ орж ирж байгаа саналуудыг дэмжиж байна. Энэ дээр нэмж саналууд оруулмаар байна. Тэгээд манай гишүүд ч хэлж байна л даа. Сая ингээд тэр Шинэ хоршоо хөдөлгөөн, хөтөлбөр дээрээс нь ингээд тэр газрын тос, ЖДҮ гээд.

Яг үнэндээ Шинэ хоршоо хөдөлгөөн малчны хотонд, тэр сумд үйлдвэрлэлийг л бий болгох зорилготой л ажлын байрыг бий болгох зорилготой, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой л өгч байгаа шүү дээ. Хөдөө сумуудаар айлуудаар очиход л тийм асуудал ерөөсөө алга байна. Энэ жил ингээд эргэн төлөлт нь хийгдэж байгаа. Тэгээд энэ хөтөлбөр хэрэгжээд явж байгаа байхгүй юу цаашдаа. Энэ юу гэдэг юм ийм үр дүнгүй ажлыг ингээд цааш нь явуулаад байх нь зөв юм уу? Энэ чинь татвар төлөгчдийн мөнгө шүү дээ.

Дараагийн асуудал энэ орж ирж байгаа саналууд дээр байгаа энэ орон нутгийн гээд тэр тусмаа энэ нийслэлийн асуудал байгаа юм. Энэ нийслэл дээр онцгойлон анхаарах шаардлагатай болсон. Маш өндөр дүнтэй томоохон төслүүд ингээд ороод ирдэг. Энэ чинь эргээд л татвар төлөгчдийн мөнгө шүү дээ. Тэгээд л дураараа шууд ингээд цалин нэмж байдаг. Тэр ТҮК-ийн ажилчдын цалин 3.5 сая гээд. Яг энэнээс болж Монгол Улсын энэ жилийн төсөв хүндрэхэд энэ нөлөөлөл байна шүү дээ.

Яахлаараа гудамд цэвэрлэгч хийж байгаа хүнээс багш нар, эмч нар дор цалинтай байдаг юм гэдэг л асуудал явлаа шүү дээ. Сая хөдөө орон нутаг, сумдад ажиллаад ирэхэд яг ийм асуудлыг ярьж байна бүх төрийн албан хаагч нар ярьж байна, ажилчид ярьж байна. Багш нарын цалин нэмчихлээ одоо төрийн энэ албан хаагчид энэ ажилчид цалингаа яах юм, бид нар яаж амьдрах юм, эд нар өөр хүмүүс бид нар өөр тусдаа улсууд юм уу гэж ярьж байна шүү дээ. Тэгэхээр ийм бодлогогүйгээр ийм хийгдэж байгаа ажлуудыг бид нар таслан зогсоох ёстой. Тэр тусмаа нийслэл дээр анхаарах хэрэгтэй байна.

Тэгээд хэсгийн ахлагч гээд хэдэн мянган хүн гэнэ. Бүтцэд байхгүй, орон тоо байхгүй улсуудыг баахан гаргаж ирээд ингээд цалинжуулчихсан. Тэгээд нөгөөдүүл нь ямар ажил хийдэг вэ гэхээр ерөөсөө л ухуулагч, намын ухуулагч хийж байдаг. Хэсгийн ахлагч нэртэй хэдэн мянган хүн. 3 мянга, 2 мянган ингээд тоог нь мэдэхгүй гэх жишээний ийм асуудлуудыг одоо бид нар зогсоох шаардлагатай болсон. Тэр томоохон төслүүд дээр бид нар үнэхээр түрүүлж ороод энэ бодитой юу, үр өгөөжтэй юу гэдгийг хянаж шалгах нь зөв байна.

Мөн дээрээс нь төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламжийн зураг төслийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гэж байгаа юм. Энэ үнэхээр чухал. Одоо манай Барилга хөгжлийн төв, зам тээвэр, замын.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье Жаргалсайхан гишүүнд. 1 минут Жаргалсайхан гишүүнд нэмж өгье.

Д.Жаргалсайхан: Энэ Эрчим хүчний хөгжлийн төв гээд л ерөөсөө ингээд дураараа төсөв баталдаг. Тэгээд л нөгөөдөх нь харьцуулахад Хэнтийд байгаа 2км замынх нь өртөг 10 тэрбум. Баянхонгорт байж байгаа 2км замын өртөг 2 тэрбум байж байгаа байхгүй юу энэ чинь. Ийм зөрүүтэй замын зураг батлаад сууж байна шүү дээ. Үгүй энэ чинь ийм юм гэж юу байсан юм бэ энэ чинь. Энэ чинь юу гэсэн үг юм тээ? Нэг нь 5 дахин илүү байна шүү дээ нэг нь нөгөөдхөөсөө. Тэгэхээр ийм байдалтай төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг ингэж тэр Барилга хөгжлийн төв, энэ Замын хөгжлийн төвийнхөн төсөв баталдаг асуудал дээр хяналт тавих ёстой. Энийг таслан зогсоох хэрэгтэй байна.

Тэгээд л дараа нь танай аудитаар ажлаа хийхгүй хэвтсээр байгаад л оруулж ирдэг. Оруулж ирснийг нь та хэд үнэхээр үнэ нэмэгдсэн байна гээд л. Ерөөсөө ийм хэсэг бүлэг компаниуд бий болчихлоо шүү дээ. Ажлаа хийдэггүй, тэр ажил нь босдоггүй, үр дүнгээ тэр үр өгөөжөө тэр сум орон нутагтаа өгдөггүй. Одоо энэ асуудлыг бас дахиад л ярих гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ байгууллагууд дээр аудит хийх шаардлагатай байна. Мэргэжилдээ тэнцэхгүй тийм ажилс.../минут дуусав./

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Сүүлийн энэ Эрчим хүчний хөгжлийн төвтэй холбоотой асуудлаас нь эхэлчихье.

1 дүгээрт энэний дараагийн нэг асуудал дээр бид нар төсөвт өртгийн өөрчлөлт дээр сэдэв аудит хийгээд ингээд ороод ирсэн бас яригдахаар байгаа. Энэ хүрээнд ажиглагдсан нэг зүйл бол энэ хөгжлийн төвүүд буюу зураг төсвийг магадлаад ингээд хариуцлагаа хүлээх ёстой байгууллагуудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болоод олон олон асуудлууд, үр дагаврууд үүсээд байгаа юм. Тэр нь 1 дүгээрт манай дээр хүртэл бид нар энэ жил 208 сэдэвт юун дээр зураг төсөв дээр ингэж ажиллаад үндсэндээ бид нар хагас жил ажиллаад 11 сарын 15 гэсэн хугацаатай Төсвийн байнгын хорооны сэдэв батлаад өгчихсөн. Тэгээд арай гэж бараг л амжсан. Энэ бол дараа нь яригдах учраас.

Тэгээд энэ дээр үндэслээд бид нар юу гэж бодсон бэ гэхээр энэ жилийнхээ сэдэв дотор бид нар энэ зураг төсвийн сэдвийг тусгайлан манай орж ирсэн сэдэв дээр зураг төсвийн сэдэв тусгайлж орж ирсэн байгаа. Төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламжийн зураг төслийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гэсэн сэдвээр бид нар энэ уг суурь шалтгаан руу нь орохгүй бол жил болгон ингээд сүүлийн 2 жил манайх хийж байгаа юм байна лээ. Төсвийн байнгын хорооноос ингээд сэдэв баталж өгөөд. Тэгэнгүүт ингээд манай дээр нөгөө ачаалал үүсээд бид нар 200 орчим ийм төсөл, зураг төсөв хянадаг болж ингэж хувирч байгаа юм.

Тэгээд бид нар олон олон ажлын ийм үр дүн өөр газар явж байх байтал тийшээ чиглээд тэгээд ингээд тэр ажил нь яваад ингээд Сангийн яам бүх яам тэгээд бүүр Төсвийн байнгын хороон дээр хүртэл ингэж нөгөө ачаалал үүсэж байгаа. Төсвийн орлого, зарлагад нөлөөлөх хэмжээнд ийм асуудал болж байгаа учраас бид нар энэний шалтгаан руу нь оръё оо гээд энэ жил ерөнхий тусгайлсан

бодлогын сэдэв орж ирээд явж байгаа учраас дараагийн энэ хэлэлцэх асуудал дээр энэ талаар дэлгэрэнгүй бас яригдана.

2 дугаарт нь тэр нийслэлтэй холбоотой асуудал дээр нэг ийм асуудал байгаа нь энэ орон нутаг дээр ер нь энэ орон нутгийн иргэдийн хурал эрх хэмжээнийхээ хүрээнд бас ингээд олон шийдвэрүүд гаргаад тэр нь ингээд төсөв дээр нь бас бас ачаалал болоод тэгээд орлого, зарлагынх нь улсын төсвийн хязгаар баталсан нөгөө тооны хязгаараас энэ тэр бас наана цаана давчихсан ийм юмнууд манай дээр бас байгаад тэгээд бид нар тэр дээр бас ингээд арга зүй юмаа ингээд хараад байгаа юм. Саяын таны ярьсантай холбоотой асуудлуудыг бид нар энэ нийслэлийн аудитын газрынхаа хэмжээнд энэ яаж батлагдаж, яаж нэмэгдсэн гээд энэ санхүү талаасаа энэ завсрын аудит болоод жилийн аудитынхаа хүрээнд гаргаж ирээд ингээд танилцуулагдана.

Шинэ хоршоотой холбоотой асуудлаар түрүүн би бас хэлсэн. Энэ жилийнхээ сэдвийн хүрээнд оруулж ирээгүй. Бид нар ингээд сэдэв ингээд болж өгвөл ингээд олон сэдвээр нэмэх бид нарт юу байгаа боловч яг ингээд хөрөнгө мөнгө, хүн хүчний хувьд бид нар ингээд тооцоод үзэхээр бид нар энэ сэдвээ, хүн хүчээ тооцоход л бид нар хүрэхгүй байх жишээтэй. Яагаад вэ гэхээр зэрэг сая төсвийн тодотголоор манайх 9 хувь ингээд орон тоогоо 1 дүгээрт хасагдаад 54 хүн хасагдсан. 2 дугаарт энэ жилийн төсөв маань батлагдахад л 6.2 тэрбумаар жишээлбэл хасагдаж батлагдсан байж байгаа.

Тэгээд ингээд нөгөө хүн хүчтэй холбоотой асуудлаа хүн өдрөөрөө тооцоод үзэхээр ингээд нарийн тооцоод үзэхээр бид нарын ачаалал жоохон хүнд байгаа. Энэ нь болохоор зэрэг эргээд аудитын чанарт нөлөөлөхөөс авхуулаад ингээд олон олон сөрөг үр дагаврууд үүсээд байгаа учраас бид нар өөрсдийнхөө бололцоонд энэ жилийн энэ сэдвийг оруулж ирсэн байж байгаа. Тэгээд нарийвчлаад яавал бид нар их дэлгэрэнгүй тооцоо, мэдээлэл бас танилцуулах бололцоотой байгаа юм.

Н.Наранбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Ингээд орон нутаг руу орж байгаа чинь зөв өө. Орон нутагт орон нутгийн өмчит энэ ТӨК замбараагаа алдсан. Баахан төсөв дээрээ ингээд л хувийн аж ахуйн нэгжтэй өрсөлдөөд л баахан төсөв мөнгө тавиад л тэгээд үр дүнгүй үйлдвэрүүд барьчихсан. Нөгөөдүүл нь ажиллахгүй. Тэгээд цаана нь юу байгаа вэ? Ерөөсөө л авлигал хулгай. Нөгөөдүүлээ одоо ингээд хувьчлах гээд сууж байдаг. Дуудлага худалдаа зохион байгуулаад л яг энэ шиг орон нутагт хавтгайрсан.

Тэгэхээр тэр орон нутгийн төсөв батлахад аудитынхан нь орж ирээд л нэг баахан л зөвлөмж өгдөг. Ер нь танайх яг нэг баахан л зөвлөмж гаргадаг. Ер нь энэ хэрэгжилт, гүйцэтгэл, энэ таслан зогсоохдоо ямар арга хэмжээ авдаг юм? Энэ дээр ер нь ахиц дэвшил гарч байна уу? Жил бүр л ингээд л нэг аудитын тайлан хэлэлцээд л ингэсэн гүйцэтгэл. Одоо манай энэ гүйцэтгэлийн тайлан бүгдээрээ л сонсоод л сууж байгаа шүү дээ. Бүгдээрээ 50 хувиас доош. Ийм үр дүнгүй ийм балай юм гэж юу байсан юм бэ энэ чинь. Энэ дээр ямар та нар арга хэмжээ авч хариуцлага тооцдог юм? Тэр талаасаа хариулт өгөөч.

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Жаргалсайхан гишүүн асуултад нэмээд хариулъя. Бид нар нөгөө орон нутаг руу ингээд түрүүн яригдсан. Орон нутаг руугаа бас бүх аймаг, орон нутагтаа сэдэв өгөөд энэ орон нутагт байгуулагд Иргэдийн хурлын шийдвэрээр байгуулагдаад байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжтэй холбоотой асуудлыг 1 дүгээрт санхүү талаасаа, бололцоо талаас нь, 2 дугаарт нөгөө энэ төвтэйгөө бусад юутайгаа давхардал талаас нь ингээд хараад сэдэв болгоод ингээд нэгтгээд бүх аймаг, нийслэл дээр хийлгэж нэгтгээд тэгээд ингээд Төсвийн байнгын хороонд танилцуулахаар ингэж тооцоолсон байгаа.

2 дугаарт, саяын таны хэлдэг энэ хариуцлагагүй байгаатай холбоотой хариуцлага манай шийдвэрүүд хэрэгжихгүй байгаа, хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаатай холбоотой асуудлаар би бас түрүүн нэлээн дэлгэрэнгүй хэлсэн. Энэ талаар бид нар тусгайлсан бүүр ингээд танилцуулга бэлтгэж Төсвийн байнгын хорооны гишүүддээ 1 дүгээрт танилцуулах ийм бэлтгэл хангачихсан байж байгаа. Өмнө нь нэг Төсвийн байнгын хороон дээр ийм чиглэл өгөгдсөн. Энэ дээр яах вэ үр дүн дээр нь хэд хэдэн юман дээр манай жишээлбэл төлбөрийн актыг ингээд бид нар албадан гүйцэтгэж чадахгүй байгаа. Яагаад вэ гэвэл хуучин ингээд.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмээд өгчих.

С.Магнайсүрэн: Хуучин ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсаар ингээд албадан явдаг байсан чинь одоо хуулиудынх нь яг юугаар байцаагч биш учраас танайхыг албадан гүйцэтгэхгүй гээд ингэчихсэн. Тэгээд бид нар өөрийнхөө хэмжээнд яваад ингэж явж ирсэн. Тэгэхээр бид нар эрүүгийн процесс, иргэний процесстэй холбоотой Захиргааны ерөнхий хууль энэ тэр 2, 3 хуулийн маш ийм хоорондоо уялдсан ийм бололцооны өөрчлөлтийг бид нар энэ танилцуулгынхаа дараа Төсвийн байнгын хороонд гишүүддээ бас санал болгоно. Бүх судалгаа, тооцоо, холбогдох мэдээллүүдийг нь хийчихсэн. Аудитын шийдвэрүүдийн асуудлаар бид нар нарийвчилсан мэдээллүүдийг танд танилцуулахад бэлэн болсон байгаа.

Н.Наранбаатар: Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Ирэх жилийн энэ аудитын сэдвийг дэмжиж байна. Тэгээд энд 2 асуудал нэмээд оруулчхаж болохгүй юм уу гээд санал хэлэх гээд байгаа юм. Би түрүү жилээс эхлээд л энэ гадаадын энэ хөнгөлөлттэй зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний талаар яриад байгаа юм. Тэгээд ерөөсөө энийг хэн шалгах ёстой юм, яаж үзэх ёстой юм? Бид нар нэг их сайхан хүү багатай зээл авчихлаа гээд баярлаад байдаг. Тэгсэн нөгөөх нь төсөвт өртөг нь мангар өндөр. Тэндээсээ ингээд ашгаа олчхоод тэгээд дараа нь бид нар тэрийг татвар төлөгчдийн мөнгөөр эргүүлээд төлнө. Хэчнээн хүү багатай ч гэсэндээ бид нар өнөөдөртөө маш алдагдалтай л юм руу яваад байгаа юм. Энэ зарим нэг орон сууцын хөтөлбөртэй холбоотой энийг шууд хэлж болоод байгаа юм л даа.

Яармагт гэхэд жишээлбэл 2 сая 500-аас 3 сая 500-гаар аж ахуйн нэгжүүд ингээд метр квадратыг нь орон сууц барьчхаад зараад байсан чинь хажууд нь тэр Солонго гэдэг чинь бүүр газрын төлбөр ч байхгүй бараг тэгээд энэ чинь 4 сая 500-аас дээшээ гараад явчих ийм байдалтай харагдаад байгаа шүү дээ. Тэгээд квадрат болгон дээр ингээд сая төгрөг гэдэг чинь наадах чинь аймаар л алдагдал хүлээхээр юмнууд харагдаад байгаа юм. Тэгэхээр ер нь энэ гадаадын зээл

тусламжтай холбоотой асуудлыг энэ аудит руугаа энэ төлөвлөгөөндөө оруулж болох уу гэж асуух гээд байгаа юм. Энэ дээр ер нь бас хийгдсэн ажил байдаг юм уу гээд.

2 дугаарт нь түрүүн энэ Алтанхуяг гишүүн бас хэлчихлээ. Нийслэлийн төсвийг ер нь энэ Үндэсний аудитын газар дээрээ татаж авч хийж байхгүй бол нийслэл өөрөө шалгаж чадахгүй байх. Бид нар хуулиараа энэ төсөв төвлөрүүлдэг аймгууд гэдэг юм уу, нийслэл гэдэг юм уу ингээд бонд гаргах эрх олгочоод байдаг. Тэгээд энэ чинь маш их хэмжээний мөнгө яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бонд гаргаж байгаа тэр аймаг, нийслэлийг ер нь энэ Үндэсний аудитын газар өөрөө татаж авч энэ төсвийг нь хянадаг байх, шалгадаг байх ийм асуудал ер нь тусгасан нь дээр байх гэж бодоод байна.

Одоо нийслэл чинь өөрөө 500 сая доллар гээд босгоод ирчихсэн. Ирэх жилээс төсөв төвлөрүүлдэг Өмнөговь ороод ирнэ тэгээд л дараа нь Орхон гээд л ингээд л Дорнод гээд л ингээд ороод ирнэ. Тэгээд яах юм тэр аймагт нь хаячхаад яваад байх юм уу хэчнээн хэмжээний мөнгө босгочоод юу хийгээд байгааг нь бид нар яа аймагт нь хаячхаад яваад байх юм уу гэдэг ийм асуудал гараад байгаа юм. Тэгэхээр энэ 2 дээр хариулт өгөөч.

Н.Наранбаатар: 5 номерын микрофоны хариулт.

С.Магнайсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Гаднын зээл, тусламжтай холбоотой асуудлаар 2 төрлөөр явж байгаа. Одоо энэ удаа бид нар энэ энэ 12 сарын 20 гэхэд хэд хоногийн дараа хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжиж байгаа гаднын зээл, тусламжийн ашиглалт, үр ашиг сэдвээр ингээд тайлан бодлогын сэдвээр гүйцэтгэлийн аудит хийгээд дуусаад одоо манайх хяналтын шатдаа байж байгаа. Удахгүй ингээд та бүхний гар дээр хүргүүлнэ.

Энэ сэдвийг бид нар 2021 онд бас хийсэн юм байна лээ. Ингээд 3 жилийн давтамжтай энэ сэдэв бол хийгдээд явж байгаа. Хөдөө аж ахуйн салбарыг нь болохоор 24 оныхоор хийчихсэн учраас энэ жил хөдөө аж ахуйн салбараас бусад гэж ингэж хийгдээд одоо тайлан бол тайлагнагдана. Тийм учраас тэн дээр нэлээн дэлгэрэнгүй асуудлууд яригдана гээд гэж ойлгож болно.

Нийслэлийн төсөвтэй холбоотой асуудлаар түрүүн бас гишүүд маань хэлсэн учраас бид нар энэ чанарын үе шатын хяналт дээр эрсдэл чанар тал дээр нь бид нар онцгой анхаарна. Манай ийм бүтцийн нэгж байдаг. Дээр нь бид нар энэ дээр Үндэсний аудитын газраас нийслэлийгээ зөвлөн тусалж, дэмжин туслах чиглэлээр шаардлагатай бид нар тийшээгээ хүн хүчээ, зарим хүнээ төвлөрүүлэх маягаар ингээд ажиллаж болно. Бүх нэгтгэл нь манай завсрын болоод жилийн аудитын тайлангаар нийслэл аймгууд бүгд нэгтгэгдээд ингээд ороод танилцуулагдаад явчхаж байгаа. Тийм учраас бид нар таны саналыг ингээд анхаараад ажлынхаа арга барил, тогтолцооны түвшинд нь анхаараад явчихвал шийдчих бололцоотой гэж ингэж хариулъя. Баярлалаа.

Н.Наранбаатар: Надад нэг санал байгаа юм. Түрүүн бас гишүүд хэлж байсан энэ төрийн мөнгө гэж байхгүй, аймаг, сумдын мөнгө гэж байхгүй татвар төлөгчдийн мөнгө л гэж байгаа. Тийм учраас татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулах явдал ялангуяа орон нутагт их байна. ОНӨҮГ, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит тийм юм гээд байгуулаад байдаг ийм асуудал сүүлийн үед олширлоо. Энэ нь өөрөө олон хууль тогтоомжуудыг

зөрчиж байгаа юм. Хамгийн наад тал нь Хэмнэлтийн тухай хуулийг зөрчөөд л ингээд л явж байна.

Хоёрт нь гэвэл энэ байгуулагдаж байгаа орон нутгийн үйлдвэр, энэ аж ахуйн нэгж, энэ компаниуд чинь улсын төсвийнхөө байгууллагад агентлагуудтайгаа давхардчихсан яг ижилхэн чиг үүрэгтэй газруудыг ингээд аймагтаа байгуулаад л явж байдаг. Нөгөө төсвийн мөнгийг хэмнэнэ гэдэг, татвар төлөгчдийн мөнгийг хэмнэнэ, үр ашиггүй зарцуулахаас сэргийлнэ тэрийг харж байдаг танай орон нутагт байдаг аудитын байгууллагууд юу хийгээд байдаг юм? Иргэдийн хурал жилдээ 4 удаа хуралддаг болсон. Улирал болгон хуралдана. Тэн дээр улирал болгон л шинэ ОНӨҮГ байгуулаад л яваад байгаа. Тэгээд танайхыг хараад л байж байгаа. Иргэдийн хуралд нь ороод дүгнэлт, зөвлөмжөө өгөөд л явж байна. Ямар арга хэмжээ авдаг юм мэдэгдэхгүй.

Нөгөөтээгүүр орон нутгийн энэ олон өмчит үйлдвэрийн газар чинь аж ахуйн нэгжүүдтэйгээ бизнесийнхэнтэйгээ давхцаад байна. Тэдэнтэй энэ төр нь өрсөлдөөд байна. Тэгэхлээр яаж энэ бизнес эрхлэгчид чинь цаашаа амьдрах юм, яаж үйл ажиллагаагаа явуулах юм? Нөгөө төр чинь би бизнес эрхлэгч, аж ахуйтайгаа өрсөлдөхгүй гээд байдаг чинь хаана байгаа юм? Тэгээд энийг чинь танайхан хараад байж байгаа биз дээ? Тэгээд энэ дээр яагаад өнөөдрийг хүртэл чимээгүй, дуугүй яваад байгаа юм? Орон нутгийн өмчит эмнэлэг ч байгуулагдаж л байх юм, сургууль ч байгуулагдаж л байх юм. Сэргээн засах асрамжийн газар гээд л Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төв гээд л ингээд л төрийн өмчөөр, төсвөөр ингээд байгуулаад л өчнөөн олон орон тоо батлаад л.

Тэгээд л урсгал зардал дээр нь нэмж өгөөд тэгээд ийм замбараагүй ийм юмнууд байгааг яаралтай дараагийн эхний он гараад эхний аймгийн ИТХ хуралдахаас өмнө та бүхэн он гараад хамгийн эхэнд энэ орон нутгийн өмчит энэ замбараагүй үйлдвэрийн газруудад аудит хийж, тэр зохих шаардлага юмнуудыг нь өгч, зогсоохыг нь зогсоож, өөр хууль зөрчөөд явж байгаа нөхдүүдийг энэ томилдог барьдаг албан тушаалтанд нь санал, зөвлөмжөө хүргүүлж, төсвийг үрэлгэн зарцуулсан гэмт хэргийн шинжтэй бол Төсвийн тухай хууль зөрчсөн бол тэр хууль хяналтын байгууллагууд нь өгөх ийм ажлуудыг хийж эргэж мэдэгдэх хэрэгтэй байна гэж.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Сая бид нар асуулт, санал гээд явсан. Тийм одоо үг хэлэх байгаа.

Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулга болон аудитын сэдэвтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Түвшин гишүүн.

Б.Түвшин: Ер нь сэдвүүдийг дэмжиж байна Аудитын хийх. Энэ 13, 14 дээр байгаа газрын тосны салбарын 2 аудитыг миний харж байгаагаар санхүүгийн тайлагналын аудит гэж би хараад байх юм. Тэгэхлээр ер нь энэ газрын тосны асуудал дээр үйлдвэрийн төслийн гүйцэтгэл тэгээд үр дүнгийн гүйцэтгэлийн аудит болгоод өөрчилчхөөч гэдэг саналыг хэлэх гэсэн юм. Одоо энэ газрын тосны үйлдвэр маань яг хэзээ ашиглалтад орох юм, хэдэн хувьтай явж байгаа вэ, энэ зээл, санхүүжилтийн асуудал нь яаж явж байгаа вэ гэдэг энэ бодит үр дүн, гүйцэтгэлийг гаргахгүй бол санхүүгийн тайлангаар бид нар яг зөрчлийн асуудал л

гарч ирэх л юм байж болох л юм шиг харагдаж байна. Тэгэхлээр энийг тийм өөрчлөх саналтай байна гэдгээ хэлье.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн нэрээ татлаа. Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Би энэ урьдчилсан, төлөвлөсөн байдал дээр урьдчилсан хяналт хийнэ гэж байгаа дээр их эргэлзэж байна. Ялангуяа Туулын ордны зам гээд. Энэ асуудал чинь өөрөө сэдвийн хүрээнд давхцаад байгаа байхгүй юу Магнайсүрэн даргаа. Та хэд байна шүү дээ бодлогоор гүйцэтгэхээр сонгосон 9 сэдвийн 1 нь буюу төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламж, зураг төслийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гээд хийчихсэн. Тэгээд яагаад ингэж онцолж яг ийм ойлгомжгүй байдал руу оруулах гээд байгаа юм? Та нар хэрэгжиж байгаа мега төсөл болгон дээр ингээд татаж хэрүүл хийх үү? Энэ чинь ажил явуулахгүй гэсэн санаа. Ийм зүйл байж болохгүй ээ. Энийгээ хасах хэрэгтэй. Энэ ерөнхий хүрээндээ юмаа хий л дээ.

Тэгээд одоо энэ дээрээс ингээд баахан ямар экспертүүд нь ажиллах бол болно, болохгүй гээд баахан зураг хийчихсэн компаниудта. Ийм хоёрын хооронд ийм явцуу эрх ашиг буюу цаана нь юу болоод байгаа юм? Энэ хэний захиалга юм? Энэ зүйлээ хас шулуухан л хэлье дээ. Тэгээд энэ 4 дэх сэдвийнхээ хүрээнд энэ асуудлаа хий л дээ. Төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламж, зураг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гээд энэ дээрээ л хий.

2 дугаарт, энэ ТӨК-удын хуулийг Улсын Их Хурал дээр батлах асуудал хоцрогдож байгаа учраас энэ асуудлын л юм яригдаад байна. Маш олон жилийн дүгнэлт, шийдвэртэй. Аудитын дүгнэлтүүд ч гарч байсан, хянан шалгах тодорхой ажлын хэсгүүд ч гараад явж байсан. Тэгэхээр энэ бараг энэ аудитын сэдвээсээ энийг ярих гэхээсээ илүүтэйгээр Улсын Их Хурал бид нар энэ дээр өргөн баригдчихаад байгаа Нийтийн өмчийн хууль болон тэр төрийн өмчийн компанийн хуультай холбоотой хуулийн төслийг л яаралтай баталмаар байгаа юм. Би бас Төсвийн байнгын хорооны даргад хэлж байна. Энийг бас Даргын зөвлөлд ярьж болдоггүй юм уу? Би уг нь ажлын хэсгийг нь ахлаад явъя л гээд байгаа. Тэгээд ажлын хэсэг нь ингээд 21 оноос хойш хэвтэж байна шүү дээ. Тэгээд батлуулдаггүй тэгээд л жил жилийн аудитын сэдэв дээр яригдаад л байдаг.

2 дугаарт, энэ Засаг захиргаа нэгжийн тухай хуулийг батлахдаа аймаг, нийслэлийн Иргэдийн хурлын төлөөлөгч нар олгодог байсан жижигхэн урамшуулал ч гэсэн байхгүй болонгуут энэ орон нутгийн өмчит компаниуд чинь зах замбараагүй байгуулагдаад байгаа юм. Энэ хүмүүс чинь сонгуульд орохдоо бас тодорхой хэмжээний мөрийн хөтөлбөр дэвшүүлж орсон. Тэгээд та нар төрийн албан хаагч биш урамшуулал авч болохгүй, цалин авч болохгүй гэхчихсэн. Тэгэхээр энэ чинь үйл ажиллагаагаа яаж явах юм? Орон нутгийн тэр иргэдийн хурал гэдэг чинь бас байнгын үйл ажиллагааны шинжтэй болчихсон юм шүү. Хуучин шиг бас тэргүүлэгч сонгоод орхих ямар ч бололцоогүй.

Яагаад гэхээр энэ олон хуулиудаар хэм хэмжээг батлах асуудлыг орон нутаг руу шилжүүлээд байгаа юм. Энэ хүрээндээ энэ хүмүүс чинь бас ингээд үйл ажиллагаа явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ засаглалын гажуудал гарчхаад байгаа юм. Тэгэхээр энэ орон нутгийн өмчит компаниуд байгуулагдаад байгаагийн цаад шалтгаан нь Засаг захиргааны нэгжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр гарсан энэ бодлогын алдаанаас болсон. 2 дугаарт энэ төрийн болон орон

нутгийн өмчит компанийн хуулийг батлуулж чадахгүй байгаа учраас гарч байгаа юм. Тэгэхээр энийг ингээд бас уялдуулаад уг нь яримаар байгаа юм. Тэгэхдээ энийг бас санаа аваач л гэж хэлж байгаа юм.

Ингээд энэ төрийн чиг үүргийн давхардлын асуудлыг яваад энэ төр өөрөө хэмнэлттэй бөгөөд цомхон ажиллах энэ бололцоог нь аудитаас л хэлж өгмөөр байгаа юм. Өнөөдөр энэ Засгийн газрын бүтэц дээр ажиллаж байгаа хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн статусыг ойлгохгүй явж байна шүү дээ. Уг нь яамны доор ажиллаж байгаа болон хэрэгжүүлэгч юм байгаа юм. Яамгүй агентлагууд чинь тохируулагч юм байгаа юм. Одоо ингээд шоу нь юу вэ гэхээрээ хэрэгжүүлэгч яг тохируулагч болохоор супер юм хийх гээд байна гээд.

Тэгээд дээр нь яам нь байхгүй учраас хагас бодлогын шинжтэй магадгүй удирдлага нь улс төрийн албан хаагч толгойлж болох ийм хэмжээний агентлагуудыг бусад оронд тохируулагч агентлаг гэдэг байхгүй юу. Дэд сайдын rank-тай хүн удирдаж болдог. Дээрээ яамны сайдтай газруудыг чинь яам буюу тэр нь Засгийн газрын гишүүнээр тэргүүлж байгаа тохиолдолд хэрэгжүүлэгч агент байдаг. Бид энийгээ ойлгоогүй 30 жил явсан шүү дээ. Энэ чиг үүргийн давхардлууд энэ дээр байна. Жишээ нь газрын асуудал 8 газар байна. Эдийн засаг, худалдааны асуудал 4, 5-н яамнууд дээр байна. Энэнээсээ бид нар уг нь чиг үүргийн давхардал бүх юмыг хийвэл энэ үндсэндээ аудит.../минут дуусав./

Н.Наранбаатар: Жаргалсайхан гишүүн үг хэлнэ.

Д.Жаргалсайхан: Сэдвүүдийг дэмжиж байгаа юм. Сэдвүүд дээр нэмэх асуудлууд байна. Энэ Шинэ хоршоо хөтөлбөрийг оруулж ирэх ёстой. Тийм, энэ том төслүүдийг аудит хийгээд ер нь эхнээс юмыг баталгаажуулаад явах нь хаа хаана зөв шүү дээ. Бид нар төрийн мөнгө гэж байхгүй. Татвар төлөгчдийн мөнгө л гэж байгаа. Тийм учраас энэ татвар төлөгчдийн мөнгийг тэр их том төсөл, том зүйлүүд рүү орох тусам хянаж байх ёстой.

Дээрээс нь энэ орон нутагт энэ өмчит, энэ төрийн өмчит энэ компаниудыг заавал үр өгөөжийг нь тэгээд бас манай гишүүдийн гарч байгаа саналтай яг ялгаа байхгүй яг хувийн хэвшилтэй өрсөлдөх тийм нөхцөлийг л бүрдүүлж болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тал дээр нь татвар төлөгчдийн мөнгийг тэгж үрэлгэн загнаж болохгүй. Энийг бүүр онцгойлон та анхаарч яг ямар ажил, арга хэмжээн дээр оруулах юм, оруулаад ирээч ээ.

ТӨК-уд энэ алдагдалтай ажиллаад байгаа асуудал байгаа юм. Ашигтай ажиллах бүрэн бололцоо байгаа юм тээ? Тэгэхээр энэ тал дээр бас тусгайлан бүүр яг төрийн өмчит, орон нутгийн өмчит компаниудын үр ашгийн тал дээр санал оруулж ирж гэсэн ийм санал байна.

Нийслэл дээр тэр хэсгийн ахлагч гээд бүүр нэр зааж байгаад оруулмаар байна. Хэсгийн ахлагч. Энэ чинь өөрөө юу хэлж байна вэ гэхээр ухуулагч л байгаад байна шүү дээ. Нэг нам 4 жил ухуулга хийчхээд сонгуульд ороод байна. Бусад энэ намууд нь, жижиг намууд нь ямар ч ухуулагчгүй энэ чинь ямар байдал юм? Шударга сонгууль мөн юм уу, энэ ардчилсан орон мөн юм уу? Бид нар ийм л юм ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь өөрөө маш том ноцтой асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэ асуудлыг тусгайлан оруулж ирээч гэсэн ийм саналуудыг хэлэх гэсэн юм.

Тэгээд та бүхэн бас энэ саналуудаа нэгтгээд хэзээ санал хураалгах юм? Би саналаа нэгтгэж санал хураалтад ормоор байна. Тэгэхгүйгээр бидний хувьд санал орохгүй бол ийм байдлаар санал хураалтад орохгүй. Ийм санал хэлэх гэсэн юм. Тэгээд хэдүүлээ бас ажлаа хаа хаанаа хийсэн шиг хиймээр байна шүү дээ. Одоо энэ Байнгын хорооны хурал дээр хар л даа Ардчилсан намынхан л ирц бүрдүүлж байна шүү дээ. Тийм, яг үнэндээ бид нар яг энэ улс төржсөн ийм увайгүй төсвөө хянан шалгахгүй бол энэ асуудлыг батлахгүй. Тэр тусмаа нийслэлийн хэсгийн ахлагчийг. Энийг зогсоох ёстой. Ийм замбараагүй татвар төлөгчдийн мөнгийг үрдэг. Тэгээд намын ажил хийдэг. 4 жил хийдэг энэ ажлаа таслан зогсоох ёстой. Ийм байна.

Н.Наранбаатар: Санал гаргаж байгаа гишүүд зарчмын зөрүүтэй саналын хуудсаар саналаа гаргана. Тийм наана чинь нэмээд л санал хураачихна шүү дээ. Тийм. Үгүй одоо ингээд.

Төрийн аудитын байгууллагын 26 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаар гишүүд үг хэлж дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналууд гишүүд гаргаж байгаа. Тэн дээр санал хураах учраас гишүүд Байнгын хорооны хуралдаа орж ирнэ үү.

Тийм энэ 1 хуудсан дээр бүгдийг нь бичиж болохгүй юм байна. Тус тусад нь санал хураалгах учраас тус тусдаа. Нийслэл хийнэ шүү дээ.

Эхнээс нь Сайнзориг гишүүнийх зарчмын зөрүүтэй санал ирсэн байна. Саналын томьёолол нь. Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийн 9-д тусгагдсан Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал сэдэвт аудитын сэдвийг хасах.

Энэ нь төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламжийн зураг, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гэсэн 4-тэй давхцаж байна. 4 дэх асуудалтай давхцаж байгаа юм байна. Ийм тайлбартай юм байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Магнайсүрэн дарга энэ дээр тодруулаадхаач.

С.Магнайсүрэн: Саяын санал дээр манайх ер нь ажил саад болох талаасаа биш ер нь урьдчилсан аудитын анхны ийм юу л туршилт хийж эхэлье л гэж оруулсан юм. Ер нь гишүүд яавал энийгээ хасчихад бид нарт ямар ч асуудал байхгүй. Тэх. Үгүй үгүй тэр чинь байна шүү дээ яг зураг төсөв хийж магадалж байгаа төрийн байгууллагын тогтолцоо руу нь л орж байгаа юм. Тэгэхгүй бол бид нар хувийн компани бүгд юм руу бүх зураг төсвийг угаасаа үзэж барахгүй. Тогтолцоо руу нь л орж байгаа юм. Бодлого руу. Энийг хасвал хасаж болно. Тэрийг та хэд шийдчих дээ. Асуудалгүй.

Н.Наранбаатар: Ингэе саналаа хураагаад явъя. Өөрсдөө ингээд дэмжих нь дэмжээд, дэмжихгүй нь дэмжихгүй. Чөлөөтэй. Санал хураалтад бэлтгэе гишүүд. Гишүүд санал хураалтын томьёоллыг түрүүн уншиж танилцуулсан. Одоо гишүүд бэлэн болсон уу? Бэлтгэчихсэн, санал хураалтад бэлтгэгдсэн. Одоо санал хураалт. Ороогүй гишүүн байна уу? Бүгд санал хураалтад бэлтгэгдсэн үү? Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Дахиад уншаадахъя. Анхааралтай байгаарай. “Бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийн 9-д тусгагдсан Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал сэдэвт аудитын сэдвийг хасах”. Энэ нь төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга байгууламжийн зураг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн гэсэн 4 дэх заалттай давхцаж байгаа болно гэж байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор.

16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал “Үндэсний аудитын газраас нийслэлийн үйл ажиллагаа, төсөв дээр аудит хийлгэх”. Санал хураалгах болсон үндэслэл нийслэлийн төсөв, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх гэсэн. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Ийм зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор.

5 номер тайлбар хэлье.

С.Магнайсүрэн: Энэ санал дээр түрүүн гишүүд нэлээн асуугаад бид хэд нэлээн ярьсан. Ер нь хуулиараа Үндэсний аудитын газрын эрх хэмжээ, орон нутаг буюу аймаг нийслэлийн төрийн аудитын байгууллагын эрх хэмжээ гээд ингээд заагдчихсан. Тэгэхээр энэ хүрээнд би түрүүн шийдлийг нь ажлынхаа тогтолцоо, зохион байгуулалтаар бид нар энэ нийслэлийн аудит дээрээ анхаарчихъя гэдэг энэ зарчмаараа явахгүй бол одоо энэ яг хураагдах саналын томьёолол бол хууль тогтоомжид нийцэхгүй байгаа учраас энийг би Цогтбаатар гишүүнийг бас анхаарчхаач ээ, татаад авчихвал гэсэн ийм тайлбар хэлмээр байна. Манайх төвөөсөө нийслэл рүүгээ.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн саналаа татаад авчихлаа. Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл, түүний үр дүн, үр өгөөж. Эндхийн зээл хэр өгөөжтэй байгаа, үйлдвэр хэзээ ашиглалтад орох үндэслэлээр ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Саналын томьёолол нь болохоор “газрын тосны үйлдвэр ашиглалтад орох хугацаа тодорхойгүй, зээлийн ашиглалт, үр дүн тодорхойгүй байгаа тул” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин.

Энэ дээр тодруулга хэлэх үү? 5 номер.

С.Магнайсүрэн: Энэ манайх ингээд 12 сарын 20 гэхэд хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжиж байгаа гаднын зээл, тусламжийн, төсөл, хөтөлбөрийн үр ашиг, санхүүжилт дээр нь ингээд сэдвээр энэ 25 оны сэдэв тусаад хугацаа нь энэ 20-н юм. Тэгэхээр бид нар энэ хүрээнд уг нь үзээд ороод ирчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдхэн хоногийн дараа ингээд ороод ирэх учраас би энийг, энэ сэдвийг дэмий болов уу л гэж бодож байна л даа. Яагаад гэвэл энэ үзэгдчихсэн энэ танилцуулагдана тайлан нь. Тэгээд энэ Байнгын хороогоор хэлэлцэгдэнэ. Гүйцэтгэлийн аудит.

Н.Наранбаатар: Тэгвэл Түвшин гишүүн зарчмын зөрүүтэй саналаа татаж авлаа.

Дараа нь “гаднын нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжиж хэрэгжиж байгаа төрийн албан төсөл, арга хэмжээнд аудит хийх”.

Хэрэгжиж буй төсөл арга хэмжээний төсөвт өртөг хэт өндөр байгаа. Саналын томьёолол. “Гадаадын нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд гүйцэтгэх аудит”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батболд. Тодруулаарай, тайлбар хэлээрэй.

С.Магнайсүрэн: Саяын ер нь саналтай яг энэ хүрээнд л бид нар нөгөө бүх гаднын зээл, тусламжийн бас хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдээр санхүүжилт хийгээд одоо энэ 12 сарын 20-нд асуудал маань ороод ирэх учраас энэ хүрээнд 900-гаад төсөл, арга хэмжээ байгаа нийтдээ. Тэгэхээр энэ хүрээнд ингээд ороод ирчхэж байгаа учраас ирэх жил сэдэв нэмэх шаардлагагүй байх. Гишүүний яриад байгаа асуудлууд энэ хүрээнд хөндөгдөөд үзэгдээд ороод ирэх учраас би энэ саналыг бас хэрэггүй байх л гэж, гэсэн ийм саналыг.

Н.Наранбаатар: гишүүн.

Р.Батболд: Одоо нөгөө 20-нд орж ирэх юм байна шүү дээ тийм үү? Тэгэхдээ энэ чинь яг одоо нийслэл дээр явж байгаа энэ төсөл, арга хэмжээнүүд чинь бүгдээрээ яг хамрагдаж чадсан юм уу? 900 гээд байгаа чинь ерөөсөө бүгдээрээ хамрагдаж чадсан юм уу л гэж асуух гээд байгаа юм. Тэгээд яг тэр дээрээ дүгнэлт маань бас ямархуу гарч байгаа юм бол? Би хамгийн гол нь тэр төсөвт өртөгтэй холбоотой юман дээр л санаа зовоод байна. Маш их өндөр гараад байдаг. Тэгээд энэ талын юм нь явж байгаа юм уу? Эс үгүй бол санхүүжилттэй нь холбоотой ч байдаг юм уу тиймэрхүү аудитын дүгнэлт энэ тэр орж ирэх юм болов уу яах юм бол? Тэгээд би яг дүгнэлтийг нь мэдэхгүй байгаа учраас л асуугаад байна л даа.

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Энэ сэдвийн хүрээ нь яг сэдэв нь ингээд батлагдсан учраас бүх төсөл, арга хэмжээ орж байгаа. Жишээлбэл түрүүн та хэлсэн Солонго 1, 2 энэ тэр гээд л эд нар хүртэл яваа. Тийм учраас яг таны юу яасны дагуу гүйцэтгэл, үр дүн нь ийм сэдвээр орж ирж байгаа учраас бүх зүйл орсон гээд ойлгож болно. Орж байгаа.

Н.Наранбаатар: Батболд гишүүн татаж авсан.

Дараагийнх нь “Шинэ хоршоо хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээлийн эргэн төлөлт, мал аж ахуйн салбарт гарсан чанарын үзүүлэлт, нөлөө”.

Томьёолол, ““Шинэ хоршоо”, “Чинээлэг малчин” хөтөлбөрийн зээл, зарцуулалт, эргэн төлөлт, мал аж ахуйн салбарт гарсан чанарын үзүүлэлт, үр нөлөө”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар. Тайлбар байгаа юу? 5 номер.

С.Магнайсүрэн: Энэ дээр сэдвийн хувьд бид нар Ганбаатар гишүүн зөвшөөрвөл уг нь би аймаг, нийслэлийнхээ аудитын газрынхаа төлөвлөгөөнд суулгах нэг хувилбар байж болж байгаа юм. Тэгээд тэр бүгдийг нь хийлгэсний дараа бид нар нэгтгээд Байнгын хороонд авчраад явалал би тэндээ төсөв,

төлөвлөгөөндөө оруулах нэг хувилбар байна. Энийг гишүүн бас нэг бодолцож үзвэл.

2 дугаарт, өнөөдрийн байдлаар манай хүн, өдрийн тооцоогоор нийтдээ бид нар энэ 9 сэдвээр нийтдээ энэ 27 сэдвээр үзэхэд л бид нар 7538 хүн, өдрөөр дутмаг болчихоод байгаа юм. Тэгээд бид нар бүх хүч, нөөц бололцоо юмаа л дайчилна гэдэг хамгийн сүүлийн шавхаж ингэж орж ирсэн нэг ийм хувилбар байгаа. Тэгээд гишүүний юугаар тэгээд зүгээр тайлбар бол ийм байна. Зүгээр нэмнэ гэвэл сэдвээ яагаад өөр сэдэв хасагдаагүй байгаа учраас жоохон.

Н.Наранбаатар: Санал гаргасан гишүүн тайлбар хэлж болно. Ганбаатар гишүүн. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Яах вэ би ерөнхий аудитын тайлбарыг эхний ээлжид орон нутаг дахь аудитын байгууллагуудаараа тухайн орон нутгийн нөхцөл байдал, зээл олголт, эргэн төлөлт, зарцуулалт, үр дүн. Гол нь энэ зарцуулалт чинь маш чухал байгаа юм шүү дээ. Өнгөрсөн, өчигдөр Гаалийн дарга ярьж байна лээ та нар анзаарсан бол өнгөрсөн тэр 24 оны импортоор орж ирсэн машин ямар их огцом өссөн 120 мянга гарсан байна лээ шүү дээ. Тэгээд сая энэ юунаар ингээд буцаад уначихсан.

Тийм учраас гаалийн татвар, бүрдүүлэлт бас бага байгаа гэж. Тэгэхлээр яах вэ энэ Шинэ хоршоон дээр тэр зарцуулалт дээр нь орон нутаг нь хэрвээ үнэхээрийн хийчхээд та бүхэн нэгтгээд явбал болж байна. Үүнийхээ дараа хэдүүлээ нэгдсэн байдлаар ер нь энэ их олон их наядын, энэ чинь 5 их наядынх. Дээрээс нь 848 тэрбум төгрөг одоогийн байдлаар зээл олголт гарчхаад байна.

Гэтэл яг нөгөө хоршооллын салбартаа яг юм хийх малчдадаа очоогүй мэдээлэл бид нарт ирээд байна. Тийм ч байгаа бодит байдал дээр. Машин болсон, хурдан морь болсон. Тэгээд энэ чинь эргэн төлөлт нь дөнгөж 4.7 хувьтай 48 тэрбум төгрөгийн эргэн төлөлт байна шүү дээ. 848 тэрбум төгрөг зээл гарчхаад 48 тэрбум төгрөгийн эргэн төлөлттэй байна гэдэг бол энэ анхаарах асуудал мөн үү? Мөн. Тэгээд саналын хувьд дэмжиж байна. Ерөнхий аудиторовын санал болгосноор орон нутгийнхаа аудитууд, аймаг, орон нутгийн аудитууд гүйцэтгэснийх нь дараа ирэх оны төсөв дээр нэгдсэн байдлаар бас ярилцаж болох юм гэж бодож байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тэгвэл саналаа татаж авлаа.

Дараагийн санал Улаанбаатар хотын хэсгийн ахлагч нарын цалинтай холбоотой. Улаанбаатар хотын хэсгийн ахлагч нэртэй 1950 хүн Монгол Ардын намын ухуулагчийн ажил хийж байгаа нь Шударга өрсөлдөөний хууль зөрчиж байна.

Саналын томъёолол, “Улаанбаатар хотын хэсгийн ахлагчийн цалин олгохыг зогсоох”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан. Тайлбар 5 номер.

С.Магнайсүрэн: Энэ асуудлыг одоо хийгдэж байгаа манай завсрын аудит юмнуудын санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд үзээд тэгээд бид нар энэ танд тодорхой мэдээлэл өгч болж байна. Жилийн 2 сард орох нөгөө жилийн эцсийн юугаар ч үзэж болно. Энэ санхүүгийн аудитын хүрээнд энийг шийдчих асуудал.

Тийм учраас гүйцэтгэл, нийцлийн хүрээнд тусгайлсан бодлогын сэдвээр хэрэггүй байх. Энийг тусад нь би ингээд тусгайлан бүүр танилцуулах ийм бололцоотой. Сэдэв батлах биш зүгээр л энд яригдсан учраас бид анхааралдаа аваад тусгайлан авч үзээд ингээд танилцуулбал ямар вэ гэсэн ийм санал байна.

Н.Наранбаатар: Жаргалсайхан гишүүн тайлбар.

Д.Жаргалсайхан: Энэ зааланд олон намын төлөөллүүд сууж байна. Тэгээд бид нар шударга өрсөлдөөн, энэ ардчилал, хүний эрх чөлөө, сонгох, сонгогдох эрхээ эдэлж чадахгүй байна. Тэр тусмаа нийслэл дээр. Тэгээд энэ нь бол яг нэг халхавч нэртэй хэсгийн ахлагч гээд баахан улсууд ингээд 4 жил ингээд ажиллуулчихсан. Бид нар ингээд ямар ч төсөв мөнгө байхгүй, сонгууль гэхээр л ингээд давхиад ордог бэлтгэл хангачихсан ийм төрийн механизмтай тулдаг. Тэр ч үүднээсээ энэ нь ингээд үр дүнгээ өнөөдөр ингээд үзүүлдэг. Нийслэл дээр бусад жижиг намууд үнэхээр сонгуульд оролцох бололцоогүй болдог. Тийм учраас энийг яг санал хураалгамаар байна.

Н.Наранбаатар: Санал хураалгая гэсэн саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Улаанбаатар хотын хэсгийн ахлагч нарын цалин олгохыг зогсоо. Энэ чинь томъёоллыг нь дараа нь арай өөрчилж болох Улаанбаатар хотын хэсгийн ахлагч нарын цалин хөлс олголтын байдалд аудит хийх гэдэг тийм томъёоллоор найруулгын томъёоллоор санал хураая. Дэмжиж байна гэсэн томъёоллоор санал хураана. Энэ чинь бэлдэх билүү эхлээд. Санал хураалтад бэлдчихсэн байна. Санал хураалт.

44.4 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Одоо орон нутагтай холбоотой. Одоо, дараа нь санал хураалттай шүү гишүүд ээ тогтоолын төсөл батлах.

Дараагийн санал нь тэр миний гаргасан санал ОНӨҮГ-ын үйл ажиллагаа, үр өгөөж түүнийг яаж явах вэ? Тэн дээр тайлбар өгөөдөх.

С.Магнайсүрэн: Наранбаатар гишүүний асуултад тайлбарлая. Орон нутгийн өмчит компаниуд ингээд аймгууд дээр бас мэр сэр, зарим газар нэлээн нэлээн хэдэн ахиу тоотой ингээд байгуулаад байгаа ийм асуудлууд байгаа юм байна лээ. Тийм учраас бид нар аймаг, нийслэлийнхээ 2 төрийн аудитын байгууллагын 2026 оны төлөвлөгөөнд бүх аймгууд дээр орон нутгийн өмчит болоод бусад ийм аж ахуйн нэгж байгууллага байгуулагдаж байгаа болон төвийн хуулийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг давхардаж тэр орон нутагт байгуулагдаад байгаа энэ асуудлуудаар сэдэв батлахаар ингээд тохиролцчихсон байгаа. Тийм учраас тэрийг нь нэгтгээд бид нар Төсвийн байнгын хороондоо танилцуулчих бололцоотой учраас манай том төлөвлөгөөнд орчихно оо гэж ойлгож болно. Түрүүн би бас тэгж тайлбарласан байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэсэн аудитын сэдвийн талаар гишүүд үг хэлж дууслаа.

“Аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Одоо санал хураалт. Санал хураалттай тул Байнгын хорооны гишүүд танхимд орж ирэхийг хүсье.

Гишүүд орж ирж байтал дараагийн асуудалдаа ороод явж байя. Танилцуулгаа эхэлж байя.

14.47 цаг

4 дэх асуудал. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өмнөх хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн өмнөх бүрэлдэхүүн хэвээрээ байна. Нэмээд Юрагийн Энхтуяа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер. Бусад нь хэвээрээ.

Төсвийн байнгын хорооны 2024 оны оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 05 тоот тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан. Энэхүү тогтоолд өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Ерөнхий аудитораас 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 3007 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлснийг Байнгын хорооны гишүүдэд цаасаар болон цахимаар хүргүүлсэн байгаа.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэвт өөрчлөлт оруулах тухай саналыг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэнгийн микрофон 5 номер.

С.Магнайсүрэн: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталж, тогтоолын хавсралтаар нийт 42 сэдэв баталж өгснөөс хуулийн дагуу гүйцэтгэх 18, төрийн аудитын бодлогоор гүйцэтгэх 24 сэдэв баталж өгсөн.

Өнөөдрийн байдлаар хэрэгжилтийг үнэлж үзэх юм бол нийт 42 сэдвийн 3 сэдэв, 4 сэдэв дээр бас Төсвийн байнгын хороогоор шийдүүлэх асуудал байна гэж үзэж бид өнөөдөр танилцуулгыг хийж байгаа.

1 дүгээрт, аудит гүйцэтгэх боломжгүй болсон 1 сэдэв байгаа учраас үүнийгээ танилцуулъя.

Гадаадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын санхүү, тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг төсөв, санхүүгийн боломжгүйн улмаас гүйцэтгэх боломжгүй болж байгаа. Манай байгууллагын 2025 оны төсвийн тодотголоор 5.9 тэрбум төгрөг хасагдсан. Үүнээс гадаад томилолтын зардал, мөн бусад зардлууд хасагдсантай холбогдуулаад бид энэ сэдвийг гүйцэтгэх боломжгүй болсон учраас энэ сэдвийг хасаж өгөөч гэж ингэж асуудлыг Төсвийн байнгын хороодоо танилцуулж байгаа.

2 дугаарт хасуулахаар 2 сэдвийг оруулж ирсэн. Нэг нь юу вэ гэхээр “Оюу толгой” компанийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн сэдэвт ийм сэдэв байгаа. Яагаад энэ сэдвийг оруулж ирж байгаа вэ гэхээр зэрэг Оюу толгой төслийн зээлийн ашиглалт, ашиглалтын үр дүн сэдэвт аудитыг тус өнгөрсөн онд бид нар хийгээд өнөөдөр энэ сэдвээр тайлангаа Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байгаа.

Ирүүлээд Төсвийн байнгын хороо хэлэлцээд энэ дээр мөрөөр нь авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг байгуулсан. Батжаргал гишүүнээр ахлуулаад. Ажлын хэсэг байгуулан ажиллаж байтал ингээд бас Хянан шалгах түр хороо байгуулагдаад дахиад өнөөдөр ингээд сонсгол хийгээд явж байгаа. Энэ Хянан шалгах түр хорооны шинжээч ажлын хэсэгт нь манай аудитор, шинжээч нар, дарга нар бас ингээд ажиллаад тэгээд өнөөдөр ингээд ид дундаа явж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэг, түр хорооныхоо ажлын үр дүнг үзэж байж дараа нь энэ сэдвийн асуудлыг ярья гээд бид нар энэ жил энэ сэдвийг хийгээгүй байгаа.

Ер нь бараг 21, 2 оноос эхэлж энэ сэдэв яригдаад тэгээд дунд нь КОВИД, цар тахлын үе таараад тэгээд дараа нь 2 жил бараг, 3 хагас шахуу гүйцэтгэж үр дүнг сая бид нар ингээд танилцуулсан ийм өргөн цар хүрээтэй ажил байгаа учраас дахиад энийгээ дуусаагүй байхад дахиад сэдвээр орох нь боломжгүй байгаа учраас энийг танилцуулж байгаа юм хасуулахаар.

2 дугаарт нь стратегийн ач холбогдол бүхий ТӨК-удын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл гэсэн ийм сэдвийг хасуулах саналаа бид нар хүргүүлсэн. Энэ нь 1 дүгээрт хууль тогтоомжид ийм стратегийн ач холбогдол бүхий ТӨК гэж байхгүй. Компанийн хууль болоод Ашигт малтмалын тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэсэн л ийм томъёолол байгаа юм. Тэгэхээр бид нар энэ цар хүрээгээ тогтоох, аудитынхаа хүрээг тогтоож чадахгүй.

Ингээд бид нар судалгаа хийж үзээд энэ “Эрдэнэс Монгол” компаниас судалгаа аваад стратегийн ач холбогдол бүхий компани биш харин стратегийн ач холбогдолтой ордыг эзэмшиж байгаа компаниудын юуг гаргаад ирэнгүүт ингээд 6 компани нь, орд нь 6 орд. Манай “Эрдэнэс Монгол” компанийн эзэмшилд байдаг юм байна. Тэгээд энэ 6 ордыг эзэмшиж байгаа компаниуд дээр бид нар 2017 оноос авхуулаад 2024 он хүртэл нийт 12 сэдвээр бид нар ингээд аудитыг хийгээд ингээд танилцуулчихсан байгаа юм. Тэгэхээр бид нар ингээд өмнөх асуудлууд, өмнө нь ингээд хийчихсэн байгаа учраас энэ сэдвийг бас хасуулъя гэсэн ийм саналыг танилцуулж байгаа.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” компани болоод “Эрдэнэт” үйлдвэр дээр бид нар жил болгон санхүүгийн тайлан, завсрын аудит ингээд цаглаварт хугацаандаа хуулийн хүрээнд ингээд явж байгаа учраас энэ сэдвийг хасуулъя гэж байгаа.

Нөгөө талаар бид нарын энэ 2 сэдэв хасуулах нэг үндсэн шалтгаан бол бид нарын 25 оны төсвийн тодотголоор төсөв хасагдсантай холбогдуулаад ийм явж ажиллах ингээд олон гадаад болоод дотоод томилолтууд тээвэр, шатахуун ийм зардлууд тэгээд хүний нөөц бас 9 хувь хасагдсан ийм шалтгаанууд байгаа гэдгээ гишүүддээ бас тайлбарлаж байгаа юм.

Гуравд нь энэ 2026 онд нэг саналыг шилжүүлээд бид нар сая түрүүн тодотгол тогтоолдоо оруулчихсан байж байгаа. Монгол Улсын Засгийн газраас

агаар, орчныг бууруулах чиглэлээр 21-24 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг бид нар 26 он руугаа шилжүүлээд хийчихье гэж байгаа. Энийг нөгөө тогтоолын төсөлд өмнөх хэлэлцэх асуудал дээр оруулчихсан байгаа учраас энийг шилжүүлэх ийм санал байгаа юм.

Ийм 4 саналыг л өмнөх жилийн нөгөө аудитын сэдвийн хэрэгжилтийн явцад Төсвийн байнгын хорооноос гаргасан тогтоол дээр 2-ыг хасуулъя, 1-ийг хойшлуулъя, 1-ийг шилжүүлъя гэсэн ийм саналыг бид нар гаргаж байгаа юм. Баярлалаа.

Н.Наранбаатар: Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэнд баярлалаа.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэвт өөрчлөлт оруулах асуудалтай холбогдуулан “Тогтоолд өөрчлөлт оруулах” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийн талаар асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгье.

Батболд гишүүнээр тасаллаа. Батболд гишүүн.

Р.Батболд: Энэ тогтоолын төсөл дээр чинь ерөөсөө 2 л орчихоод 2 л нэр яваад байгаа юм биш үү? Саяын яриад байгаагаар 4 сэдэв хасагдах гээд байна шүү дээ тээ? Дипломат алба дээрээс нь Оюу толгой гээд ингээд яриад 4 сэдэв ярьчих шиг болох юм. Тогтоолын төсөл дээр чинь 2 нь байгаад байгаа юм биш үү? Тэгээд хасах сэдэв дотор энэ яваад байгаа Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн гээд байгаа юм. Энийг яагаад хасах болчихов оо гээд. Энэ эс үгүй бол ирэх жилийн төлөвлөгөөнд байгаа юм уу? Одоо бид нар бас нэг юу билээ ямар сан билээ нэг сан байж байгаад л бас хэрэгт ороод баахан мөнгө төгрөг идэж уучихсан энээ тэрээ гээд нэг юмнууд яваад байдаг. Тэгэхээр энийг яагаад хасчхав гэдэг асуудал.

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Энэ 25 оны сэдвийг баталсан Төсвийн байнгын хорооны тогтоол дээр 2-ыг, 2 сэдвийг хасаж байгаа юм. Таны саяын хэлдэг агаар, орчны бохирдол бууруулахтай холбоотой сэдвийг болохоор бид нар ирэх жил буюу 26 онд бодлогоор гүйцэтгэх түрүүний ярьдаг 9 сэдвийн хүрээнд оруулчихсан. Шилжүүлээд оруулчхаж байгаа юм. Бүүр хасаагүй хойтон хийе гэж байгаа юм.

Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг уг нь жил бүр хийж байх ёстой боловч энэ жил боломжгүй болсон учраас хойтонг нь тусдагаараа бас сэдэв нь байгаа. Яг хасуулж байгаа 2 сэдэв нь тэр Оюу толгой юу 2 байж байгаа стратегийн ач холбогдол бүхий ТӨК-ийн үйл ажиллагаа гэсэн ийм 2 сэдвийг л хасахаар ийм санал танилцуулагдаж байгаа юм.

Н.Наранбаатар: Батболд гишүүн тодруулах уу? Батболд гишүүний микрофоныг.

Р.Батболд: Агаар, орчин гэж 3 дээр юм уу тэр уур амьсгалын юм уу аль юм бэ? Нөгөө ирэх жилийн төлөвлөгөөнд орчихоод байгаа гэдэг чинь яг хаана тусаад байгаа юм тэр агаар, орчинтой холбоотой асуудал нь? 1 дээр явж байгаа юм

байна тээ? Энэ тэгээд он нь хойшлоод л яваад байх юм байна тээ? 21-ээс 24 байсан чинь 22-оос 25 болоод. Энийг 21-ээс 25 гэж оруулахгүй юм уу ядаж тэгвэл. Тэгээд энэ цаглавар дээр чинь байсан уу энэ хаана яваад байна? Цаглавар дээрээ яг тэднээс тэдэн гэсэн нь яг хаана явж байна аа? Энийг хэлээд өгөөч.

Н.Наранбаатар: 5 номер.

С.Магнайсүрэн: Саяынх ингээд нөгөө бодлогын 9 сэдвийн 1 дээр байгаа. 26 оны 8 сарын 10-наас 12 сарын 18 гэсэн ийм хугацаатай Байнгын хорооны тогтоол дээр орж ирсэн байж байгаа. 22-оос 25 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн гэсэн ийм сэдвээр орж ирсэн байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийн талаар үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгье.

Үг хэлэх гишүүн алга.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.9.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Аудитын сэдэв батлах тухай Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн 2 бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв гэсэн зүйлийн Засгийн газраас агаар, орчны бохирдол бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн гэсэн 5 дахь хэсгийг, “Оюу толгой” ХХК-ийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн гэсэн 11 дэх хэсгийг стратеги ач холбогдол бүхий ТӨК-удын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл гэсэн 15 дахь хэсгийг тус тус хассугай.

Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Санал хураалт явж болохоор байна уу? Гишүүд танхимдаа орж ирье. Төсвийн байнгын хороон дээр санал хураалт явагдах гээд байна. Гишүүд танхимдаа орж ирье. Болохгүй юм байна. Заавал энэ хурууны хээгээр.

Ганзориг гишүүн Оюун толгойн түр хорооны хуралтай байгаа учраас ирцээс хуралдаа орох шаардлагатай байгаа учраас ирцээс хасаж өгнө үү гэсэн хүсэлт ирүүлсэн. Ирцээс хасъя.

15.08 цаг

Дараагийн асуудалд оръё. 5 дахь асуудал.

Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах сэдэвт нийцлийн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн ижилхэн.

Төрийн аудитын тухай хуулийн 33.6-д Монгол Улсын Ерөнхий аудитор энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 115.2.2-т төрийн санхүү төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ гэж заасан.

Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн 5 номер.

С.Магнайсүрэн: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл зүйл, 7 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 24 оны 12 сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах гэсэн энэ сэдэвт нийцлийн аудитыг гүйцэтгэж, тайлан, дүгнэлтийг үүгээр танилцуулж байна.

Тус аудитыг төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байдал.

2 дугаарт, төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцож төлөвлөхдөө холбогдох хууль, журам, норм, дүрмийн шаардлагад нийцүүлсэн эсэхэд чиглүүлэн гүйцэтгэлээ. Уг сэдвээр хийх аудитын төлөвлөгөөг 2025 оны 4 сарын 15-ны өдөр баталсан бөгөөд 163 төсөл, арга хэмжээнд аудитын горим хэрэгжүүлж, дүгнэлт гаргахаар баталсан боловч аудитыг гүйцэтгэх тайлагнах үе шатын хугацаанд 45 төсөл, арга хэмжээ нэмж ирүүлж, нийтдээ 208 төсөл, арга хэмжээ болсноос 185 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хянаж, 145 төсөл, арга хэмжээнд дүгнэлт гаргалаа.

Аудитын дүгнэлт гаргасан 145 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хянаж захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналын дүнгээс 163.1 тэрбум төгрөг буюу 31.3 хувь, магадлалаар баталгаажсан төсвийн дүнгээс 88 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар бууруулж, 68.7 тэрбум төгрөгийн үр өгөөжийг бий болгосон бөгөөд Их Хуралд нэг асуудлыг толилуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын даргад 2, Сангийн сайдад 1, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад 4 зөвлөмжийг тус тус өглөө.

Тус аудитын дүн, дүгнэлтэд үндэслэж Төсвийн байнгын хорооноос Засгийн газарт барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний төсөвт өртөг гүйцэтгэлд хийх дотоод аудит, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр тус Байнгын хорооноос чиглэл өгч ажиллах саналтай байна.

Товч танилцууллаа. Манай ажлын хэсэг дэлгэрэнгүй гишүүдийн асуултад дэлгэрэнгүй хариулахад бэлэн байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Магнайсүрэн даргад баярлалаа. Аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Гишүүд Мөнхсоёл гишүүн, Сайнзориг гишүүн, Пунсалмаа гишүүн, Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууна. Солигдсон Мөнхсоёл гишүүн одоо асуулт асууж, үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Энэ тайланг ирүүлсэнд баярлалаа. Тэгээд сая товчхон танилцаж сонслоо. Өмнө нь бас ирүүлчихсэн байсан, уншсан байсан. Ер нь бид нар бүгдээрээ мэдэж байгаа жил болгоны Үндэсний аудитын газрын тайланд угаасаа энэ хөрөнгө оруулалтын төслүүдийн гүйцэтгэл бага хувьтай тэгээд ялангуяа Аудитын газраас өгсөн зөвлөмжийн хувь маш бага гардаг. Энэ удаад улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсвийн аудитын дүгнэлтийн талаар бид нар ярьж байна.

Сая хэллээ 145 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудит хянаад 31.5 хувьтай буюу 163.1 тэрбум төгрөгийн нэмэгдэл нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээ байна гэж байна шүү дээ. Тэгэхээр та нар ингээд зөвлөмж гаргачихдаг ийм зөрчил, дутагдал жил бүр маш тогтмол давтагдаж байгаа. Энэ дээр та нараас гадна өөр ямар байгууллага, ер нь яаж энэ гаргаж байгаа зөвлөмж, дүгнэлтийг чинь хэрэгжүүлдэг болох вэ? Энэ тал дээр танай байгууллагын санал юу байна?

2 дугаарт нь үүнтэй ч холбогдоод ер нь жил жилийн Үндэсний аудитын гаргаж байгаа тайлантай ч холбогдоод энэ гаргаж байгаа зөвлөмжийн хэрэгжилт маш сул байгаа, байсаар ирсэн. Магнайсүрэн дарга саяхан томилогдсон. Одоо томилогдоод хэдэн сар болчхов оо? Түүнээс хойш та өөрөө юу хийв, ямар ахиц, өөрчлөлт байна гэж харж байна? Энэ тал дээр бас хийж байгаа үйл явцтай нь танилцъя гэж бодож байна. Ийм 2 асуулт асууя.

Н.Наранбаатар: Магнайсүрэн адарга хариулъя. 5 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Энэ яг энэ сэдвээр ингээд сая бид нар аудитын 26 оны сэдэв батлах яг энэ процесст сүүлийн 2 жилийн ийм сэдвээр 23, 24 онд юм уу, 23, 25 онд ийм 2 жил ийм сэдэв ингээд манай сэдэв дотор оруулж баталж өгсөн юм байна лээ. Тэгээд бид нар энэ сүүлийн буюу энэ жилийн 25 оны сэдвээр хийсэн аудитынхаа дүнг одоо танилцуулж байгаа юм. Энд ингээд бид нар 208 төсөл, арга хэмжээг бүхэлд нь авч

үзэж ингэж дүгнэлт гаргаж байгаа юм. Энэ асуудлын цаашид ингээд энэ асуудал ерөөсөө зогсохгүй үргэлжлэх шинжтэй ийм төлөвтэй.

Тэгээд 26 оны сэдэвт бид нар юу гэж оруулж ирсэн бэ гэхээр зэрэг бодлогын хувьд ерөөсөө энэ асуудлын тогтолцоо тэр асуудал үүсээд байгаа уг суурь руу нь орохгүй бол одоо Эрчим хүчний хөгжлийн төв, Замын хөгжлийн төв, манай Барилгын хөгжлийн төв энэ тэр гээд энэ нөгөө зураг төсөв зохиогоод төсвийг нь ингээд магадлалаар баталгаажуулаад тэгээд хариуцлагаа хүлээдэг энэ газруудын хариуцлага байхгүй болчихоод байна. Тэгээд бид нар аваачаад ингээд энд өөрсдөө энд ингээд юм яриад суух хэмжээнд ирчхээд байгаа байхгүй юу. Хууль нь байгаад байдаг цаанаа хариуцлага байдаггүй.

Тэгэхээр бид нар энэ зураг төсөв зохиож байгаа, магадалж байгаа тэр тогтолцоо руугаа оръё гэдэг сэдвээр сая энэ 26-ны оны сэдэвт тийм сэдэв орж ирсэн байгаа. Тэгэхээр бид нар цаашид энэ уг сурвалж руу нь нэлээн тийм нухацтай орж, яагаад гэвэл сүүлийн 2, 3 жил хийсэн юмнаасаа бид нар зөвлөмж юмнууд өгөөд л байдаг үр дүн нь гарахгүй байгаа учраас энэ рүү нь сэдэв баталж ингэж бодлогоор орж байгаа.

2 дугаарт нь шийдвэрийн хэрэгжилт сул байна гэдэг дээр бас асуудал байгаа учраас бид нар энэ дээр бүүр тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Ер нь энэ аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага бол шийдвэрийн хэрэгжилт дээрээ онцгой анхаар гэдэг ийм зөвлөмж, уриалгууд гаргачихсан. Бид нар харин энийг нь шинэ бүтэц, зохион байгуулалтаараа бий болгоод тэгээд бүх дата, анализаа гаргаж аваад цаашдынхаа арга хэмжээ рүү ороод тэгээд энэ холбогдох хуулийн байгууллагууд ялангуяа Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Улсын Ерөнхий прокурор, Монголбанк гээд энэ байгууллагуудтайгаа хамтарч ажиллах асуудлаа төлөвлөөд ингээд яриад эхэлчихсэн явж байгаа учраас цаашдаа эрс ахисан үр дүн гарна гэдэгт би өөртөө итгэлтэй байгаа. Тэгээд энэ талынхаа бэлтгэсэн зүйлээ би Төсвийн байнгын хороонд удахгүй танилцуулна гэдгээ бас түрүүн хэлсэн байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Ер нь одоо өнөөдөр яригдаад байгаа янз бүрийн сэдвүүд бүүр Татварын өршөөлийн тухай хууль энэ тэр гээд бүгд юутай холбогдож гарч ирж байна вэ гэхээр ерөөсөө хариуцлагатай хэсгийгээ урмыг нь хугалаад, хариуцлагагүй байдлыг л ер нь өөгшүүлэх гээд байна шүү дээ. Тэгэхээр улс орон даяар энэ хариуцлагыг үнэхээр анхаарч ажиллах ёстой байсан. Бүүр ямар ч асуудал байсан. Тэгэхээр энэ дээр бас Магнайсүрэн даргын хэлснийг ойлголоо.

2 дугаарт ер нь энд орж ирснээс хойш миний ажиглаж байгаа бас нэг зүйл юу вэ гэхээр угаасаа төрийн алба хүний нөөц харьцангуй бас хангалттай биш. Цаг хугацаа давчуу дотор хийх гэж байгаа ажил нь дэндүү олон байгаад байгаа нэг асуудлууд бас харагдаад байгаа юм. Тухайлбал аудит хийж байгаа газрууд. Тэгсэн мөртөө үр дүн бага. Тэгэхээр аль болохоор чанарлаг, тооноос илүү чанарт анхааръя гэсэн ийм саналыг би бас хэлмээр байгаад байгаа юм.

3 дугаарт нь.../минут дуусав./

Н.Наранбаатар: 5 номер асуулт тээ, асуулт уу? Санал хэлсэн юм байна. Дараагийн гишүүн Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ төсөвт өртөг нэмэгдээд байгаа асуудлууд ер нь дандаа цүнхний компаниудаас болж байгаа гэж харагдаж байгаа юм. Гүйцэтгэлтэй холбоотой. Тендер явагдахаар яадаг гэхээр баримтуудыг нь авсан ч болно надаас. Сангийн яаман дээр гомдлууд нь оччихсон. Тендерт шалгарч чадаагүй компаниуд нь гомдлоо өгдөг. Яагаад тэд нар гомдоод байна гэхээр цүнхний компаниуд дээгүүр нь ороод тендерийн хорооныхонтой нь хуйвалдаж байгаад тендерийг нь түгждэг. Тэгээд нөгөөдүүл нь гүйцэтгэгч компанитайгаа очоод тохирох гэж оролддог юм шиг байгаа юм. Хэдэн хувиа өг гэдэг юм бүү мэд. Тэгээд тэрийг нь хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа компаниуд Сангийн яаманд гомдол өгч байна. Гомдол нь шийдэгдэхгүй тэр чигээрээ явж байна. Тэгээд хэсэг хугацаа алдсаны дараа тендер нь зарлагдаж байна. Явахаараа цаг хугацаа алдсан ч юм уу, зураг төсөвт өөрчлөлт орсон ч юм уу ингээд хугацаа алдагдалтай холбоотой энэ асуудлууд чинь бас үүсээд байгаа юм нэг талаасаа.

Нөгөө талаасаа энэ магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан төсөвт өртгийнх нь өөрчлөлт нь ер нь дунджаар 25 хувьтай, захиалагчаас ирүүлсэн төсөвт өртөг нь ч гэсэн дунджаар 25 хувьтай өөрчлөлттэй гээд энэ та хэдийн гаргаж өгсөн дүгнэлт. Эндээс бид нар инфляц хамгийн өндөр түвшиндээ 9.2 хувьтай. 2024 онд 6.7 хувьтай байсан. Энэ хоёрын зөрүүгээр харъя гэхээр дахиад үндэслэлгүйгээр нэмэгдээд байх боломжтой 15 хувь бас байгаад байгаа байхгүй юу дахиад.

Тэгэхээр ер нь би энэ өмнөх асуудал дээр ч гэсэн яриад байгаа энэ хулгайч нартайгаа яаж тэмцэх юм бэ? Та хэд хэтэрхий ер нь яах вэ нэгж байгуулаад үр дүнгийн хойноос явж байна гэж байна. Сайн байна. Гэхдээ удаан байгаад байгаа юм биш үү? Хурдлахгүй бол бид нар хулгайчуудаа хүчрэхгүй байсаар байгаад улсын төсөв чинь өнөөдрийн Сангийн сайдын мэдэгдлээр хоёр аравны хэдэн их наядаар ч гэнэ тасарчхаад явж байна. Хувийн хэвшил чааваас ёстой нээрээ бүх бүсээ чангалаад гарч болдог бүх татвар, хураамж, юмаа төлөөд дээрээс нь дансаа хаалгаад үлдэхэд хулгайч нар зүгээр баяжаад хоцорч байгаа юм. Хувиа аваад хоцорч байгаа юм.

Одоо энэ нийслэл дээр тэр чигээрээ хулгай. Дүүргүүд бас энэ БГД-ийн тэр замаа цэвэрлэх тендерүүд нь зарлагддаг юм байна л даа. Дахиад л хулгай. Дандаа цүнхний компаниуд авна. Засаг даргын нэр талаараа ирж мэдээлэл өг гэсэн хүн бүүр утсаа ч авдаггүй том толгойтой нөхөр. Тэгээд энэ нийслэл дээр хийгдэх гээд байгаа аудитыг яагаад та нараар хийлгэе гэхээр нийслэлийн аудитууд юу ч илрүүлж чадахгүй байгаа учраас Үндэсний аудитын газраар хийлгэе гэдэг санал гаргаад байгаа юм. Нийслэл дээр тэгээд дүүргүүд дээр цөм цөм хулгай.

Яах вэ зарим тохиолдолд хөдөө орон нутгуудад нэг хэвийн зураг гэдэг нэг ийм батлагдаагүй зураг төсвөөр Өвөрхангай аймагт бүүр жишээлэхэд зураггүйгээр сургуулийн барилга эхэлж байгаа шүү дээ. Зураггүйгээр. Энэ чинь хулгай биз дээ? Тэгээд энэ хулгайнуудаа зогсоо гээд та нар яг ийм хатуухан шиг арга хэмжээ, санал гаргаад явахгүй л бол энэ хулгай зогсож чадахгүй. Сангийн яам шийдэж чадахгүй. Нөгөө захиалаад байгаа Боловсролын яам нь шийдэж чадахгүй. Энэ дээр та хэдийн байр суурийг сонсьё.

Н.Наранбаатар: 5 номерын микрофон Магнайцэрэн дарга.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуудал дэвшүүлж ярьж байгаатай бас яг энэ аудит хийгээд үр дүнг нь үзэхээр ийм зүйлүүд нийтлэг их ажиглагдаж байгаа ийм асуудлууд байгаад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр зэрэг яг энэ барилга байгууламжтай холбоотой асуудал дээр. 1 дүгээрт дээд түвшиндээ ингээд төсөвлөлтийн шаардлага хангахгүй барилга байгууламжийг төсөвт суулгах нэг ийм зөрчил байгаа юм. Тийм учраас бид нар Их Хурал дээр энэ асуудлыг анхаараач гэж 1 асуудал толилуулсан байгаа.

Дараагийн шат руугаа ороод ирэхээр зэрэг нөгөө энэ зураг төсвийг хянаж магадлахдаа хариуцлагагүй хандаж байгаа асуудал байгаа юм.

1 дүгээрт, зураг чанаргүй хийгдсэнээс болоод тухайн ажлын бүх зүйл энэнээс болоод зогсож байгаа, гацаж байгаа, царцаж байгаа, нурж байгаа, дараа нь дахиад төсвөө нэмүүлэх гэж байгаа ийм асуудлууд гарч байгаа ийм асуудал байна. Тийм учраас бид нар энэ Хэрэг эрхлэхийн сайд болоод Сангийн сайд, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд бүгдэд нь ийм ийм зөрчил, дутагдал байгаа учраас энийгээ засаач гэдэг зөвлөмжийг энэ дүгнэлтийнхээ ард хавсаргасан байгаа. Бид нар ирэх жилийнхээ төсөвт энэний уг суурь шалтгаан руу орно гэдгээ хэлсэн. Нэлээн сайн орохоор ийм 2, 3 жилийн юуныхаа үр дүнгээс харчихсан байж байгаа.

Тэгээд бид нарыг ингэж орох явцад гэмт хэргийн чанартай асуудал байвал бид энийг шуурхай холбогдох байгууллагууд нь шилжүүлнэ. Бид нарыг бид нар ингээд шинээр нэгж байгуулаад энэ асуудал дээр нэлээн ул суурьтай, дата мэдээлэлтэй, судалгаатай хандаж байгаа учраас хууль хяналтын байгууллагуудтай уялдаа холбоогоо хангаад нэлээн шуурхай үр дүнд хүрэхээр ажиллах ийм бололцоо бидэнд гараад ирчихсэн.

Тийм учраас бид нар энэ 1 сарын 1-нээс ялангуяа санамж бичгүүд байгуулаад нэлээн орохоор урьдчилсан ийм яриатай мэдээлэл баазаа, датагаа нэгтгэх, тэр дата руу нь харилцан байгууллагынх нь эрх этгээд, нэг хүн нь эрх аваад тэр мэдээлэл рүү нь, сан руу нь ороод ороод ингээд мэдээллүүд нэг байхаар ингэж ажиллаж байгаа учраас үр дүн гарна гэдэгт би эргэлзэхгүй байна.

Ер нь алхам алхмаар энэ янз бүрийн зөрчил, дутагдлыг арилгаад таслан зогсоогоод ингээд явах бололцоо бас харагдаж байгаа. Энэний төлөө тууштай ажиллана гэж ингэж хариулъя. Баярлалаа.

Н.Наранбаатар: Дараагийн гишүүн Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Үндэсний аудитын газраас тэгээд Магнайсүрэн дарга бас яг зогсолтгүй явж байгаа татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа энэ тогтолцоог бас ил тод ингэж ярьж байгаад баярлалаа. Тэгээд энэ төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусган баталж төсөвт өртгийг нэмэгдүүлдэг гэдэг ёстой хамгийн бодит үнэн. Энийг хэн хийдэг юм бэ? Улсын Их Хурлын гишүүд бид өөрсдөө хийж байгаа байхгүй юу. Уг нь энийг засах гэж тогтолцооны хувьд 126 гишүүн болгоод жоохон бодлогын юм ярья энэ тэр гэж ярьсан юм.

Тэгэхдээ яг харамсалтай нь төсөв ярихаар ерөөсөө бүгд нэг тойргийн жижигхэн. Тэгээд тэр нь улсын төсвөөр хийхгүй ажлуудыг хүртэл төлөвлөж оруулж

ирдэг. Орон нутаг хариуцах ёстой юмнуудыг улсын төсөв дээр хийж байгаад ингээд төсвийн наймаа, хулгай хийж байгаа шүү дээ. Энэ үнэн. Энэ төсвийн наймаа, хулгайг бүүр Засгийн газрын хариуцлагын асуудал дээр хүртэл уялдуулж авч үзэж байгаа практик сая гарлаа шүү дээ. Ийм л байгаа үнэн үнэн. Энийг хүлээн зөвшөөрч байна.

Тэгэхээр энийг тогтолцооны хувьд засъя гэж байгаа дээр баярлаж байна. Тэгээд энэ зураг төслийг зохиохоосоо эхлээд магадлах энэ харилцаан дээр угаасаа ур чадварын дутагдал, ойлголтын дутагдал, эргээд энэ хариуцлага, хяналтын тогтолцоо байхгүй болчихсон. Энэ бол зүгээр хуйвалдаан. Энэ улсын төсвийг чинь Барилга хөгжлийн төв баталж байгаа шүү дээ ерөнхийдөө.

Дээрээс нь яамнуудын дэргэд төвөгшилтэй салбарын барилгуудыг баталдаг тэр зургийн институц ер нь шийдэж байгаа юм. Энийг бид нар тогтолцооны хувьд тэр зохиогчийнх нь болоод магадлалын тэр хариуцлагын асуудлыг нь ярихгүй бол энэ Улсын Их Хурлын гишүүд төсөв батлаад байгаа юм байхгүй. Энийг чинь халти хулт бодлогын шийдвэр гарангуут төсөвт өртгийг нь яаж нэмэгдүүлэх вэ гээд тэнд шийдэж байгаа юм.

2 дугаарт ерөнхийдөө гишүүд ч гэсэн бид хэд бас өөрсдөөсөө анхаармаар байгаа юм. Яаж ийж байгаад лоббидоод нэг төсөл оруулангуутаа улсын төсвөөс тавьж байгаа нь ерөөсөө тэр төслийг хэрэгжүүлэх эхний жилдээ 5, 10-хан хувийг нь тавьж байгаа шүү дээ. Би нэг жишээг ярья. 320-оод тэрбум төгрөгийн зам тавиулж байхдаа 10 тэрбумыг эхлэх мөнгийг нь тавьж байгаа байхгүй юу. Энэ хэзээ дуусах юм тэгээд? Энийг ингээд хүчээр шийдчихээд дараа нь ингээд жил дамнуулан улсын төсөв өртөг нэмэгдүүлээд явдаг. Энэ бол жинхэнэ сонгодог хулгай. Энийг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөөсөө эхлээд болих хэрэгтэй. Ийм юмнууд ярьчхаад яг ингээд микрофон авахаар бүгд шударга юм ярина их гоё юм ярина. Тэгэхээр би хэзээ ч ийм зан маневр гаргахгүйн тулд л уг нь ажиллаад хэлээд байгаа юм. Тэгэхдээ дандаа ад болж байна л даа. Тэгэхээр энийг нэг засъя.

Жишээ нь, Дарханы замын асуудлыг л ярья л даа зүгээр жишээ аваад. Зураг төсвийг зурсан этгээд маань төсөвт өртгийг нэмэгдүүлж энэ зохиогчийн төлбөрөө илүү авахын тулд тойргуудыг гаргасан байгаа шүү дээ. Тэр дугуй тойргуудыг. Шулуун явж байсан замыг. Барилгын хийцийн хувьд нэмэгдүүлж. Ийм байдлаар ингээд явахаар чинь энэ улсын төсөв чинь үргүй зарцуулагдахгүй яах вэ дээ. Ийм л байгаа үнэн.

Дээрээс нь энэ Тендерийн хууль байгаа. Тендерийн хууль дээр бас зөвхөн зураг төсөвтэй ажил тендер худалдан авалтууд нь ямар ажлууд дээр явах вэ, ер нь том мега төслүүд нь эргээд.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье Сайнзориг гишүүнд.

П.Сайнзориг: Магадгүй энэ том төслүүд үндсэндээ гүйцэтгэгч зургийн автар хоёр нэг байж байж хариуцлагаа хүлээх юм байна лээ. Хүний зурсан зургаар том мега төсөл хөдөлж болохгүй юм байна лээ. Угаасаа ингээд хийцлэлийн хувьд гүйцэтгэгч, зохиогч хоёр муудалцаад ирдэг. Дунд нь захиалагч асуудалд ороод ингээд удааширдаг. Тэгэхээр бид хэд энэ Тендерийн хууль дээр ч гэсэн сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох ёстой.

Дээрээс нь стандартууд байна. Энэ барилгын хийцлэлийн стандартууд чинь бүх социализмын өмнө зах зээл рүү шилжиж байх үед байгаа. Техник технологи, шинжлэх ухааны ололтууд байсаар байгаад энэ стандартууд муу байгаа учраас өнөөдөр энэ төсөвт өртгүүд чинь автоматаар нэмэгдээд байгаа юм. Энэ хөнгөн хийцлэлтэй гэдэг юм уу барилгын салбар дээр зөндөө шийдлүүд гарчхаад байхад танк орж ирэх зориулалттай гүүр бариад сууж байгаа байхгүй юу бид. Стандарт нь энэ юм.

Тийм учраас энэ төсөв чинь улайхгүйгээр баахан ийм төсөвт өртөгтэй юмнуудыг тавьж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг цогц байдлаас нь тэр тогтолцоо, хариуцлага, эргээд энэ Улсын Их Хурлын үйл ажиллагаанаасаа гадна стандартын асуудлуудыг бас уялдуулж энэ ажлынхаа хүрээнд бас та хэд маань бас санал дүгнэж тэр аудитын сэдвийн хүрээнд баталлаа шүү дээ.../минут дуусав./

Н.Наранбаатар: 5 номер хариулт.

С.Магнайсүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэнтэй санал нэг байна. Яг бид нар аудитаа хийгээд тэгээд дүгнэлтийг нь Их Хуралдаа бас энэ төсөвлөлтийн шаардлага хангах тал дээр нь анхаараач гэдэг асуудал толилуулаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас авхуулаад Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд хүртэл ингээд бүгдэд нь тодорхой зөвлөмжүүд өгсөн. Энэ дотор тэр зураг төслийг чанартай боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам, стандартад одоо шинэчилж зохицуулах гээд саяын таны хэлдэг саналуудыг тусгасан.

Ер нь тэр зураг төсөв зохиож байгаа шатад 1 дүгээрт мэргэжлийн чадвар дутаж байгаа, боловсон хүчний чадавх дутаж байгаа, авлига, ашиг сонирхол, тэгээд хяналт, хариуцлага байхгүй гэсэн ийм үндсэн хэдэн асуудлууд гарч ирээд байгаа юм. Тийм учраас энэ зүг рүү нь бид нар хойтонгийн сэдэв батлагдахад нэлээн бас нухацтай ороод тодорхой асуудлууд гаргаж ирж Байнгын хороон дээр тавина гэсэн тооцоолол байгаа.

Тэгээд тэр энэ хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламжийн төсөвт өртгийг ингээд томсгосон өртгөөр тооцож тусгаач гэдэг тэр асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлээч гэдэг энэ дүгнэлтийг манай Үндэсний аудитын газраас сүүлийн 2, 3 жил дараалан юу яасан байдаг юм байна лээ зөвлөмж болгож ингэж хэлсэн байдаг. Гэвч энэ одоо хүртэл шийдэгдэхгүй байгаа.

Тухайлах юм бол Барилгын хөгжлийн төв дээр барилгын норм дүрмийн, нормын сан гэж байдаг. Энэ бол төсөвт өртгийн гүйцэтгэгч байгууллагуудын гүйцэтгэлийн тодорхой хувиар санхүүжээд, эх үүсвэр нь бүрдээд явдаг норм дүрмээ шинэчлээд явах ийм бүрэн бололцоотой. Тэгээд энэ маань бас хаана юунд явж байна гэдэг бас асуудал байгаад байгаа. Тийм учраас бид нар ийм 7, 8 зөвлөмж бас өгчихсөн байж байгаа. Тэгээд энэнийхээ хойно бас явж ажиллана л гэсэн ийм бодолтой байгаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ тухайн тэр төсөл, хөтөлбөрийн бас онцлогт нь тааруулж уян хатан гэдэг юм уу байх тэр зохицуулалтыг бид нар бий болгомоор байгаа юм. Тэгэхээр ялангуяа ер нь зүгээр төвөгшил өндөртэй ийм барилгын хийцлэл дээр зохиогч нь яг эцсийн хариуцлага хүлээдэг байдалтай баймаар

байна. Бусад оронд зохиогч яг мэргэжлийн этгээд өөрийнх нь төсөв, зураг төслийн дагуу хийгээгүй гүйцэтгэгчийн ажлыг шууд зогсоогоод энийгээ шийддэг. Тэгэхгүй ингээд зохиогчид нэг хагас хугас юм хийдэг, гүйцэтгэгч дундаас нь юм ярьдаг, захиалагч сүүлдээ энэ хоёрын дундах учрыг нь олох гэж махаа идэж хугацаагаа авдаг. Энийг сүүлд нь эцэслэн баталгаажуулж байгаа нь Барилга хөгжлийн төв гээд хуйвалдааны газар.

Тэгэхээр энэ зүйлүүдийг бас нэг цаашаа тогтолцооны хувьд та хэд маань яриач. Зохиогчийн тэр хяналтыг баталгаажуулж бас санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг юм чинь цэвэр даатгалын систем байгаа юм. Даатгал орж ирээд үндсэндээ бараг энэ улсын комисст авч байгаа үйл ажиллагаа хийдэг. Энэ “А” зэрэглэлийн барилга, “В” зэрэглэлийн барилга гээд. Тэгэхээр энэ рүү анхаарч өгөөч.

Н.Наранбаатар: Санал уу? Санал санал хэллээ. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Манай аудитын байгууллага их чухал асуудал оруулж ирж байгаа юм. Би энийг бас нэлээн үзсэн. Тэгэхдээ энэ надад шинэ зүйл биш л байгаа л даа. 12 он бишээ, 14 оны төсвийг оруулахад тэр үеийн манай байгууллагууд ажиллаад ер нь Монгол Улсын төсөв авлигажсан байна гэдэг ийм л юмыг би Их Хурлын индэр дээрээс хэлж байсан юм. Тэрний цаана юуг ойлгоод байгаа вэ гэхээр яг л манай аудитынхны оруулж ирж байгаа юмыг л хэлж байгаа юм. Зураг төсөл. Зураг төслөөс энэ авлигал эхэлдэг. Зургийг янз янзаар зурдаг. 320 хүүхдийн сургууль гэхэд өөр өөр компани зурдаг. Ингээд манай засаг дээрээс энэ авлигажсан төсвийг алга болгохын тулд, багасгахын тулд юу хийсэн юм гэхлээр нэг загварын зураг төсөв хийе. Магадгүй тэр орон нутгийн онцлогоос хамаараад суурь нь өөр байж болох байх. Фасад нь өөр байж болох байх. Бусад юмыг ингээд ингээд зургийг хэмнээ гэсэн. Одоо би юу болсныг мэдэхгүй байна.

Дараа нь тэр зураг дээр хийдэг төсөв, төсөвчин гэдэг маш аюултай зүйл. Би зүгээр нэг жишээ хэлэхэд намайг тэр үед байж байхад л өчигдөр нь 3 тэрбумын төсөвтэй байсан тэр объект маргааш нь 4 тэрбум төгрөг гэж байгаа шүү дээ. Яаж 1 хоногийн дотор 1 тэрбумаар төсөвт өртөг нь нэмэгддэг юм? Тэгэхээр энэ төсөвчин гэдэг дээр асар их том авлигал явж байгаа. Энийгээ яаж шийдэж байгаа юм мэдэхгүй. Бид нар бас Баярсайхан сайд Барилгын сайд байсан. Хийх гэж оролдоод явж л байсан юм. Материалын нь үнийг өсгөнө. Тэр нэг стандарт байсан. Энэ ёстой аймшигтай шүү дээ.

Өшөө нэг юм хэлэхэд хугацаа. Манай Их Хурлынханд бас муу, буруу юм байгаа юм. 5 жил, 3 жилээр нь байшин босгоно гэж тавьж байгаа юм. Энэ уулаасаа л дампуурал. Ингээд 100 байшинг 5 жилээр босгоно гэж тавьсан дор 20 байшинг 2 жилийн дотор босгоно гээд л тавих ёстой. Тэгэхээр энийг энэ завхралд хувь нэмэр оруулж байгаа бас манай Их Хурлын бас зарим нь бий. Тойрог дээрээ жоохон юм тавьчихъя гээд ийм юмыг янзлах ёстой. Тэр байтугай бид нар өртөг зардлыг хямдруулах ёстой. Сум болгон соёлын төв, сум болгонд нэг заал гээд ингээд давхиад байх юм уу тэр объектуудыг нийлүүлэх юм уу энэ дээр хөөе Магнайсүрэн даргаа та нэг очоод үзчих. Дундговь аймгийн Гурвансайхан сум маш үлгэр жишээ. Энэ манай Эрдэнэбүрэн гишүүн тэрийг хийсэн. Тэгэхдээ арай чадаагүй. Соёлын төв юу хоёр нь нэг ханатай байхгүй юу. Ядаж зардал арай багасаж байгаа юм. Үгүй энэ бид нар жижигхэн улс байж байж хамаг мөнгөө цемент, шаварт өгөөд, зуурмагт өгөөд дуусгаж байгаа байхгүй юу. Уг нь боловсрол хэрэгтэй, уг нь

эмнэлэг хэрэгтэй. Тэгэхдээ бид нар байшинд нь мөнгийг нь өгөөд дуусгадаг байхгүй юу. Уг нь тэнд ажиллаж байгаа хүмүүс, тэнд хэвтэж байгаа өвчтөнүүдэд мөнгө ч очиж баймаар байхгүй юу.

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье.

Н.Алтанхуяг: Би ер нь санал хэлж байгаа шүү. Та нартай 150 хувийн санал нэг байгаа учраас. Би тэгээд яах вэ өнгөрсөн ч гэсэн би зарим юмыг нь засчхаж болмоор санагдана. Тэр төсөвчин дээрээ анхаараад өгөөрэй. Яаж, хугацаа. Хугацааг дахиад хуулиа өөрчилдөг юм уу? Ерөөсөө л 2 жилээс илүү дамнаж юм баримааргүй байна. Манай үед засаг энэ авто зам яагаад ийм хурдтай явсан юм гэхээр 120км-ийг зам аваад дараад хэвтчихсэн нэг амьтныг чи чадахгүй юм бол бусад компаниудаа оруулаад тендер зарлая гээд 5 компани орохоор 20км-ийг аваад л тэгээд зөндөө барьчихдаг байхгүй юу. Үгүй гэх мэтчилэн уг нь хүсэл байвал энэ ард түмний ахуй амьжиргаа дээшлүүлэх улс орон хөгжүүлэх гэдэг чинь бас хүсэл хэрэгтэй юм шиг байна. Би одоо бүүр тийм тэнэг хүмүүс дандаа сонгогдоод байна гэж байхгүй л дээ. Дээр нь дарга болоод байна гэж байхгүй байх. Хүсэл байхгүй. Дандаа 5, 10 төгрөг л идэхийн дон туссан. Болчхож уу?

Н.Наранбаатар: Санал уу? Дараа нь Пунсалмаа гишүүн асуулт асууж, санал хэлнэ.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөвт ажлуудын өртөг нь дараа жил нь өсөөд байдаг ийм байдал байнга давтагдаж байна. Энэ өссөн дүн нь төсөв дээр нэмж суугдаад байна. Тэгээд улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалт хэсэг дээр жил болгон 15-20 хувийг нь өсөлт нь эзэлж байгаа байхгүй юу. Сүүлийн 3 жилийн өсөлтийг нийлбэр дүнгээр нь аваад үзсэн чинь 1.9 их наяд төгрөг болсон. Энэ бол ерөөсөө тэр чигээрээ цахилгаан станц барих ийм том дүнгээр энэ төсөв чинь өсөөд байна гэсэн үг байхгүй юу.

Тэгээд яагаад ингээд төсөв өсөөд байдаг юм бэ гээд үзэхлээр ерөөсөө л нэг үндсэн шалтгаан сая гишүүд бүгдээрээ хэлж байна ТЭЗҮ нь хангалттай биш байна, төсвийн шаардлагатай материалууд хангалттай биш байна. Тийм учраас жишиг ТЭЗҮ ашиглаж байгаа. Тэгээд жишиг ТЭЗҮ-гээ яг хөрсөн дээрээ бүтээн байгуулалтаа хийхлээр бүх тооцооллууд нь зөрдөг. Тэгээд нэмэлт төсөв суулгах шаардлагатай болдог.

Ер нь яагаад бид нар ингээд ТЭЗҮ-гээ ингээд яаралтайгаар ингэж дандаа оруулж ирдэг юм. Бид нарт чинь хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө байна, жилийн төлөвлөгөө байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хяналт тавьж байна. Бид нар энэ ТЭЗҮ-гээ ер нь нэг урт хугацаандаа нямбайхан шиг төлөвлөөд ингээд байж болдоггүй юм уу? Эсвэл тухайн төсөв батлагдах үед нэмэлтээр маш яаралтай олон төсөв орж ирдэг юм уу? Энэ юунаас болоод ингэж ийм дутуу ТЭЗҮ боловсруулагдаж орж ирээд байдаг юм бэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаар асуудал нь болохлоор барилгын төсөвт өртгийг өөрчлөн нэмэгдүүлэх ямар аргачлал баримталдаг юм бэ? Жишээлбэл, энд барилгын төсөвт өртгийг өөрчлөн томсгох хэлбэрээр тооцоолох аргачлал дээр нь хэрэглээний үнийн индекс, валютын ханш зэргийг суурь хүчин зүйл болгож тооцно гэхчхэн байгаа. Энэ бол инфляцын түвшнээр л ер нь өсгөнө л гэсэн үг шүү дээ. Гэтэл инфляц чинь жилдээ 10 орчим хувь гээд томоор бодчихье. Тэгэхэд 30 хувь,

бараг 40 хувь өсгөж байгаа. Энийг ер нь ямар аргачлалаар, ямар баримт бичгийг үндэслэж ингэж илүү хэмжээгээр нэмдэг юм бэ гэдэг талаар 2 асуулт асууя.

Н.Наранбаатар: 6 дугаар микрофон ажлын хэсгийн хариулъя. Албан тушаал, овог нэрээ хэлээд.

Д.Энхболд: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд. ТЭЗҮ дээр яагаад ийм асуудалтай байна вэ гэдэг дээр Үндэсний аудитын газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар жил болгон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон дунд хугацааны бодлоготой уялдуулаад салбартаа хэрэгжүүлэх дараа жилийн төсөл, арга хэмжээн дээр урьдчилсан зураг төслийг бэлдэх, ТЭЗҮ-г боловсруулдаг байх ийм шаардлагатай байна гэдэг зөвлөмжүүдийг удаа дараа өгч байгаа.

Гэтэл энэ дээр гэнэт гэнэт тухайн асуудал дээр жилийн төлөвлөгөө, бодлогын асуудалтай уялдахгүй асуудлуудыг оруулж ирдэг. Сая гэхэд төсөвт өртгийн нэмэгдлийн 145 арга хэмжээн дээр дүгнэлт гаргахад 110 төсөл, арга хэмжээ нь энэ шаардлагыг хангаагүй байх жишээтэй. Энэ дээр бид нар удаа дараагийн Боловсролын яам гэхэд жишээлбэл дараа жил, 2 жилийн хугацаанд хэчнээн хүүхдийн сургууль барих юм, хэдэн онд, дараа жил нь хэдийг нь барих юм энэ бүх юугаараа аймаг, байршлаараа судалгааг хийсэн байх ёстой. Энэнтэй холбогдуулаад дараа жилийн төсөвт тавигдах зураг төсвүүд бэлэн болсон байх шаардлагыг хангуулсан байх үндэслэлтэй байгаа учраас энийг Төсвийн тухай хуульд суулгаснаараа энэ төсөвт өртгийн нэмэгдэл өөрчлөлт гэдэг асуудлыг бага хэмжээнд гаргах ийм бололцоо байна гэж үзэж байгаа юм.

2 дахь асуудлын хувьд тэр томсгосон хэлбэрээр төсөв зохиох ийм аргачлал, заавар нь батлагдсан байгаа холбогдох эрх бүхий байгууллагын. Гэвч одоогийн байдлаар бодит нөхцөлд энэ нь хэрэглэгдэхгүй байгаа. Энэ хэрэглээний үнийн индекс болон холбогдох энэ өөрчлөлтүүдийг уялдуулж төсөвтөө энийг ашиглахгүй байгаагаас бол энэ эрх зүйн орчин нь байгаа боловч бодит хэрэглээн дээр энийг ашиглахгүй байна гэж энэ аудитаар дүгнэсэн.

Дээрээс нь энэ төсөвт өртгийн өөрчлөлтийг оруулаад байгаа 3 багц шалтгаан байна гэж аудитаар тодорхойлсон байгаа. Энэ дээр 1 дүгээрт энэ төлөвлөлтийн үйл явцын дараалал алдагдчихсан байгаа. Юмаа төлөвлөж хуульд суулгасныхаа араас нь л төсөвлөлтийн шаардлага хангуулах ийм процессууд яваад байна.

Хоёрт нь тэр нэмэлт ажлуудыг үндэслэлгүйгээр төсөвлөж орж ирж байгаа түрүүний бид нарын яриад байсан 31.3 хувийн үндэслэлгүй ажлуудыг нэмж оруулж ирэх ийм асуудлууд байна.

Батлагдсан зураг төсөв дээр бол зураг зүйг өөрчлөх асуудлуудаар өөрчлөлтүүд зураг зүйн өөрчлөлтүүд орж байна гэдэг ийм асуудлуудыг гаргаад тавьсан. Ер нь саяын асуудлуудтай холбоотойгоор хяналт, хариуцлагын тогтолцоо гэдэг асуудал ер нь байхгүй байна.

Тухайлбал, саяын аудитаар нийтдээ 85 хуулийн этгээд зураг төсөв боловсруулснаас 65 хуулийн этгээд нь алдаатай зураг төслүүдийг ингээд боловсруулж гаргаад байгаа. Энэ дээр яг нарийвчилсан ямар хариуцлага тооцох

юм бэ, хэн хариуцлага тооцох юм бэ гэдгийг ерөөсөө нарийн тодорхойлж өгөөгүй. Удаа дараагийн алдаатай зураг төсөв боловсруулаад байгаа эксперт болон холбогдох төсөвчний тусгай зөвшөөрлийг нь цуцлах шаардлага байна гээд Аудитын байгууллагаас өмнөх аудитор зөвлөмж өгөхөөр саяын 25 оны аудит дээр дахиад л нөгөө хүмүүс нь зураг төслөө боловсруулаад ороод ирсэн байдаг.

Тэгэхээр энэ хариуцлага, хяналтын тогтолцоог илүү нарийн тодорхой болгох шаардлага байна гэдгийг бид нар Улсын Их Хурал, Засгийн газарт өгч байгаа.

23 оны аудитаар бид нар Засгийн газрыг энэ тогтолцоо чинь болохгүй байна. Энэ дээрээ үнэхээр болохгүй байгаа бол өөрчлөлтийг оруулж Их Хуралд танилцуул, энэ чиг үүргийн өөрчлөлтүүдийг тодорхой болго гэдэг ийм зөвлөмж хэрэгжээгүй байгаа учраас энийг саяын аудитаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос энэ дээр тусгайлан Засгийн газар.../минут дуусав./

Н.Наранбаатар: Пунсалмаа гишүүн тодруулах уу? Пунсалмаа гишүүн 1 минут.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр нийцлийн аудитын зүгээс тогтолцооны хувьд болохгүй байна гэж сая хэллээ шүү дээ. Тэгэхлээр тогтолцоог өөрчлөхийн тулд энийг зөв голдиролд оруулахын тулд бидэнд юу хийх хэрэгтэй юм? Та энийг сая хэд хэдэн санаа хэллээ. Би бас ийм тогтоолын төсөл санаачилчихсан явж байгаа. Тэгэхлээр та бүгдийн зүгээс энэ тогтолцоог өөрчлөхөд ямар алхмууд хийвэл зүгээр вэ гэдэг саналыг надад бичгээр хүргүүлээч ээ гэдэг хүсэлтийг хүргэж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Бичгээр хүргүүлэх нь байна.

Аудитын тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Хамт шүү дээ.

Үүрийнтуяа гишүүн орон нутгийн томилолттой тул ирцээс хасъя. Аубакир гишүүн чөлөө авсан тул ирцээс хасъя. Ингээд 2 гишүүн ирцээс хасагдаж байна. Номин гишүүн асуулт уу, санал уу? Номин гишүүн санал хэлье.

Ч.Номин: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би бас энэ төсвийн ерөнхийлөн захирагч байсны хувьд одоо энд гардаг бэрхшээлүүд талаас нь бас хэлье гэж бодож байна. Энэ хамгийн гол асуудлууд ерөөсөө бид нар Улсын Их Хурлын гишүүд бид нар өөрсдөө байдаг. Яадаг гэхээр бид нар өөрсдөө төсөвжилтийн шаардлага хангаагүй төслийг шууд оруулж ирдэг. Энэнээс болоод төсөвт өртөг нь нэмэгдэх нөхцөл үүсдэг.

Яагаад вэ гэхээр бид нар төсвийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй зүйлийг оруулж ирдэг. Бид сая 2026 оны төсөв дээр ч гэсэн та бүхэн өөрсдөө санаарай 1.4 их наяд орчим төгрөгийн 100 гаруй шинэ төсөл, арга хэмжээ орж ирсэн. Эдний дийлэнх нь зураг төсөв нь шаардлага хангаагүй.

Энэнээсээ болоод бид нар өөрсдөө дутуу төсөвжилттэй, дутуу зурагтай төсөл, арга хэмжээ оруулж ирчхээд дараа жил нь энийгээ гүйцээж дуусгахын тулд тэгээд сайд нарт үүрэг болгоод энийг хэрэгжүүл гээд. Энийг хэрэгжүүлэхийн тулд магадлан хийлгэдэг. Дээрээс нь ингээд аудит хийлгэ. Ингээд төсөвт өртөг

нэмэгддэг. Тэгэхээр энэнээсээ болоод өндөр өртөгтэй болоод явдаг. Тэгээд нөгөө хэрэгжилт нь бүрэн хангагдахгүй зүйлүүд гарч ирдэг.

Яг төсөв хэлэлцэж байх үед бид нар яадаг вэ гэхээр бараг 126 төсвийн ерөнхийлөн захирагч нар болчихдог. Тэгснээ араас нь хэрэгжилт ярихаараа болохоор бүгдээрээ та нар татвар төлөгч нарын мөнгөөр ингэж байна гээд баахан хянагч нар болчихдог. Яг энэ дээрээ тулах юм бол бид нар хамгийн түрүүнд юу хийх ёстой вэ гэхээр төсөвжилтийн шаардлага хангаагүй аливаа төсөл, арга хэмжээг төсөвт суулгахгүй гэдэг дээрээ л анхаарах ёстой. Тэгэхээр шинэ Байнгын хороон дарга маань дараа 2027 оны асуудал дээр яг ийм зураг төсөвгүй зүйлүүдийг суулгахгүй байх дээр л анхаарах хэрэгтэй. Тэгж байж бид нар төсвийн сахилга баттай, хэрэгжилт бүрэн хангагдсан, төсөвт өртөг нэмэгдэхгүй ийм төслүүд явна.

Тэгэхээр бас Аудитын ерөнхий газраас хэрвээ тийм шаардлага байвал надад бас бичгээр хүргүүлээч. Би ямар нэгэн хууль санаачлах хэрэгтэй бол санаачилъя. Яагаад вэ гэхээр аль аль талдаа хэцүү. Аваачаад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр өөрсдөө мэдээгүй байгаа төсөл, арга хэмжээг тавьчихдаг.

Тэгээд өнөөх нь яадаг вэ гэхээр нэг орж ирэхдээ 5 тэрбумаар орж ирчхээд дараагийн төсөв дээр орж ирэхдээ төсөвт өртөг нь нэмэгдээд ороод ирдэг. Би шинэ сайдаар орж ирж байхад 2021 онд миний төсөв дээр Богд Зонхов гэдэг төсөл 5 тэрбумаар байсан. 22 оны төсөв орж ирэхдээ яасан 32 тэрбум болгоод ингээд зураг төсөлтэй болгоод нэмээд ороод ирчихсэн. Тэгээд энэ мэтчилэн ийм төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрөө хүртэл мэдэхгүй зүйлүүд байдаг.

Тэгэхээр 1 дүгээрт хэрвээ л сахилга баттай байлгая, өнөөдөр ярьж байгаа зүйлээ хийе гэж байгаа бол гишүүд өөрсдөө сахилга баттай болох ёстой. Дураараа ямар нэгэн зураг төсөлгүй төсөл, арга хэмжээг оруулж ирэхгүй байх дээр анхаарах хэрэгтэй. Энэ дээр бид нар бас хамтарч ажиллах нь хамгийн чухал байна гэдгийг бас хэлмээр байна.

Н.Наранбаатар: Баярлалаа. Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах Үндэсний аудитын газрын тайланг хэлэлцэж дууслаа.

Өмнөх хоёр асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Энийг уншихъя.

15.47 цаг

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Аудитын сэдэв батлах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.9.7 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан аудитыг хугацаанд нь гүйцэтгэж аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлж ажиллахыг мөн Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэнд үүрэг болгосугай.

Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөр санал хураалт явуулъя. Дэмжье.

62.5 хувиар тогтоол батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа.

15.49 цаг

Дараагийн санал хураах тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.9.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.“Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн 2 бодлогоор гүйцэтгэх аудитын сэдэв гэсэн зүйлийн Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн гэсэн 5 дахь хэсгийг, “Оюу толгой” компанийн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүн гэсэн 11 дэх хэсгийг, стратегийн ач холбогдол бүхий төрийн өмчийн компаниудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, нийцэл гэсэн 15 дахь хэсгийг тус тус хассугай.

Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар.

Энэ тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ санал хураалт яасан техникийн алдаа гарч байна уу? Яаж байна? Санал хураалт.

Энэ хэн нь яасан? Сайнзориг гишүүн горимын санал гаргах уу? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Техник сая ажилласангүй дарга. Тийм учраас өмнөх саналыг хүчингүй болгож дахиж хурааж өгнө үү.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад гишүүд эхлээд бэлтгэх юм байна. Бүгд орчихсон уу? Тэмүүлэн дарга орсон уу? Бүгд орчихсон уу? Мөнхсоёл гишүүн орсон уу?

Сайнзориг гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

62.5 хувиар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулаад “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хурааа. Санал хураалт.

Тогтоолын төсөл 62.5 хувиар батлагдлаа.

15.52 цаг

Ингээд сүүлчийн асуудал 6 дахь асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаар талаарх Сангийн сайдын мэдээллийг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулаарай. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бэлтрэгийн Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батжаргалын Цогнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.1-д Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон бусад газрын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын мэдээллийг хэлэлцэнэ.

Мэдээллийг Сангийн сайд Жавхлан танилцуулна. Сангийн сайдын микрофоныг нээе 6 номер.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Төсвийн байнгын хороонд танилцуулахаар бэлтгэснийг та бүхэнд үүгээр танилцуулъя.

Нэгдсэн төсвийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого 28 их наяд төгрөг, нийт зардал 28.4 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 428.8 тэрбум төгрөг гарах төсөөлөлтэй байна. Түүнчлэн урсгал зардал 22.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 25.2 хувьтай, суурь тэнцэл 1.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2 хувьтай байх төсөөлөлтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 27 их наяд 968.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 7.5 хувь буюу 2 их наяд 277 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөөр байна. Энэ нь дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

Нэгд, нүүрсний орлого экспортлогч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын мөнгөн дүн 2 дахин буурч, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, АМНАТ-ын орлого өмнөх оны мөн үеэс 1 их наяд 683.3 тэрбум төгрөгөөр, төлөвлөснөөс 615 тэрбум төгрөгөөр тус тус буурч, 9 их наяд 395.2 тэрбум төгрөгт хүрэх хүлээлттэй байна.

Нийт импортын дүн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тодотголд тусгагдсан дүнгээс 10.4 хувиар буюу 1.3 тэрбум доллароор буурлаа. Импорт ийнхүү багассанаас гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан дүнгээс 1.2 их наяд төгрөгөөр буурч, 6.6 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Макро эдийн засгийг тогтворжуулах бодлогын үр дүнд оны эхэнд 742 сая ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл эхний 10 сарын байдлаар 141 сая ам.долларын эерэг болсон. Гадаад валютын нөөц 12 дугаар сард 6 тэрбум долларт хүрлээ. Түүнчлэн Эс Эн Пи агентлаг болон зээлжих зэрэглэлийг “BB” төлөвийг тогтвортой болгон нэмэгдүүллээ. Макро эдийн засгийн тогтвортой ... оны сүүлийн хагаст ийнхүү сайжирсан хэдий ч экспортын шокийн голлох салбарууд үзүүлсэн сөрөг нөлөө үргэлжлэн төсвийн орлого буурахад нөлөөлсөн.

Мөн үүний хажуугаар эерэг үр дүн гэх юм бол төлбөрийн тэнцлээс гадна энэ валютын ханшийн тогтвортой байдлаа их сайн хадгалж чадлаа. 3650 хүрээд байсан ам.долларын ханш өчигдрийн байдлаар Төв банкны ханш 3544 төгрөгтэй байна. Мөн оны эхний хагаст урсгал тэнцэл алдагдалтай байсан бол сүүлийн хагаст эерэг 1 тэрбум доллар руу дөхөж байна.

Энэ нь макро тэнцвэрийн нэлээдгүй сайн үр дүн, макро бодлогын үр дүнгийн нөлөө ийнхүү гарч байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 28 их наяд 397.3 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 10.2 хувь буюу 3 их наяд 212 тэрбум төгрөгөөр бага гарах төсөөлөлтэй байна. Энэ нь дараах шалтгаантай байна.

1 дүгээрт төсвийн орлоготой уялдуулан төсвийн зардлыг санхүүжүүлж байна. Төсвийн сангаас цалин хөлс, зээлийн үйлчилгээний төлбөр, нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмж зэрэг зайлшгүй зардлыг нэн тэргүүнд санхүүжүүлж, тухайн өдрийн татварын орлогын дүнгээс хамааран бусад урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлж байна.

Хөрөнгө оруулалтын зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 81 хувь буюу 2 их наяд 366 мянга 4 тэрбум төгрөг байна. Барилгын ажлын гүйцэтгэлийн хугацаа харьцангуй богино. Улирлын нөлөө ихтэй компаниудын гүйцэтгэлийн чадавх

хангалттай биш байгаагийн зэрэгцээ энэ онд шинээр хэрэгжиж эхэлсэн төслүүдийн 46.3 хувь нь 5 дугаар сард гэрээ байгуулсан нь гүйцэтгэл бага гарахад ийнхүү нөлөөлж байна. Мөн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлийн дундаж хэмжээ 78 хувьтай байжээ.

3 дугаарт, өнөөдрийн байдлаар гүйцэтгэл нь ирээгүй байгаа хөрөнгө оруулалтын үлдэгдэл 1 их наяд 180.9 тэрбум төгрөг, ирсэн хөрөнгө оруулалтын өсөлт нь 98 тэрбум төгрөг байна. Он дуустал хугацаанд гүйцэтгэлд үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хэвийн олгохоор ажиллаж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны эцэст ДНБ-ий 40.4 хувь буюу 36.4 их наяд төгрөгт хүрэхээр байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагаас 20 хувь нэгж, төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хязгаараас 10 хувь нэгжээр тус тус доогуур байгаа нь өрийн тогтвортой байдал бүрэн хангагдаж байгааг харуулж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газраас улсын төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

Нэгд, 3.7 их наяд төгрөгийн татварын өр ноогдлын үлдэгдэлтэй аж ахуйн нэгжүүдээр болон 615.9 тэрбум төгрөгийн томоохон татварын өртэй татвар төлөгч тэр өрийг төлж барагдуулах.

Хоёрт, Гаалийн ерөнхий газраас гаалийн баталгаат агуулах, бүсүүд дэх хугацаа хэтэрсэн барааны үлдэгдлийг бүрэн шахах замаар төрөөс 49.7 тэрбум төгрөг. Нефтийн бүтээгдэхүүний хойшлуулсан татварыг ондоо багтаан барагдуулах замаар 18.6 тэрбум төгрөг, гаалийн баталгаат агуулахад байршуулах хугацаа нь дууссан аж ахуйн нэгжүүдээс 10 тэрбум төгрөг, өр, авлагыг барагдуулах ажлыг идэвхжүүлэх замаар 2.2 тэрбум төгрөг, бүрдүүлэлтийн дараах шалгалтыг эрчимжүүлэх замаар 1 тэрбум төгрөгийн татварыг тус тус нэмж төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дэлгэцээр та бүхэнд танилцуулна. Хүлээж авна уу.

Н.Наранбаатар: 7 дугаар микрофоныг нээе.

Ж.Ганбат: Байнгын хороод гишүүдийн өдрийн амар амгаланг эрж байна. 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаар танилцуулъя. Энийг танилцуулахын өмнө төсвийн макро эдийн засгийн байдал ямархуу байгааг эхний ээлжид танилцуулъя.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж ажилласан. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай байсан бол 25 оны 3 дугаар улирлын байдлаар 5.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гадаад валютын нөөц бол 2025 оны 2 сар 4.8 тэрбум ам.доллар байсан бол 2025 оны 12 сарын 3-ны байдлаар 6 тэрбум доллар байна. Төлбөрийн тэнцэл бол -742 сая доллар байсан бол 53 сая доллар ингээд + ийм үзүүлэлттэй гарсан байна.

Зээлжих зэрэглэл тогтвортой сайжирсан ийм үзүүлэлттэй байгаа. 2025 он гарснаас Засгийн газар гадаад валютын албан нөөцийг хамгаалах нэмэгдүүлэх ажлын хүрээнд импортыг хязгаарлах, ялангуяа импортын суудлын автомашиныг хязгаарлах ийм арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлсэн байгаа. Энэ үнэд валютын нөөц бол 6 тэрбум доллар хүрэхэд энэ бодлого үр дүнгээ хүрсэн. Төлбөрийн тэнцэл сайжирсан ийм эерэг үзүүлэлттэй гарсан. Төсвийн импортыг энэ хүрээнд импорт 2025 оны тодотголоор 12.5 тэрбум долларын импорт хийнэ гэж тооцож байсан бол энэ оны хүлээж байгаа гүйцэтгэлээр 11.2 сая ам.доллар болж импорт дээр бид 1 тэрбум долларын импортоор ингэж ийм буурсан ийм үзүүлэлтүүдтэй байна.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг энэ хүснэгтийг бас гишүүдийг анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Энэ дээр бид 2025 оны төсвийг батлуулахдаа гол суурь үзүүлэлт болгож Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээр ашиглаж төсөв боловсруулж байгаа. 2025 оны төсөв болон 2025 он төсвийн тодотгол дээрх энэ үзүүлэлтүүдийг энэ слайдаар харьцуулж харуулсан байгаа.

ДНБ нэрлэсэн үнээр эхний 2025 оны эхний батлагдсан төсөв дээр ДНБ нэрлэсэн үнийг 95 их наяд төгрөгөөр тооцож байна. Төсвийн тодотголоор бид 5 их наядаар бууруулаад 90 их наядаар тооцсон. Энэ маань хүлээж байгааг гүйцэтгэхээр 87.5 их наяд гээд энэ дээр 2.5 их наядаар буурсан ийм нэрлэсэн үзүүлэлт ДНБ ийм байдалтай байна.

Уул уурхай дээр гол буурсан үзүүлэлт энэ дээр байгаа. Бид эхний 2025 оны эхний батлагдсан төсөв дээр 30.5 их наядын уул уурхай гэж тооцож байсан бол тодотгол дээр энэ 22.3 бид нар бууруулж энэний тоо Эдийн засгийн яамнаас ирсэн тоон дээр үндэслэн төсвийн тодотгол боловсруулсан. Хүлээж байгаа гүйцэтгэл энэ маань 19.9 гэж ингэж буурсан. Эндээс бид уул уурхайгаас орж ирэх хүртэл орлого энэ дээр гол буурсан.

Уул уурхайн бус орлого дээр яах вэ өсөлттэй байгаа. Гэхдээ энэ дээр уул уурхайн бус дээр хөдөө аж ахуйн салбар дээр гол өсөлт гарсан ийм байгаа. Энэ дээр төсвийн нөлөөлөл харьцангуй бага байгаа. Уул уурхайн бус дээр яах вэ анхны батламж 14.5 гэсэн маань энэ маань хүлээж байгаа гүйцэтгэлээр 67.5 гээд нэмэгдсэн боловч энэ дээр хөдөө аж ахуй дээр гол өсөлт гарсан. Энэ дээр төсвийн нөлөөлөл харьцангуй бага ингэж.

Гол экспорт дээр бид нар экспортын орлого тодотголоос буурч гарсан байгаа. Нүүрсний экспортын биет хэмжээ бол 24 оны жилийн эцэст 84 сая тонн нүүрс экспорт гаргаж байсан. 2025 оны анх батлагдсан төсөв дээр бид 83 сая тонныг экспорт гаргана гэж тооцсон. Төсвийн тодотгол дээр 85 гэж тооцсон. Хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн 87, биет хэмжээний хувьд хэвийн хэмжээнд өнгөрсөн оны мөн түвшинд ингэж байгаа. Үнийн хувьд өнгөрсөн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нүүрсний дундаж үнэ 110 ам.доллар. Энийг бид нар төсөв дээр 105-аар тооцсон. Төсвийн тодотгол дээр 70 ам.доллараар тооцсон. Энэ бол дундаж үнэ бол одоогийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл 65 ам.доллартой тэнцэж байгаа. Эндээс үнийн хувьд бид төсвийн орлого дээр буурч байгаа.

Зэсийн хувьд харьцангуй тогтвортой ийм өндөр түвшинд байгаа. Бид 2025 оны тодотгол дээр 5345 ам.доллар зэсийн үнийг тооцсон. Энэ өнөөдрийн

байдлаар энэ хүлээгдэж байгаа 5600 ам.доллар гээд байгаа. Хэдийгээр энэ зэсийн үнэ өндөр байгаа ч гэсэн яах вэ нүүрс дээр бид үнийн хувьд буурч байгаа учраас экспортын орлого буурч байгаа. Экспорт дээрээс бид 500 орчим сая доллар экспорт буурсан учраас энэ дээр төсвийн орлого буурахад гол нөлөөлсөн.

Импорт дээр бид 2025 оны анх батлагдсан дээр 13.5 тэрбум долларын импорт хийнэ гэж тооцож байсныг бид 2025 он тодотгол дээр 1 тэрбум доллар буурвал 12.5 тэрбум доллар гэсэн энэ дээр хүлээгдэж байгаа гүйцэтгэл 11.2 тэрбум ам.доллар болж ингэж буурсан ийм үзүүлэлттэй байгаа. Эндээс гол импорт дээрээс 1 тэрбум доллар ингээд импорт буурсантай холбогдуулан энэ төсвийн орлого буурахад гол нөлөө үзүүлсэн байгаа.

Яг энэ гол макро эдийн засгийн тоон, тооцоолол энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсруулсан энэ тоон дээр үндэслээд төсвийн тодотголыг боловсруулаад бид орлогыг 3.3 их наяд, зарлагыг 2 их наядаар бууруулсан энэ тодотголын хүлээж байгаа гүйцэтгэл дээр саяын ийм байдлаар гол экспорт, импорт, нүүрсний үнэ дээр бид бууралттай байгаа. Төлөвлөсөн хэмжээнд хүрч чадаагүй нь төсвийн орлого буурахад нөлөөлсөн. Энэнтэй хамаараад бид хүлээж байгаа гүйцэтгэл дээр нэгдсэн үндэсний тэнцвэржүүлсэн орлого бол 2.2 их наядаар буурахаар ийм байдалтай байна.

Энд гол нөлөөлсөн юм бол уул уурхайн салбарын идэвхжилт, бууралт, нүүрсний экспортын орлого нь бууралттай холбоотойгоор нүүрсний аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого 2 дахин буурсан үзүүлэлттэй байгаа. Үүнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц бүхий орлого өмнөх оны мөн үеэс 1.7 их наяд төгрөгөөр, төлөвлөснөөс 614.9 тэрбум төгрөгөөр тус тус буураад 9.4 тэрбум төгрөгт хүрэх ийм тооцоололтой байгаа. Энэ дээрээ ингээд хүснэгтээр харуулчихсан байгаа.

Зэс дээр эерэг үзүүлэлттэй байгаа хэдий ч Оюу толгойн төсөвт төвлөрүүлэх орлогын нөлөө харьцангуй бага, борлуулалт нь 2 дахин ахиу өссөн хэдий ч төсөвт төвлөрүүлэх орлогын дүн нь Оюу толгой дээр 200 орчим тэрбум төгрөгөөр өссөн байгаа. Энэ бол тийм төдийлөн бас борлуулалт нь өссөн хэдий ч энэ төсөвт төвлөрүүлэх орлого нь бага ийм дүнтэй байж байгаа.

Импортын хэмжээ би өмнө нь танилцуулсан. 2025 оны төлөвлөсөн түвшнээс 1.3 тэрбум ам.доллараар буурч байгаа. Тэгээд 11.2 тэрбум долларт хүрэхээр байна. Үүнээс үүдэн гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан дүнгээс 1.2 их наяд төгрөгөөр буурсан ийм үзүүлэлттэй. Тэгээд 6.6 их наяд төгрөгт хүрэхээр ийм байдалтай орлогын гол нөлөөлөл бол саяын хэлдэг экспортын нөлөөлөл, импортын нөлөөллөөс болоод төсвийн орлого гол буурахад ийм нөлөө үзүүлжээ.

Бид нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг 2025 оны гүйцэтгэл бол тэнцвэржүүлсэн орлого, батлагдсан дүнг харьцуулсан энэ тоон дээр байгаа. Энэ дээр энэ улаанаар биччихсэн гол нь энэ дээр орны ИТХ-аар төсөв батлан, улсын төсөв баталсны дараа аймаг, нийслэл ИТХ-аар орон нутгийн төсөв батлагддаг. 2025 оны төсвийг орон нутаг, аймаг, нийслэл батлахдаа жишээ нь зарлагыг 2.6 их наядаар нэмэгдүүлж баталсан. Энэ дээр урьд оны үлдэгдлээс санхүүжих нь 713.3 тэрбум төгрөг. Бондоос санхүүжих гээд энэ гол нь нийслэлийн бонд байгаа. Нийслэлийн 2024 онд гаргасан энэ нийслэлийн бондын зарцуулалт нь энэ 2025 онд зарцуулалт

нь гарч байгаа учраас энэ төсвийн зарлага талд бас нөлөөлөх ийм байдалтайгаар байгаа.

Гүйцэтгэл нь орон нутгийн энэ иргэдийн төлөөлөлд батлагдсан төсвийн гүйцэтгэл саяын хэлдэг зарлага нь 811.5 тэрбумын гүйцэтгэлтэй. Урьд оноос нөгөө дансны үлдэгдлээс санхүүжих нь 313, бонд дээр 497006 төгрөгийн санхүүжилттэй. Энэ дүнгээр 2025 оны төсвийн гүйцэтгэлийн зарлага нь нэмэгдэж энэ хэмжээгээр нэгдсэн төсөв дээр ачаалал ирж байна гэж ингэж үзэж байгаа юм. Энэ дээр дараагийн слайд дээр орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг ИТХ ба энэ орлогоо жишээ нь Улсын Их Хурлаар аймаг, нийслэл, орон нутгийн төвлөрүүлэх орлого, санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн сан гээд энэ 3 дүнг баталдаг.

Аймаг, нийслэл ИТХ-аар орлогоо нэмэгдүүлээд, зардлаа нэмэгдүүлэх байдлаар ингэж баталж байгаа байх ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд. Энэ дээр аймаг, нийслэл, орон нутаг нийтдээ энэ 2025 оны төсөв дээр 1.2 их наядаар орлогоо нэмэгдүүлсэн. Мөн зарлагаа 2.6 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн. Ингээд өөрөөр хэлэх юм бол нөгөө талдаа энэ дансны үлдэгдэл болон бондын санхүүжилтээр -1.4 их наяд гээд орон нутаг өөрөөр хэлбэл ийм алдагдалтай байхаар төсвөө ИТХ-аар ингэж батлуулсан бол энэ байгаа. Энэ хэмжээгээр нэгдсэн төсөв дээр зарлага ингэж ачаалал бол орж ирж байгаа.

Бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх, 6.1.3-д нь нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ нь тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх гэдэг ийм тусгай шаардлагыг бид хангах ёстой. Тэгээд тусгай шаардлагыг хангахад хангахад ДНБ-ий нэрлэсэн ДНБ хүлээгдэж байгаа гүйцэтгэл 87.5 их наяд төгрөг байна. Тусгай шаардлагыг хангаж суурь тэнцэл 1.7 их наяд төгрөг байх ёстой. Урсгал зардал 26.2 их наяд төгрөг байх ийм тусгай шаардлагыг бид хангаж ажиллах ёстой.

Яг энэ хүрээндээ хангаад саяын хэлдэг төсвийн орлого 262 их наядаар тасалдаж байгаа энэ тохиолдолд бид үлдэж байгаа хугацаанд бид хүлээж байгаа гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн төв маань 27.9 их наяд. Нийт зардал маань 28.4 их наяд, суурь зардал маань 26.2 их наяд. Үүн дотор нь гадаад зээлийн хэрэгжүүлэх ажил үйлчилгээ 1.5 их наяд, нийслэлийн бондын зарцуулалт 686.5 гээд тэнцвэржүүлсэн тэнцэл -428, суурь тэнцэл маань 1 их наяд 700-гаар ингээд ийм байдалтайгаар бид хангах ёстой ийм байгаа. Энэ дээр 11 сарын гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл саяын миний хэлсэн тоо.

Одоо яг энэ дээр бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг бид хангаж ингээд яг энэ хүрээндээ гарахын тулд бид нар 2025 оныг 12 сарын хүлээж байгаа хугацаанд нийтдээ бид тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн маань 2 их наяд 363.4 тэрбум төгрөг. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн маань 1 их наяд 18.5 тэрбум төгрөг, урсгал зардал маань 596.1 тэрбум төгрөг гэдэг ийм байдалтайгаар бид санхүүжүүлэхээр ингэж 12 сар одоо үлдэж байгаа хоёр 7 хоногийн хугацаанд ажиллаж байна. Тэгээд бид төсвийн хууль ёсны тусгай шаардлага хангаж ажиллахаар л ингэж ажиллаж байгаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтын яг хөрөнгө оруулалтын санхүүжилт нийтдээ 611 төслийн 2 их наяд 915.9 тэрбум төгрөгийг санхүүжих дүнд нь олгох ёстойгоос бид 611 төслийн 1 их наяд 734.1 тэрбум төгрөгийг 60 хувийг нь олгочихсон санхүүжилттэй нь. 40 хувь

буюу 1 их наяд 180.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлээгүй үлдэгдэлтэй байна. Энэ үлдэж байгаа хоёр 7 хоногийн хугацаанд бид нар нэг орлогын байдалтайгаа уялдуулаад санхүүжүүлэх ийм.

Гадаадын тусламж бол 116 төсөл дээр 1 их наяд 959.4 тэрбум санхүүжих ёстой. Олгосон санхүүжилт 1 их наяд 772.5 тэрбум төгрөг буюу 90 хувийг нь олгочоод байна. Үлдэгдэл нь 18669 хувь буюу 10 хувь нь санхүүжилтийн үлдэгдэлтэй байгаа. Энэ дээр зээл нь бол 61.9 тэрбум төгрөг, тусламж нь 125 тэрбум. Гадаад зээлийн санхүүжилттэй 90 хувийн гүйцэтгэлтэй ийм байдалтайгаар явж байгаа.

Ингээд мэдээлэл танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Сангийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарт баярлалаа.

Сангийн сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Хамгийн доор Түвшин гишүүн байна уу? Түвшин гишүүнээр тасаллаа. Номин гишүүн солигдчихлоо ирцээрээ яах ёстой. Түвшин гишүүн асуулт асууж, санал хэлнэ.

Б.Түвшин: Төсвийн нөхцөл байдлыг сая бас тодорхой сонслоо. Ер нь энэ төсвийн тодотгол хийсэн. Дээрээс нь хэдүүлээ төсвийг батлаад саяхан тодотгол хийгээд 2, 3-хан сарын дараа л ийм их том зөрүүнүүд үүсээд байгаа нь л харамсалтай л даа. Тэгэхлээр энэ ДНБ-ийг ингээд тооцоолоод явж байгаа асуудал ингээд сүүлийн хэдхэн сарын дотор 5 их наяд, 3 их наяд гээд ингээд 8 их наядаар буурчихлаа. Яг энэ ДНБ-ээсээ төсвийн орлогоо шууд доош нь буулгаж төлөвлөдөг үү? 1 дүгээр асуулт.

2 дугаарт, энэ аж ахуйн нэгжүүдийн ялангуяа энэ аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварын төлөвлөгөө бас биелэхгүй явж байх шиг харагдаж байна. Миний хувьд энэ Монгол Улсын аж ахуйн нэгжүүд ёстой нөгөө бүсээ чангалаад татварынхаа хамгийн дээд хэмжээндээ хүртэл төсвөө цуглуулж байгаа байх. Цаашдаа ч ер нь энэ төлбөрийн чадварын асуудал бас муудаж магадгүй зүгээр харагдаад байгаа юм.

Тэгэхлээр доороосоо ерөөсөө энэ аж ахуйн нэгжүүдийнхээ төлөвлөгөөг авч дээш нь энэ хоёр талыг дотоодын нөөцөд нь доош нь буулгасан аж ахуйн нэгжүүдийнхээ тогтвортой төлөвлөлт хоёрыг дээш нь уулзуулж төлөвлөдөг үү? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт, энэ дутаж байгаа 2.2 их наядыг ер нь яах вэ? Яг үүгээр яг юу ямар үйл ажиллагаа, ямар зардлыг хасаж тодотгоё, хасаж энэ ондоо орёо гэж ингэж бодож байна?

3 дугаарт, энэ төсвийн бууралт 26 оны төсөвт нөлөөлөх үү гэсэн ийм 3 асуултыг асууя.

Сангийн сайд хариулах уу? 6 дугаар микрофоныг нээе Сангийн сайд.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад ярья. Тэгэлгүй яах вэ ДНБ болон бусад өөр 9 тоо төсвийн хүрээний мэдэгдэл дээр Эдийн засгийн хөгжлийн яамнаас

Их Хуралд ороод батлуулдаг юм байгаа юм. Энийг дагаад мөн макро тоонууд ирнэ. Тэр дээр гадаад худалдааны тоонууд, импорт, экспорт гээд эдгээр тоонууд дээрээ уялдуулж жишээ нь импорт. Импорт дээр бараа бүтээгдэхүүний мөн ангилал энэ юмнуудыг задалж гаргана л даа. Судалгаагаар аль болох л нарийн гаргана. Энэ дээрээ үндэслээд жишээ нь гаалийн албан татварын орлогын бүрдүүлэлт, тэгээд ДНБ-д эзэлж байгаа салбар салбарын эдийн засгийн идэвхжил энэ юмнуудыг харна. Уул уурхай, барилга, худалдаа, үйлчилгээ, тээвэр гээд эдгээр салбаруудын эдийн засгийн идэвхжил ямар байх нь вэ? Тэндээс аж ахуйн нэгжүүдийн орлого ямар байхаар төлөвлөөд ингээд орлогыг төлөвлөдөг байгаа.

Тийм учраас Их Хурал дээр баталдаг. Засгийн газраас өргөн барьдаг, Эдийн засгийн хөгжлийн яамнаас бэлтгэж гаргадаг энэ макро тоонууд дээрээ маш чухал өндөр ач холбогдол өгч төлөвлөлт хийх нь маш чухал байдаг.

ДНБ-ий дээш, доош хөдөлж байгаа тэр тоонууд дээрээ Эдийн засгийн хөгжлийн яамныхан хариу өгчхөөрэй.

2.3 их наяд төгрөгийн татварын орлого дутах эрсдэл байгаа. Энэ бол 11 сарын 30-ны тайлангаар гарч ирсэн ийм тоо шүү. Өнөөдрийн байдлаар арай багасаад ингээд явж байгаа. Тэгэхээр 2.3-аас 1.2 нь гаалийн албан татварын орлого байгаа. Энэ маань шууд ерөөсөө импорттой холбоотой. Импорт маань тэр хүснэгтээ гаргачих даа 12.5-аас 11.2 болж гүйцэтгэл нь оны эцэс рүү тэгж буурахаар байна. Тэгэхээр энэ импортын тоо бол гаальчдаас шууд бас шалтгаалахгүй. Гаальчид хилийн цаана байгаа бараа тавааруудыг нааш нь бушуу авчир бид нар татвараа авмаар байна гэж ингэж шаардах боломжгүй ийм зүйлүүд байдаг. Үүгээрээ нөгөө татварын орлого бүрдүүлэлт дээр ажиллаж байгаа байцаагч нараас арай өөр байдаг шүү.

Тийм учраас энэ хэмжээ ер нь яах аргагүй ингээд дутна дутна. Үлдэж байгаа зөрүүтэй 1 аравны нөгөө талд нь 2 орчим нь яг татварын аж ахуйн нэгжүүдийн орлого болон бусад албан татваруудын нийт орлого байгаа. Энэ дээрээ Татварын ерөнхий газар өргөн фронтоор бүх боломжоороо бүх хүчээ дайчилж ингээд ажиллаж байна. Ингээд үлдсэн хугацаанд аж ахуйн нэгжүүдтэйгээ тулж уулзаж байна.

Өөрөөр хэлбэл, юу юугүй данс хаахаасаа илүүтэйгээр туслан зөвлөж ямар боломжууд байна вэ. 11 сарынхаа энэ тайлант хугацааны ноогдлоо төлөөд дээрээс нь мөн 12 сарынхаа ноогдлыг он гараад биш наана нь төлөх ямар боломжууд байна гэх мэтчилэн ийм уулзалтуудыг хийж байна. Энд дурдах ёстой хэд хэдэн манай яг топ 100 аж ахуйн нэгжүүд ялангуяа эхний топ 10, 10-20-д байдаг аж ахуйн нэгжүүд маш үлгэр жишээ байгаа. Энэ бол манай үндэсний компаниуд. Энэ дотор манай төрийн өмчийн компаниуд ч байна. Манай урдаа барьдаг хувийн томоохон компаниуд ч байна. Эдгээр компаниуд голцуу өргүй, 12 сарынхаа ноогдлыг урьдчилж төлөхөд ч бэлэн байгаагаа зарим компаниуд илэрхийлж байгаа гэх мэт бид татварын орлого бүрдүүлэлт дээр онцгой анхаарч ажиллаж байна.

Тэгэхээр энэ орлого дутаж болзошгүй эрсдэл маань нэг ангилж харахаар 3-н зүйл.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: 3 зүйлээс, хэсэгт байна. 1 дүгээрт ингээд их татварын орлого. 2 дугаарт гаалийн татварын орлого. 3 дугаарт яг ингэж мөнгөн дүнгээр хэмжиж болохгүй нэг нөлөөлөөд байгаа зүйл маань сүүлийн үед энэ Татварын өршөөлийн хууль гарна, санаачилна гээд ийм хэл ам гарсан нь нэгэнт бас хүнд явж байгаа, бид чинь хавраас хойш л хүнд явж байна шүү дээ. Макро бодлогын үр дүнд сайн үр дагавар нь гарч байна. Тэрнийх нь мөн бас ингээд сөрөг үр дагавар нь ингээд төсөв дээр ирж байна. Ингэж байхад нөгөө дайран дээр давс гэдэг шиг ийм мэдэгдэл гарчихаар ялангуяа дүүргийн татвар, орон нутгийн татварууд дээр орлого бүрдүүлэлт дээр бас нөгөө сөрөг нөлөө гарч ирж байна. Татвараа төлөхгүй хойшлуулах, эргэлзэх ийм байдлууд үүсэж байгаа учраас энийг бас их даамжруулмааргүй байгаа юм. Ийм зүйл байна.

2026 оны төсөвт эхний улирлын зарим нэг татварууд дээр.../минут дуусав./

Н.Наранбаатар: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Өмнөх практикаар жилийн эцсийн буюу 12 сарын ногдуулалт дараа жилийнхээ эхний улиралд ордог. Зарим тохиолдолд бид бас нааш нь татаж байгаа учраас 26 онд бага хэмжээгээр нөлөөлнө. Гэхдээ 26 оныг бас төлөвлөлт, татварын төвлөрүүлэлт, гааль дээр ч тэр эдийн засгийн идэвхжүүлэлт энэ юмнууд дээрээ Эдийн засгийн хөгжлийн яамтайгаа дахиж бид нар эргэж ярилцана.

Н.Наранбаатар: Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Ер нь 6-9 сарын дотор ДНБ-ээ 2 удаа тодруулаад тэгээд нийтдээ 8 их наядаар бууруулж байгаа нь бид нар энэ ДНБ-ий тооцоолол жоохон үндэслэлгүй байгаад байна. Ялангуяа энийг төсөв хэлэлцэхэд бас яригдаж байсан. Үүн дотроосоо уул уурхайн салбар бол буураад уул уурхайн бус салбарууд өссөн гээд байгаа юм. Тэгэхлээр энэ хөдөө аж ахуйн салбар өсөж байгаа буюу уул уурхайн салбар нь буураад байгаа дээрээс үндэслэж аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар буураад байгаа нь гэдэг чинь ДНБ-ээсээ доошийгоо татварынхаа суурь руу буулгаагүй юм биш үү гэдэг энэ дүгнэлтэд хүргээд байна л даа. 1 дүгээр асуулт. Тэгэхлээр энэ асуудлыг бид нар цаашдаа анхаарч 2 талаас нь хийх хэрэгтэй байх.

2 дугаарт, энэ үнийн мэдрэмжийн хувьд бид нарын эдийн засаг үнэхээр хүнд байна л даа. Энэ үнийн хувьд, тоо хэмжээний хувьд харьцангуй 87 сая тонн гэдэг бол харьцангуй.../минут дуусав./

Н.Наранбаатар: Түвшин гишүүн тодруулъя нэмье.

Б.Түвшин: Гэтэл үнийг бид нар дахин дахин тодруулаад яриад л байхад л төсвийг батлахдаа 105-аар, тэгээд тодотгол хийхдээ 70-аар, одоо 65-аар гээд байгаа юм. Тэгэхлээр энэ үнийн хэлбэлзлийг ер нь төсвөө батлахдаа эхнээс нь багаар батлаад явж болдоггүй юм уу? Ер нь энэ татварын бодлогуудаа эргэж харж энэ аж ахуйн нэгжүүдээ дэмжих бодлого явуулах цаг бас тулаад байх шиг л харагдаад байна. Одоо энд аж ахуйн нэгжүүдийн хувьд үнэхээр чангалж байна.

Бид нарын төсвийн татварын сүүлийн орлого бол сүүлийн 3, 4 жил 2 дахин өссөн байгаад байдаг. Бид нарын зарцуулалт дээр бас жоохон үр дүн, ашиг багатай байгаад байдаг. Аж ахуйн нэгжүүд маань ингээд татвар төлөлт болон үнийн хэлбэлзэл дээр бас хэлмэгдээд ингээд эдийн засгийн хувьд чадавх нь

буураад байж байгаа. Тийм учраас энэ ДНБ-ий тооцооллын арга болон төсвийн орлого хоёрын уялдааг ер нь сайжруулах шаардлагатай байна гэж би хувьдаа үзэж байна.

26 оны хувьд энэ хэлбэлзлийг байхгүй болгож л ажиллах зайлшгүй шаардлага байна гэж.../минут дуусав./

Н.Наранбаатар: Эхлээд 1 номер хариулъя. Нэр, албан тушаал.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Макро тоонууд төсөөлөл зөрж байгаа энэ дээр ерөнхийдөө үндсэн 2 шалтгаан байгаа юм. Эхнийх нь одоо нарийн харах юм бол эдийн засгийн бодит өсөлтийн хэмжээ бидний төсөөлснөөс давж байгаа. Тодотголын үеэр 5.5 гэж байсан бол одоо бодит гүйцэтгэлээр 6 орчимд хүрч гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. Зөрөөд байгаа хэсэг бол нэрлэсэн ДНБ. Тодотгол хийснээс хойш 2 их наядаар буурч гарахаар байна. Энэний цаад шалтгаан биет хэмжээний экспорт болон биет хэмжээний үйлдвэрлэл дээр төсөөлсөн хэмжээнд байна. Тэрнээс давж байна. Үнийн асуудал байна.

Гол шалтгаан бол нүүрсний үнийг 70 гэж байсан бол одоо 65 орчим байна. Энэ бол экспортыг бууруулж байгаа. Гэхдээ би нүүрснээс.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж хариулъя. Гүйцээж.

Л.Энх-Амгалан: Нүүрсний үнэ буурсан ч гэсэн бидний төсөөллөөр 5.9 тэрбум долларын нүүрсний орлого олох байсан юм. Гэтэл энэ буурлаа гэхэд 5.7 л болж байгаа юм. 200 сая долларын л асуудал байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ тал дээр тийм том шалтгаан биш. Тэгэхээр яг үндсэн шалтгаан Засгийн газраас ч, Их Хурлаас ч өгсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн ажил валютын нөөцийг нэмэгдүүлэх л ажил болсон. Тэгэхээр валютын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд төрийн зочид компаниуд дээр хэмнэлтийн бодлого хэрэгжүүлсэн. Тэр хүрээнд Эрдэнэс Монголын хүрээнд гэхэд л 3 их наядын хөрөнгө оруулалт зардлыг царцаасан, хойшлуулсан байдаг. Тэгэхээр тэр хэмжээний эдийн засгийн үйл ажиллагаа явагдахаар төлөвлөж байсан бол тэр хэмжээгээр эдийн засгийн үйл ажиллагаа хумигдсан л гэсэн үг. Тэгэхээр бодлогын үр дүнд шууд төсөөллөөр гарч ирж байгаа нөлөөлөл гэж хэлж болно.

Нөгөө талдаа импортыг бууруулах хүрээнд суудлын автомашины, мөн хэрэглээний импортуудыг хязгаарлах мөнгөний болон санхүүгийн бодлогууд нэлээд хэрэгжүүлсэн. Бодлогын хүүг нэмэгдүүлсэн, зээлийн.../минут дуусав./

Н.Наранбаатар: Хариулт хангалттай юу? Өөр нэмж хариулах хүн байгаа юу? Дараагийн Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Мөнхсоёл гишүүний микрофоныг нээгээрэй. Сангийн сайд нэмээд хэн, хэдэн номер вэ? 8 номер уу? 8 номерын микрофон хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Тэгэхлээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр нийтдээ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд орж ирдэг. Энэ үзүүлэлтүүдээсээ орлогын доод хэмжээг тооцож гарч ирдэг. Ингэхдээ жишээ нь нүүрсний хувьд бид нар Эдийн засаг, хөгжлийн яамнаас бол нарийвчилсан байдлаар ямар нэр төрлийн нүүрс вэ гэдгээсээ шалтгаалаад үнүүдийг нь тооцож гарч ирдэг. Тэгээд тухайн жилдээ энэ

хэмжээний нүүрс нь жишээ нь энэ жилийн хүлээгдэж байгаа үндэслэл нь 87 сая тонн нүүрс нь хэр хэр хэмжээгээр ямар нэр төрлөөр гарсан байна гэдгээсээ шалтгаалаад 65 доллар дээр оччихоод байгаа юм.

Мэдээж хэрэг нэг талаасаа энийг 60 доллар гэдэг ч юм уу нөөцтэйгөөр авч төлөвлөх нь илүү аюулгүй мэт санагдаж болно. Гэхдээ тоог бид нар буруу төлөвлөж болохгүй. Аль болох бодитойгоор дөхүүлж төлүүлэх ийм зорилго байх ёстой. Мэдсээр байж тийм зүйл хийж болохгүй. Төлөвлөчихсөний дараа мэдээж хэрэг гүйцэтгэлийн хувьд яв цав нийлэхгүй байх өнөөдрийнх шиг ийм асуудал гарч байна л даа тийм.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн асуулт асууж, санал хэлнэ.

Б.Мөнхсоёл: Өнөөдөр Төсвийн байнгын хорооны хурал бараг 4, 5 дахь цаг дээрээ үргэлжилж байна. Тэгээд энэ 3 дахь асуудал маш чухал асуудал орж ирлээ. Өнөөдөр улс орны хэмжээнд төсвийн байдал хүндэрсэн. Энэ бол зөвхөн энэ өрөөнд сууж байгаа хэдхэн хүний асуудал биш, Улсын Их Хурлын 126 гишүүний асуудал биш, нийт иргэдийн санаа зовж байгаа асуудал.

Өөрөөр хэлэх юм бол тэтгэвэр, тэтгэмж, цалингаас бусад урсгал зардлыг гаргаж чадахгүй ийм хүн хүнд байдалд ирчихсэн. Зарим шалтаг, шалтгааны учир холбогдлыг өмнөх Түвшин гишүүн асуугаад хариултуудыг ерөнхийдөө сонсчихлоо. Би бас энэ танилцуулагдсан тооноос харсан яг энэ валютын албан нөөцийг нэмэгдүүлэхийн тулд импортыг хязгаарласан, хэрхэн гэж асуух гэж байсан сая хариулчихлаа 1 номерт. Тэр чинь өөрөө эргээд 1.2 их наядын орлого бууруулалтыг бий болгочихсон байна шүү дээ. Нэг том шалтгаан.

2 дугаарт нь тэр Эрдэнэс Тавантолгой нүүрсний 4 аж ахуйн нэгжүүдийн орлого 48, 50 хэдэн хувиар тус тус буурсан байна шүү дээ. Нөгөө талдаа харин ч Эрдэнэтийн болон Оюу толгойнх нэлээн өндөр хувьтай. Оюу толгойнх бүүр 110 хэдэн хувьтай өссөн байна гэх мэт тоонууд дээр ажиллахгүй бол гадагшаа нийтэд мэдээлэл өгөхдөө дандаа нарийн өгөхгүй бол ингээд ерөнхий бүдэг ярихаар одоо энэ орон даяар хариуцлагагүй байдал нэвт явж байна гэдэг дээр би анхаарал хандуулмаар байна. Хариуцлагагүй байдлыг өөгшүүлж, хариуцлагатай хэсгээ унагасаар байгаад энэ улс орон даяар юу гэх юм хариуцлагагүй байдлыг бүүр урамшуулдаг ийм тогтолцоо үүсэж байгаад би маш их харамсаж байна.

Тухайлбал, сая бас сайд ярилаа. Өглөө бас телевизүүд асууж байна. Тэр дуулиан шуугиан, нөгөө инфляц, хэрэглээний үнийг индексийг өсгөдөг тэр янз бүрийн чимээ анирууд шийдэл гарсан хойно, шийдвэр гарсан хойно, бодлого суурьтай гарсан хойно юмыг тараахын эсрэг хэт ингээд шийдэгдээгүй поп маягийн юмнууд явчихаар чинь нөгөө орлого төвлөрөл буурчхаад байна.

Нөгөө талдаа энэ байдал юуг харуулаад байна гэхээр бид нар ерөөсөө энэ татварынхаа реформыг хийхгүй бол болохгүй болчихсон. Татварынхаа реформыг хийхгүй болохоор мэдээж татвар төлж чадахгүй байгаа аж ахуйн нэгж энэ тэрүүд чинь зарим нь магадгүй энэ нөхцөл байдлыг ашиглачих юм сан гэх магадлалтай боловч ихэнх хэсэг нь бас ачааллаа даахгүй хэсэг байгаа шүү дээ. Тэгэхээр татварынхаа бааз суурийг өсгөхийн тулд бүгдээрээ татварынхаа реформыг үнэхээр хийх цаг нь тулчихсан гэдгийг энэ баталж харуулж байна.

Мөн зах зээл дээр бид нар жижиг, дунд бизнесээ дэмжихээс өөр аргагүй. Татварын бааз суурь буюу татвар төлөгч, аж ахуйн нэгж, иргэдийн тоог нэмэхийн тулд. Тэгэхгүй бол энэ АМНАТ болон зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын томоохон аж ахуйн нэгж дээрээ дөнгөж зөвхөн дөрөөлөх нь эргээд эдийн засгийн гажуудал үүсгээд байна шүү дээ. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд бүгд ихэнх нь сайжирчихсан мөртөө ийм дүр зурагтайгаа харьцангуй харамсалтай. Одоо Эрүүл мэндийн даатгалын сан хоосорчихоор үнэхээрийн асуудал дагуулж байгаа, санаа их зовж байгаа учраас үүнийг бас хэлчихье гэж бод.../минут дуусав./

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, санал хэлнэ.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Би Сангийн сайд эсвэл Сангийн яамнаас бүгдээс нь асуух гээд байгаа юм. Энэ 3 төрлийн татвартай холбоотой нэг ийм график гарсан. Судалгаа Статистикийн хорооноос. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар гээд 2016 онд энэ 3 татвар нийлээд 3 их наяд ч хүрдэггүй бага тоо байсан. 2021 онд энийг 6 орчим их наяд төгрөг байсан. Өнөөдөр 14.7 их наяд. Энэ юуг хэлж байна вэ гэх юм бол татварын орлогоор хувийн хэвшил, хувь хүмүүс хангалттай хэмжээний татварыг төвлөрүүлсэн, чадсан.

Тэгтэл 2016 онтой харьцуулахад 7, 8 дахин томорсон. 2021 онтой харьцуулахад 2.5 дахин томорсон энэ татварын орлого яг хувийн хэвшил дээр яаж дэмжлэг болж очсон бэ? Сангийн яам сайн ажилласан гэж бодож байгаа юу? Энэ дээр. Миний анзаарч байгаагаар Сангийн яам маш муу ажилласан. “Эрдэнэс Тавантолгой” дээр БЭТ тавьдаг байсан. Сангийн яамныхан очдог байсан. Эрдэнэс Монгол дээр хүн тавихад бас л Сангийн яамныхан очиж байсан. Тэгээд одоо өнгөтэй өөдтэй болгон дээр нь Сангийн яамныхан очиж ажиллачхаад одоо байгаа үр дүн нь сая Мөнхсоёл гишүүн хэлээд байна макро эдийн засгийн тоон үзүүлэлтүүд маш сайн гарч байгаа мөртөө орлого тасалдчихсан гээд сууж байгаа. Ямар ч төлөвлөлт хийж чадаагүй Сангийн яам. Тэгээд 2021 оноос хойш магадгүй хамгийн урт хугацаанд Сангийн сайд хийж байгаа манай Жавхлан сайд 3, 4 дэх Засгийн газартаа улираад ажиллаж байгаа. Гэтэл яагаад ийм хариуцлагагүй байдалд Монгол Улсын энэ сан хөмрөг тасалдах байдалд хүрээд байгаа юм? Энэ дээр та ямар хариуцлага хүлээж чадах вэ?

Дараагийн бас нэг энэ үнийн судалгаа байгаа. 2016 онтой харьцуулахад 2025 онд хамгийн бага өсөж байгаа хүнсний бүтээгдэхүүн 86 хувиар, хамгийн их өсөж байгаа нь 240 хувиар өсөж байгаа. Энэ яг иргэдэд ингэж дарамт болж очиж байгаа юм. Тэгээд энэ нөхцөл байдлаас бид нар харахад төсвийн бодлого яг сайн байгаа онож чадаад байна гэж та нар үзэж байна уу гэж асуух гээд байгаа юм.

Тэгээд миний бодлоор Монгол Арлын нам сүүлийн 10 жилд засаглахдаа иргэдээ хувийн хэвшлээ дэмжих биш яг л Монгол Ардын намын хулгайч нараа дэмжсэн бодлого л хэрэгжүүлж ирж чадсан. Цүнхний компаниуд баахан болсон, болоогүй тендерчид тэнд, энэ Сангийн яаман дээр би мэдэж байгаагаар баахан тендертэй холбоотой гомдол очиж байгаа юм. Цүнхний компаниуд авчихсан учраас гомдол очоод байгаа юм. Яг авч чадах ёстой компаниуд нь аваагүй. Эндээ асуултдаа хариулт авч байгаад дараагийнхаа юмнуудыг тодруулъя.

Н.Наранбаатар: 6 дахь микрофон Сангийн сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Гишүүнийг ойлгож байна сөрөг хүчний гишүүн учраас ийм өнцгөөс ярилгүй яах вэ. Би хариулт өгье. Аж ахуйн нэгжүүдийн орлогын татвар, хувь хүний орлого татвар, НӨАТ-ын орлого албан татвар, НӨАТ-ын татвар сүүлийн жилүүдэд өссөн. Энэ бол сайн сайн ажилласан гэсэн үг Засгийн газар. Үе үеийн Засгийн газар. Учир юу вэ гэвэл энэ сууриа их сайн тэлж чадсан байна эдийн засгийн өсөх хэрээр.

НӨАТ-ын хамрагдалт анх НӨАТ Ардчилсан нам Засгийн газар барьж байх үед энийгээ эхлүүлж байсан. Энэ бас нэг сайн эхлэл болсон шүү. 46 хувьтай эхэлж байсан НӨАТ-ын хамрагдалт өнөөдөр 80 хувь руу дөхөж ирж байна. Өөрөөр хэлбэл, тэр хэмжээгээр далд эдийн засаг буурч, татварын суурь тэлсэн гэсэн үг.

Тийм учраас энэ татварын бүртгэл, энэ суурийн тэлэлт дээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар ингэж нэмэгдэж боломж гарч ирж байгаа юм.

Дээрээс нь эдийн засгийн өөрийнх нь ДНБ энэ ерөнхий объём маань өөрөө өсөхөөр энэ төсвийн орлого энэ эдийн засгийнхаа идэвхжилийг дагаад өснө. Тийм ийм одоо хандлагаар явж өсөлт гарч ирсэн гэсэн үг.

Тэр БЭТ гэж байна. Энийг Сангийн яам томилдоггүй шүү уучлаарай. Энийг Засгийн газраас томилдог. Сангийн яам оролцож томилдог, илгээдэг ийм зүйл огт байхгүй. Харин ч эсрэгээр нь эерэг талаас нь харах юм бол энэ яам нь бас олон жилийн тогтвортой боловсон хүчний капитал, институт юм байна. Эндээс боловсон хүчнээ Засгийн газар авч байжээ л гэж ингэж харна. Тэрнээс биш Засгийн газар нь дотроо Сангийн яам нь мэдээд өөрөө томилдог БЭТ гэж нэг ч байхгүй. Та энэ дээр андуураад байх шиг байна.

Макро эдийн засаг, макро бодлого талдаа ийм юм байгаа юм. Хэрвээ бид хавраас хойш яг макро талдаа мөнгөний бодлоготойгоо уялдуулж энэ валютын нөөц, валютын ханш, зээлжих зэрэглэл эдгээр зүйлүүдээ урсгал тэнцлээ хэрвээ бариагүй алдсан бол төлбөрийн тэнцлийн алдагдал, төсвийн алдагдал хоёр нь бүүр давхцаад хос алдагдалд ороод өнөөдөр эдийн засгийн бүүр хямралд ирэх байсан, хямралд ирэх байсан. Энийг хоёуланг нь барина гэдэг ийм нөхцөлд ямар ч боломжгүй асуудал.

Тийм учраас макро тэнцвэрээ хадгалахын тулд мөнгөний бодлого, сангийн бодлого хоёр нийцтэй ажиллаж чаджээ. Энэ бол маш том үр дүн шүү. Хавар байсан төлбөрийн тэнцэлд 600 сая долларын алдагдалтай өнөөдөр 144 сая долларын эерэг гарсан байна. Он гараад бид нар ханшаа алдана, нөөц багасна, зээлжих зэрэглэлээ алдана гэдэг тийм айдас байхгүй болсон. Эдийн засаг цаашаа тогтвортой явна.

Одоо хэдийгээр орлого тасарсан ч гэсэн жилийн эцэс рүү бид Төсвийн хуульдаа бариулаад төсвийн тэнцлээ бариад гарна хуульчилсан хуулийн хэмжээнд нь. Тийм учраас бид төлбөрийн тэнцэл, төсвийн тэнцэл хоёр дээрээ яг хуулийн хэмжээнд макро тэнцвэрүүдээ бариад гарах учраас биднээс энэ гадаад нөхцөл байдал ийм тогтворгүй байгаа ийм үед эдийн засгийн хямрал бид нар холуур тойрч гарч чадсан ийм бодлогын үр дүн гэж ингэж харж байгаа. Дүнгийн судалгаан дээр Эдийн засгийн хөгжлийн яам хариулах байх тийм ээ инфляцтай холбоотой асуудлыг.

Тэр гомдлыг статистикийг нь манайхан хэлээдхээрэй. Энэ худалдан авалттай холбоотой гомдлын статистикийн аргынхан сүүлийн жилүүдэд эрс бууж ирж байгаа. Эрс буурч байгаа шүү гэдэг нь худалдан авах ажиллагаа элбэг чанаржиж байна, ил тод болж ирж байна, хариуцлагатай болж ирж байна гэсэн үг. Энэ худалдан авах ажиллагаа Шадар сайд дээр байдаг. Сангийн яаман дээр бодлого, хууль талаас нь бид нар хяналт тавьж ажилладаг ингэж явж байгаа.

Н.Наранбаатар: 1 номер нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Инфляц дээр төсвийн хүрээний мэдэгдэл батлагдахад инфляц ерөнхийдөө намартаа нэлээн инфляц нэмэгдэх болов уу гэсэн дарамт өндөр байсан. Тэгээд бидний тооцоогоор 9.5 хувь байх болов уу гэсэн тооцоолол хэлж батлуулсан байдаг. Одоо бидний хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 8.6, 7-н хувьтай гарчихаар байна. Хавар төсөөлж байснаас харьцангуй гайгүй гарна.

Шалтгаан нь валютын зах зээл тогтвортой байгаа. Тэрнээс үүдээд импортын инфляц байхгүй. Мөн тодорхой хүнсний бүтээгдэхүүнүүдээр нийлүүлэлт нь нэмэгдсэн. Өмнөх жилүүдэд нэмэгдэж байснаас харьцангуй даруухнаар өсөх тийм шинжтэй байна. Дараагийн 3 жилүүддээ инфляцын зорилтыг 7, 6, 5 гээд Монголбанкны үндсэн чиглэлтэй нийцтэй байхаар төлөвлөөд ингээд бодлогуудаа уялдуулаад ажиллаад явж байгаа.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Гааль, татвар хоёр дээр ажиллаж байгаа яг үнэн шударгаар ажиллаж байгаа мэргэжлийн албан хаагчдыг нийтээр нь буруутгаж байгаа юм биш. Гэхдээ Ерөнхий сайд нэг чиглэл өгөхөөр АТГ очиж шалгаад, нэг шалгасан хүнээс нь 20, 30 байшинтай авлигачууд гарч ирээд байгаа юм. Тэгэхээр зүгээр энэ дутаад байгаа орлогоо худлаа ярих нь энэ гааль, татварын ажилчдаас бараг бүрдүүлчих боломжтой юм уу гэж харах гээд байгаа шүү. Ер нь АТГ ажлаа сайн хийхгүй бол Монгол хулгайдаа живчих гээд байна.

Тэгээд Сангийн сайдаас яг зарчмын хувьд хоёрхон асуулт.

Одоо нөгөө тендер зарлагдаад аж ахуйн нэгжүүд хөдөө орон нутагт ч тэр, хотод ч тэр аваад хийчихсэн ажлуудынхаа гүйцэтгэл нь дуусчхаад байгаа мөнгөнүүдээ энэ ондоо авч чадах уу гэдэг нэг асуулт.

2 дугаарт нь хувийн хэвшил дээр дансаа хаалгачхаад байгаа, эсвэл дансыг нь хаагаад байгаа хүмүүстэйгээ хаахгүйгээр орлогыг нь бүрдүүлэх, хаахгүйгээр асуудлыг шийдэх ямар гарц гаргалгаа байгаа вэ?

Н.Наранбаатар: Сангийн сайд.

Б.Жавхлан: Өмнө түрүүн манай Төрийн нарийн бичгийн даргын энэ тоонууд дотор гарсан даа. Одоо 1.2 их наяд орчмын батлагдсан төсвийн санхүүжилтийн дүн байгаа. Тэрнээс одоогоор гүйцэтгэл ирсэн нь 100 гаруй тэрбум төгрөг, 92 тэрбум төгрөг байгаа. Он дуустал энэ ингээд бага зэргээр нэмэгдэх байх. Тэгэхдээ энэ жилийн гүйцэтгэл харьцангуй бага гарна. Яагаад вэ гэхээр 5 сарын 31 гэдэг хууль энэ жил анх удаа хэрэгжиж эхлээд 640 тэрбум төгрөгийн төсөв тэрүүгээр шууд хэмнэлтэд орсон. Тэр хэмжээгээр гүйцэтгэл бага гарна.

Тэгэхээр оны эцэс рүү яг санхүүжилт 200-300 тэрбум, maximum-даа л нэмж гарна гүйцэтгэл. Тэр нь ч хүрэхгүй дээ. Тийм учраас бид нар 2.3 дотор чинь энийгээ бас тооцоолчихсон явж байгаа учраас татварын орлого бүрдүүлэлттэйгээ уялдуулаад бид нар алдагдлаа нэмж болохгүй учраас өөрөөр хэлбэл орлогоо давсан зардал гаргаж болохгүй учраас хэчнээн хэмжээний бид нар орлогоо саяын хэлсэн дүнгээс бүрдүүлж чад.../минут дуусав./

Н.Наранбаатар: Нэмж гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Данс хааж байгаа арга хэмжээ бол эцсийн арга хэмжээ шүү. Тэгээд энийг үзэмжээр шийддэггүй. Энэ яг хуульчлагдчихсан албадлагын арга хэмжээний процессоор явж байгаа хамгийн сүүлийн арга хэмжээ. Өмнө нь энийг анхааруулна, удаа дараа мэдэгдэл хүргүүлнэ, мөн мэдэгдэл хүргүүлснээс хойш хоног, өдөр тоолно. Тэр хугацаанд ямар нэг татвар төлөх үйлдэл, оролдлого хийгээгүй бол данс хаана гэдэг ийм хуультай. Хэрвээ энийг татварын байцаагч хийгээгүй бол эс үйлдлээрээ татварын байцаагч өөрөө бурууддаг. Бид нар ийм хуулийн дагуу л татварын байцаагч нар маань ажилладаг.

Н.Наранбаатар: Нэмж хариулах юу бий юу? Тэгвэл Сайнзориг гишүүн одоо асуулт асууж, санал хэлнэ.

П.Сайнзориг: Ерөнхий мэдээллийг сонслоо. Товчхондоо хэлэхэд улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд 773.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ингээд байж байгаа юм байна 11 сарын байдлаар.

Тэгэхээр энэ зүйлийн асуудал ерөөсөө төлөвлөлтөөсөө эхэлсэн гэдэг нь л харагдаж байна л даа. Жил хүрэхгүй хугацаанд 2 удаа тодотголоо. Тодотгоод тодотгоод алдагдалтай гарч байна. Эдгээр бас үзүүлэлтүүдэд эерэг нөлөө үзүүлж байгаа зарим нэг асуудлууд байна валютын нөөц дээр.

Жишээ нь нийслэлээс бас энэ автомашины дугаар олголттой холбоотой зохицуулалт хийсэн. Дээрээс нь Монголбанкны бодлогын шийдвэр буюу банк бус болон зээлийн энэ автомашины хэрэглээний зээл дээр гарч байгаа урьдчилгаа төлбөрийг нэмэгдүүлсэн ч гэдэг юм уу нэг их өөр сүртэй юм алга. Тэгээд нүүрсний Монгол шүү дээ. Нүүрсний үнэ жоохон унахад л, нүүрсний үнэ, худалдан авалт жоохон унахад л бид хэд ингээд усаараа энд байж л байгаа байхгүй юу иймэрхүү нөхцөл байдалтай.

Тэгэхээр энэ чинь цаанаа нэг дохио өгөөд байна уу даа л гэж би бодож байна. Би бол Сангийн яам гэхээсээ илүүтэй Эдийн засгийн хөгжлийн яамныхан маань анхаараач ээ. Байгаа энэ хүрээнд төлөвлөх гээд орж ирэх нэг өөр. Энэ хүрээн дээрээ харин бодит эрсдэлийг хаасан, эдийн засгаа тогтвортой байлгахыг зорьсон, эргээд эдийн засгийн тэлэлтийг яг бодит утгаар нь авчирсан ийм эдийн засгийн төлөвлөлт хэрэгтэй байна шүү дээ.

Өөрөөр хэлэх юм бол зөвхөн нүүрснээс биш. Ирэх жилүүд чинь энэ нүүрсний үнэ, ханш бүүр ямар байхыг ч мэдэхгүй байна. Тэгээд Монголчууд андуураад байгаа юм. Зөвхөн Монголчууд бид нар Хятадад нүүрс нийлүүлдэг юм шиг. Үгүй шүү дээ. Энийг чинь бид нараас авахгүй байж ч болно гэж байгаа шүү дээ. Бид хэд маш олон өрсөлдөгчтэй. ОХУ-аас эхлээд нүүрс гаргаж байгаа маш олон улсууд Хятад руу байна. Тэгээд одоо нэг ганцаараа бид хэд нүүрстэй юм шиг

энд ингээд уул уурхайгаас тогтож байгаа эдийн засаг, уул уурхайгаас хамааралтай эдийн засгийнхаа үр шимийг хүртэж цалин, тэтгэвэр, бүх юмаа зохицуулж байгаа гээд ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Бүгд ингээд улс төржөөд уул уурхайн томоохон төслүүдээ явуулдаггүй. Томоохон төслүүдийн бас орон нутгийн дэмжлэгийг авч ажиллахад л тэр АМНАТ-ын хуваарилалтын асуудал байгаа.

Дээрээс нь энэ АМНАТ-аас орж ирж байгаа асуудал нь байгаль орчны асуудал руу нь жоохон тавиад өгчихмөөр байгаа юм. Дээрээс нь гадна дотнын гар, хөл болж явж байгаа энэ нөхдүүд бас болж л энэ эдийн засгийн бодит тэлэлт чинь зогсчихоод байгаа шүү дээ. Дээрээс нь энэ бодлогын буюу хууль, эрх зүйн орчны жоохон тодотголын асуудал дээр ингээд Засгийн газар хөдөлдөггүй. Ашигт малтмалын хуулийн сураг чимээ бараг 3 жил яригдаж байна. Байхгүй. Тэгээд ийм нөхцөл байдлаас чинь болоод энэ эдийн засаг чинь өнөөдөр ийм байдалтай болж байгаа юм. Тэгээд өнөөдөр магадгүй энэ зэсийн эрэлт хэрэгцээ дэлхийн зах зээл дээр нэлээн өндөр байгаа энэ үе дээр яг энэ зэстэй холбоотой АМНАТ-ын асуудлыг арай Эрдэнэт шиг биш. Тэгэхдээ энэ Оюу толгой шиг.../минут дуусав./

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Оюу толгой шиг арай 5 хувь байж болохгүй. Ядаж 12 хувь, 15 руу авчраад энэ зэсийн 2, 3 төсөл чинь бэлэн байгаа юм биш үү. Энэнээсээ наад захыг нь хөдөлгөөд энэ төсвийн орлогоо бас нэг тогтвортой байлгах энэ асуудлаа энэ ирэх 2, 3 жилдээ шийдэхгүй юу. Ирэх жил бүх цалин, тэтгэвэр нэмчихлээ шүү дээ. Тэгээд он гараад яг энэ эрчээрээ байх юм бол энэ төсвийн 1, 2 дугаар улиралд чинь төсвийн орлого бүрдүүлэлт маш хүнд байдаг. Юу угтах бол оо? Тэгэхээр ийм нөхцөл байдлууд дээр ямар арга хэмжээ авах вэ Жавхлан сайд аа? Та бас бодож байгаа юм байгаа юу? Мэдээж Төсвийн хууль батлагдсан байна. Төсвийн гүйцэтгэл энэ жилийн хувьд ингээд бас алдагдал байна. Энэ нөхцөл байдал гэдэг юм уу магадгүй бас он гараад эхний 1, 2 улирал дээр бас хүндрэлүүд үүсэхээр байна. Тэгэхээр бид ер нь яах ёстой юм бэ?

Тэгээд том бодлогын зүгээсээ Эдийн засаг, хөгжлийн яам Эдийн засаг, хөгжлийн яам шиг ажиллаж, төлөвлөж энэний гацааг манлайлж оруулмаар байна. Түүнээс биш ингээд улс төрд нь хөтлөгдөөд Ашигт малтмалын хуулийг нь оруулж ирдэггүй, эдийн засгийн төлөвлөлтөө хийдэггүй ийм байгаад байхаар чинь энэ чинь яаж төсвийн .../минут дуусав./

Н.Наранбаатар: Сангийн сайд хариулъя. Эхлээд Эдийн засгийн хөгжлийн яам 1 номер.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Гишүүний ярьж байгаатай яг л санал нэг байна. Одоо манай эдийн засаг нүүрснээс маш хамааралтай. Тэр хэрээрээ хэлбэлзэх боломжууд маш өндөр байдаг. Харин ч КОВИД-ын өмнө 1 жил 5-6 хувиар өсөөд явдаг байсан КОВИД-ын 2 жилд хасах руу орсон 1 хувиар өссөн жилүүд байсан. Түүнээс хойш 3, 4 жилд 6-7 хувийн хооронд өсөлтүүд тогтвортой хадгалагдаад байгаа. Мэдээж нүүрснээс хамаараад унах боломж маш өндөр, өсөх боломж ч өндөр. Саяхан таван жилийн төлөвлөгөө батлагдсан. Энэ таван жилийн төлөвлөгөө дээр эдийн засгийн бүтцээ илүү уул уурхайгаас биш бусад салбарууд руу төрөлжүүлэх бодлогын хүрээнд олон төслүүд батлагдсан гэж ойлгож байгаа арга хэмжээнүүд батлагдсан.

Тэгэхээр энэ дунд хугацааны бодлогын баримт бичгээ цаг тухайд нь жил болгоны төлөвлөгөөндөө оруулаад хэрэгжүүлээд явах байх. Тэгэхээр тэнд яг хэмжих үр дүнгүүдийг салбар болгоноор нь тоогоор харуулсан. Жил болгон тэр тоон үр дүнгүүд хэрхэн биелж байгааг эндээ яриад явахад механизм нь илүү зөв бүтэц рүү аваад явах болов уу л гэж л ингэж хариулах байна.

Н.Наранбаатар: Сангийн сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Эхлээд ямар ч байсан хэдүүлээ энэ оныгоо нэг гайгүй дуусгачих санаатай байна. Энэ дээр бид нар үзээд байна. Ирэх онуудад эдийн засгийн идэвхжүүлэлт яаж хийх вэ, батлагдсан Төсвийн хуулиа хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээрээ л дараагийн асуудал Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа нэлээн сайн хамтарч ажиллана. Ер нь салбар дундын зохицуулалт, эдийн засгийнхаа гол параметруудээ маш сайн харж явах хэрэгтэй.

Тэгэхдээ энэ жилийн хувьд бол бид яг том тоонуудаа их амжилттай харлаа л гэж харж байгаа. Ямар ч байсан хэрвээ бид нөөцөө алдаад, ханшаа алдаад, төлбөрийн тэнцлээ алдаад төлбөрийн тэнцлийн алдагдалтай, төсвийн алдагдалтай энэ жилийн эцэс гарсан бол 2026 онд бүр балрах байсан. Бүр байхгүй болгоод эдийн засгийн шууд хямрал руугаа орно. Ийм хос алдагдалтай болоод. Ямар ч байсан бид нар макро тэнцвэрээ барьж чадаад төсвийнхөө тэнцлийг хуулийнхаа хэмжээнд нь бариад гарчихна оны эцэс рүү. Зардлуудаа татаж байгаад ч хамаагүй.../минут дуусав./

Н.Наранбаатар: Тэнд эхлээд гүйцээгээд дараа нь. Жавхлан сайдын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм учраас 26 онд гарааны нөхцөл байдал бол бидний 25 оны жилийн эцсийн тоонууд бас гайгүй нааштай гарах учраас суурь эрсдэл бага орно 26 онд. Цаашаагаа ер нь өдөр өдрөөр ингээд өөрчлөгдөж байгаа гадаад нөхцөл байдал энэ юмнууд дотор бас урьдчилж их өөдрөг байдлаар хэлэхэд хэцүү. Мэдээж бас ийм тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилдэг учраас бас эрсдэл дундуур л явна.

Түрүүн тэр Түвшин сайдын асуусан тэр бага үнээр авч болдоггүй юм уу гээд. Түвшин сайд уг нь мэднэ дээ. Тэр нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр үнэ тооцох аргачлал дээр хуульчилчихсан байдаг юм шүү дээ. Сүүлийн 20 жилийн үнийн дундаж, тухайн жилийн үнэ, ирээдүйн 3-н жилийн дунджаар тэнцвэржүүлсэн үнэ авдаг. Ингээд зах зээлийн тухайн төсөв өргөн барих өдрийн зах зээлийн үнэ энэ хоёрын аль багаар нь авна гээд бүүр ингээд хуульчилчихсан. Тэнд үзэмжээрээ би энэнээс арай бага авмаар байна гэдэг ямар ч тийм сонголт байхгүй. Тийм ингэж төлөвлөдөг.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Тэгээд нэг их ийм юман дээр их Сангийн яамыг буруутгаад байх юм алга. Бид хэд төлөвлөлтөөсөө л эхлэх ёстой. Тэгээд хууль, бодлогын бичиг баримтаа баталж байгаа Улсын Их Хурлын гишүүн бид хэд байгаа. Тэгээд баахан бодлогын бичиг баримт батлаад байдаг. Тэн дээр том том зорилтууд тавьдаг. Тэр зорилтыг хэрэгжүүлэх наад захын зохион байгуулалт, тэр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх дээр ямар ч хуруу хумс хөдлөхгүй байгаа шүү дээ Эдийн засаг, хөгжлийн яам. Баахан гоё юм тавьдаг. Тэр том төсөл, хөтөлбөрүүдийг чинь

хэрэгжүүлэхийн тулд Ашигт малтмалын хуулийн чинь өөрчлөлтийг хүлээгээд байна. Тэр том төсөл, хөтөлбөрүүдийг чинь хэрэгжүүлэхийн тулд бусад тэр хууль, эрх зүйн орчин чинь хүлээгээд байгаа байхгүй юу. Яриад байдаг амаар аргалдаг. Одоо энийгээ дуусгавал яасан юм? Үнэхээр наад эдийн засаг чинь төлөвлөлтөөсөө болоод хэрэгжүүлэх нөхцөл, байдал нь бүрдэхгүй байхад та нар яаж ингээд ичихгүй ингээд орж ирээд л бид хэд ингээд тоогоо барихын тулд явж байгаа гээд яриад байдаг юм бэ? Тэгээд энэ боомтын сэргэлт чинь угаасаа дахиад энэ Ганцмод-Гашуунсухайтын юмнаас чинь болоод цаашаа явахгүй юм шиг байна л даа. Тэгээд энэ байдлаараа эдийн засгийн бодит тэлэлтүүдийг маш олон саадууд ирэх жилүүдэд харагдаад байна. Та хэд оруулж ирж цаас батлуулах чинь бүр тоймоо алдаж байна. Хэрэгждэггүй цаас.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Одоо Номин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Номин: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Сангийн сайд болон Эдийн засгийн хөгжлийн яамнаас бас хэлж байна л даа макро тэнцлүүдээ төлбөрийн тэнцлүүдэд бас сайн гаргах үүднээс мэдээж энэ төсөв дээр илүү дарамт авлаа гээд тэгж байна. Бид нар мэдээж олон улсын түвшинд ч нөхцөл байдлын хувьд ч хүнд жил явж байгаа.

Тэгээд манай Сангийн яамныхан маань боломжоороо аль болох хуульдаа нийцүүлээд өнөөдөр бас орж ирж байна гэж харж байна. Хэдийгээр бид бүхэн ингэж байгаа ч гэсэн он дуусахад 20-иодхон хоног байгаа.

Тэгэхээр 1 дүгээрт асуулт энэ дээр тооцоод орж ирснээс цааш очоод дахиад орлого бүрдэхгүй байх нөхцөл үүсэх боломж байгаа юу? Яагаад вэ гэхээр бид нар бас өнөөдөр төсөвлөсөн байдал дээрээсээ даруй нүүрсний үнэ маань 45 доллароор уначихсан байдалтай байгаа. Энэ цаашаагаа буух нөхцөл байдал энэ 20 хоногтоо гарах болов уу гэж бодож байна. Гарах уу гэдэг асуулт байна.

Нөгөө талдаа бид 2026 оноо бас бодож эхлэхгүй бол болохгүй болчхоод байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар нэгэнт аль хэдийн 1.6 их наядаар манай энэ нүүрсний орлого маань тасалдсанаас болоод бид нар алдагдалтай гарч байна гээд ингээд ярьж байгаа үед цаашдаа нүүрсний үнэ маань бүүр 55, 60 бүүр цаашаа унавал яах вэ? Бид нар 26 оноо дахиж бодитоор харж эхлэх хэрэгтэй байна. Энэ дээр та бүхэн юу гэж харж байгаа вэ? Үүнийг тооцож явах хэрэгтэй байна гэж ийм асуулт байна.

2 дахь асуулт нь болохоор сая бас Сангийн сайд танилцууллаа 611 төслийн гүйцэтгэл маань 60 хувийн гүйцэтгэлтэй буюу үлдсэн 40 орчим хувийн гүйцэтгэл нь олгогдоогүй байгаа буюу 1.2 их наядын үлдэгдэл үлдсэн байгаа. Тийм гүйцэтгэл ирээгүй байгаа тээ? Тэгэхдээ 20 хоног л хэдүүлээд байгаа шүү дээ.

Тэгэхээр 2026 он, 27 он руу энэ маань ингээд төсөл, арга хэмжээний санхүүжилт маань шилжээд орох нөхцөл үүсэх байх. Тэгэхээр энэ бас ямар хэмжээний дарамт болж орж ирэх бол оо? Энийг бас асуумаар байна.

3 дахь асуулт маань болохоор манай зээл маань 36.4 их наяд. Ойролцоогоор ДНБ-ий 40 орчим хувь байна гэж байна. Энэ оны эцсээр 179 тэрбумыг зээлийн хүү зардалтай явах юм байна. Тэгэхээр 1.3 их наяд орчмын зээлийн хүүгийн зардал дахиад дараа жилийн дарамтууд дээр бас байна. Тэгэхээр ингээд энэ зээлтэй холбогдолтой асуудлууд маань хэрвээ орлого буурсантай уялдуулаад та бүхэн

дээр хэр хэмжээний дарамтууд дараа жил рүү шилжиж орж ирэх вэ? Бид нар энэ дээр урьдчилсан төлөвлөгөө гаргаж ирэх шаардлагатай байгаа юу? Энийг бас хариулаад өгөөч гээд ийм 3 асуулт байна.

Н.Наранбаатар: Сангийн сайд 6 номер.

Б.Жавхлан: Номин гишүүний асуултад хариулъя. Үнийн хувьд ийм байгаа шүү. Сүүлийн 10 жилийн хугацаанд харах юм бол хамгийн доод хэмжээндээ ирчхээд байгаа юм. Сая бид нар тодотголоор 70 гэж авсан байна. Тэнцвэржүүлсэн үнээс хамаагүй бага доогуур. Тэнцвэржүүлсэн үнэ буюу түрүүний миний хэлсэн тэр хуулийн томъёоллоор авахаар энэ чинь бараг 129 доллар гарч байгаа байхгүй юу. Зах зээлийн үнэ нь 70 гэж бид нар ингэж үзээд авсан.

Одоо гүйцэтгэл дээр орж ирж байгаа 65 бол ийм үнэ юм байгаа юм шүү. Энэ жигнэсэн дундаж үнэ. Өөрөөр хэлбэл, 70 гэдэг ч үнэ байгаа, 80 гэдэг ч үнэ байгаа, 80-аас дээш ч үнэ байгаа. 70-аас доош ч үнэ байгаа. Одоо экспортолсон нүүрснийхээ бүтцийг харахаар хямд үнэтэй эрчим хүчний нүүрс нь ахиу гарчихсан энэ жил. Нөгөө коксожсон буюу хагас коксожсон, баяжуулсан нүүрс маань бид нарын тооцоолсноос бага гараад явчихсан. Тэрний шалтгааныг нь ярих юм бол нэлээн олон задлаад нэлээн урт юм ярих байх. Тэгээд 65 дээр ирж байгаа. Тэгэхээр нөгөө энэ тэнцвэржүүлсэн үнэ биш жигнэсэн дундаж үнэ гэдгийг та бүхэн бас энийг ойлгоорой.

Хэрвээ бид нар коксожсон үнэтэй нүүрсээ илүү борлуулж чадах юм бол энэ үнэ нь ингээд явах нь зах зээлийн үнээс биш. Энэ нөгөө төсвийн орлого тооцож байгаа үнэ маань ингээд дээшээгээ бас ийм хөвөх ийм боломжтой. Тэгэхдээ ер нь энэ бүтэц нэг их өөрчлөгдөхгүй болов уу гэж ийм хүлээлттэй байна.

611 төсөл. Энэ ийм байгаа. Одоо хүлээгдэж байгаа, дутуу байгаа 1.2 их наядаас гүйцэтгэл их өндөр ирэхгүй дээ. Одоо ингээд 12 сарын 5 болчихсон байж байгаа. Яах вэ 25 хүртэл нэлээн шахаад ирдэг. Тэгэхдээ их өндөр ирэхгүй. Эндээс 1.2-оос тал нь 27 онд дуусаж байгаа, тал нь 26 онд үргэлжилж байгаа төслүүд байгаа.

Хэрвээ 27 онд дуусах байж байгаад гүйцэтгэлээ авч чадахгүй ингэж үлдэх юм бол маш харамсалтай. 26 он дээр байхгүй тэр нь. Энэ чинь нөгөө сүүлийн мөнгө нь учраас. Тэгээд 27 он руу тавина гэдэг бол өөрөө төсөв дээр маш их дарамт ирнэ. Маш эрсдэлтэй. Ер нь захиалагч яамнууд ийм хариуцлагагүй аж ахуйн нэгжүүд дээр ер нь гэрээгээ шууд цуцлах хэрэгтэй. Дахиж шинээр тендер зарлаад явах хэрэгтэй. Ийм шаардлагууд тавина.

Одоогоор 92 тэрбум төгрөгийн гүйцэтгэл ирчихсэн санхүүжилтээ хүлээгдээд байж байна. Цаашаагаа нэмэгдэх нь энэ 2 дахин өсөх байх. Тэгээд тэрнээс дээш их өсөж бараг ирэхгүй бол уу гэсэн бид нар ийм судалгаа, ийм хүлээлттэй байгаа.

Бид зээлжих зэрэглэлээ сайжруулж чадсан. Энэ дээр 2 том юм гол нөлөөлсөн байгаа. Энэ бол бид зээлийнхээ таазыг маш сайн хязгаараа барьж ирж чадсан. Дээрээс нь бид Ирээдүй өв санг маш амжилттайгаар долларжуулж, төсвөөсөө тусад нь гаргаж чадсан. Өнөөдрийн байдлаар 5.6 их наяд буюу 1.7 тэрбум долларын Ирээдүй өв санг Төрийн сангаас долларжуулаад бүрэн тусгаарлаж чадсан. Таныг кабинетад ажиллаж байхад энэ 50 хувьтай л бид нар тусгаарлаж байсан. Одоо тэгвэл бага багаар нь тусгаарласаар байгаад хуулийн

өмнө Ирээдүй өв сангийн хуулийн дагуу бүрэн тусгаарлаж чадсан. Бид нар анх хүлээж авч байхад дансны хуулга л авч байсан. Одоо бол бүрэн ингээд тусад нь гаргаж чадсан. Тэгэхээр Монгол Улс өөрөө тогтвортой ийм бупер ийм валютын нөөц үлдэгдэлтэй юм байна гэдэг ийм 2 том зүйл маш сайн нөлөөлсөн байгаа.

Тэгэхээр ирэх жилүүдэд ингээд ДНБ маань тогтвортой 4-5 хувиар дор хаяж ингээд өсөөд байх юм бол энэ Засгийн газрын зээлийн өрийн үлдэгдэл, ДНБ-д эзлэх хувь энэнээс дээш нэмэгдэхгүй. Энэ харин ч багасна. Тэгэхээр эрсдэл буураад явна гэсэн үг. Тийм.

Н.Наранбаатар: Номин гишүүн тодруулъя.

Ч.Номин: Тэгэхээр хөрөнгө оруулалт дээрээ таны хэлж байгаагаар return on investment буюу хөрөнгө оруулалтынхаа чанарыг шалгаж үзэж байгаа зарим нэг төслийг бүүр цуцлах нөхцөл рүүгээ орох ийм байна гэж ойлгож болох уу тээ? Дараагийн энэ 40 хувийн гүйцэтгэл гараагүй байгаа бүүр шинээр эхлээд аягүй гүйцэтгэл нь тодорхой түвшинд очоогүй байгаа нь хөрөнгө оруулалтууд цуцлагдах магадлалтай юм байна гэж та хэлж байна гэж үзэж байна.

Ер нь нүүрсний аж ахуйн нэгжүүдийн хувьд нүүрсний энэ бүтэц их өөрчлөгдөхгүй илүү эрчим хүчний нүүрсийг Монголоос Хятад тал руугаа авах болов уу гэсэн тийм forecast-тай байна гэж ярьж байна лээ л дээ. Тэгэхээр та бол өнөөдрийн байдлаар энэ хэлээд байгаа жигнэсэн дундаж үнэ 65-аасаа дараа 2026 онд хэт их буурахгүй болов уу гэсэн төсөөлөлтэй байна уу гэж асууж байна.

Н.Наранбаатар: Сангийн сайд.

Б.Жавхлан: Энэ судалгааг яг Уул уурхайн яам болон Эдийн засгийн хөгжлийн яам илүү нарийвчлалтай судалдаг ийм яамнууд илүү тодорхой хэлэх болов уу гэж бодож байна. Миний хүлээлтээр битгий л буугаасай, үнэ битгий буугаасай. Өсөх хүлээлт бол байхгүй. Энэ хэмжээн дээр байгаасай. Бүтцийн хувьд коксожсон үнэтэй нүүрсээ л арай илүү түлхүү гаргах л ийм бодлого Уул уурхайн юм барих хэрэгтэй гэж ингэж бодож байна.

2 дугаарт, хариуцлагагүй захиалагч, хариуцлагагүй гүйцэтгэгчээс болж төсөв ингэж хохирч болохгүй. Тэгэхээр энэ дээр хариуцлага тооцож гэрээгээ цуцлах л ёстой. Тийм.

Н.Наранбаатар: Би нэг асуулт асуучихъя. Төсвийн орлого тасарч байгаа гол шалтгаан энэ уул уурхайн экспорт, дээрээс нь импортын гаалийн татвар л гэж ярьж байна. Өөр ямар татварын орлогууд тасраад байгаа юм? Тэрийг нэг орлогынх юм уу, татварынхан хэлээд нэр төрлөөр нь ямар орлого өөр тасарч байгаа юм? Экспортоос болоод аж ахуйн нэгж, АМНАТ хоёр гэж ойлгосон. Тэгээд гаалийн татвар гэж 3 юм л би ойлгочхоод байгаа юм. Өөр тасарч байгаа татварын орлого юу байна, шалтгаан нь юу байгаа юм, хэдэн хувиар тасраад байгаа юм? Оны эцэс рүү орох боломж байгаа юм уу үгүй юм уу гэсэн энийг мэдчихмээр байгаа юм. Бусдыг нь гишүүд асуучихлаа.

Ер нь бид нар энэ төрийн мөнгө гэж байх биш татвар төлөгчдийн мөнгө л байгаа. Тэгээд энэ зарлага тал дээрээ бас төсвийн сахилга хариуцлага, хуулийн хэрэгжилтийг бид нар та бид анзаарч байхгүй бол болохгүй. Энэ ОНӨҮГ, аж ахуйн нэгж гэж ёстой замбараагүй байгуулж байна. Одоо энэ төрийн босоо тогтолцоотой

агентлагуудтай яг зэрэгцэж орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байгуулж байна.

Нөгөө талаараа хувийнхны хийж байгаа бизнестээ давхардуулаад бас орон нутгийн өмчийг ер нь борооны дараах мөөг шиг л байгуулж байна. Эд нарыг ер нь та бүхэн эргэж харах хэрэгтэй юм байна. Эргэж цэгцлэхгүй бол болохгүй юм байна. Орон нутгийн өмчөөр хүний эмнэлэг ч байгуулж л байна, шүдний эмнэлэг ч байгуулж л байна, Архины наркологийн төв ч байгуулж л байх юм. Сүүлдээ тэмээний эмнэлэг ч байгуулж л байна, сэргээн засах эмнэлэг ч байгуулж л байна, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төв гээд агентлаг байж байна. Аймгуудад байж байна. Тэрний хажуугаар дахиад Сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төв гээд ингээд л маш олон орон тоо батлаад л тэгээд урсгал зардал батлаад л тавьчихаж байгаа юм. 70-н хэдэн орон тоо тэгээд л 4, 5 тэрбум гээд л ингээд л нэг байгууллагад. Тэгээд л автомат удирдлагын төв гээд л ерөөсөө замбараа алга. Төсвийн сахилга бат дээр эргэж та нар анхаарахгүй бол болохгүй нь.

Тэгээд эдгээрийгээ анхаарахгүй тэгээд төсөвт байгууллагуудын дарга нар нягтлангуудаас оны эцсийн гүйлгээ цалингаас бусдыг нь хийж болохгүй. Дулаан, халаалтаас бусдыг нь хийж болохгүй гээд л бид нар төсвөө чангалаад байдаг. Хажуугаар нь ингээд ОНӨҮГ байгуулаад ингээд замбараагүй явж байгаа. Энэ дээр анхаараарай гэж хэлэх гэсэн юм. Тэгээд түрүүний татварын орлого дээр мэдээлэл өгөөдхөөч.

8 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Тасарч байгаа орлого түрүүн тайлбарлачихсан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. Тэгэхдээ гол нөлөөлж байгаа нь нүүрстэй холбоотойгоор. Мөн гаалийн орлого тасарч байгаа. Харин цалин хөлстэй холбоотой орлогууд болох НДШ-ийн орлого бол 97 хувьтай биелэхээр хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй байна. ЭМД-ын шимтгэлийн орлого 95 хувьтай, хүн амын орлогын албан татвар 95 хувьтай мөн биелэхээр тооцдог юм. Тэгэхлээр үндсэндээ зорилтдоо хүрэхээр байна гэж тооцож байгаа.

Мөн дотоодын хэрэглээг голлон бас тооцдог НӨАТ-ын орлого байгаа. НӨАТ-ын орлого бол дотоодын НӨАТ-ын орлого бас 98 орчим хувь руу бас нэлээд дөхөж гарах болов уу гэсэн бид нар хүлээж байгаа гүйцэтгэлтэйгээр тооцож байна.

Орон нутаг дээр чиг үүргийн давхцалтай холбоотой асуудал дээр Сангийн яамны зүгээс Улсын Их Хуралтай хамтран болон л бас ажлын хэсэг дээр нэлээд ажилласан. Түрүүн бас презентаци дээр гарсан жишээ нь төсвийн хүрээний мэдэгдэл дээр орон нутгийн нийт, төрийн нийт зарцуулах зарлагын дээд хэмжээг баталдаг. Үүнээс орон нутгийн зарцуулах нийт зарлага 6.9 их наяд гэж баталсан боловчиг орон нутгийн зардал өөрсдөө ИТХ маань Үндсэн хуулиар олгогдсон бие даан төсвөө батлах энэ өөрөө удирдах ёсныхоо хүрээнд 2.6 их наядаар нэмээд баталчхаж байгаа юм. Тэгэхлээр төрийн нийт зарцуулах зарлага маань өөрөө нэмэгдээд явчхаж байгаа ийм асуудал байгаа.

Одоогийн байдлаар жишээ нь гүйцэтгэл 6.9-өөр баталсан нь 6.8 дээр оччихсон байна гэсэн үг. Тэр энэ хэсгээрээ одоо энэ зарлага бас цалингаа тавиад эхлэхлээр жишээ нь ингээд нэмэгдээд гарахаар байгаа. Энэ хэмжээгээр бас

давхцалын асуудлууд байна гэж харж байгаа. Бидний хувьд тодотголтой хамт орон нутгийн төсвийг төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан удирдах, мөн орон нутгийн орлогыг бас тодорхой хэмжээнд зохицуулах ийм эрх авах зарим нэг заалтуудыг боловсруулж Их Хуралд танилцуулж байсан.

Гэхдээ энийг илүү боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн учраас тухайн үед батлагдаагүй. Ирэх төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид бас энийг илүү боловсронгуй болгох. Бид нар нэгдсэн төсвийн бодлоготой улсын хувьд Улсын Их Хурал дээрээс өгөгдсөн үүрэг чиглэл, Улсын Их Хурал дээрээс баталж байгаа жилийн хөгжлийн төлөвлөгөө, таван жилийн хөгжлийн төлөвлөгөөтэйгөө нийцсэн, Засгийн газрын мөрийн хөтөлбөртэйгөө нийцсэн байдлаар бас орон нутаг төсвөө илүү чиглүүлж баталдаг болох тал дээр бас зорилтот арга хэмжээнүүдийг авч, арга хэмжээний саналыг ирэх хавар танилцуулахаар ажиллаж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Танилцуулгатай холбоотой санал хэлэх гишүүд нэрсээ өгье.

Түвшин гишүүнээр тасаллаа. Түвшин гишүүн.

Б.Түвшин: Энэ төлөвлөлтийн асуудал дээр ер нь суурь бодлого хэрэгтэй байна. Бид нар энэ ДНБ-ээ 2 ч удаа тодотгоод хэлээд байхад л дахиад л тэрэндээ хүрэхгүй байна. Үүнээс доош нь буулгаад нөгөө салбар руугаа орохлоор уул уурхай нь буураад уул уурхайн бус нь өсөөд байна гээд байгаа. Тэгээд энэний зөрүү магадгүй энэ дотоод салбарын зөрүүгээс болж тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар буурсан уу гээд түрүүн л гол асуух гээд байсан асуултын санаа бол энэ.

Тэгэхлээр энэ юуг хэлээд байна гэхлээрээ ДНБ-ийхээ энэ төрөлжилтийг, энэ төрөлжилт болгоноос доошийгоо татвараа буулгаж төлөвлөж байгаа байдал бас хэр үр дүнтэй байна уу үгүй юү гэдэг асуудлыг 1 дүгээрт бид нар цаашдаа анхаармаар харагдаж байна.

2 дугаарт, энэ 2.2 их наядын дотор сайн зүйл гээд байгаа тэр төлбөрийн тэнцлээ барилаа, валютын нөөцөө нэмэгдүүлээ гээд байгаа боловч ямар арга хэмжээ авч байна вэ гэхлээрээ тухайлбал түрүүн дурдагдлаа л даа Эрдэнэс Монголын 3 их наяд долларын хөрөнгө оруулалтыг царцаасан, хэрэглээг механикаар хассан, машины импортыг бууруулсан, бодлогын хүүгээ өсгөсөн гэх мэтээр ингээд эргээд эдийн засаг, бизнесээ хумьсан ийм бодлогууд явж байж энэ зарим нэг эдийн засгийн үр дүнгүүд гарч байна.

Тэгэхлээр том зургаараа бид нар ерөөсөө л уул уурхайгаас хэтэрхий их хамааралтай болчихсон. Одоо эргээд яг энэ уул уурхайн үнийн жоохон хэлбэлзэл орж ирэхэд бид нар төсвийн зарлагаа хянаж, хасаж чадахгүй ийм байдал руу ер нь ороод ингээд яг эхний хэд хэдэн удаагийн шинж тэмдгүүд мэдэгдээд байгаа учраас цаашдаа энэ эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, бусад салбаруудаа идэвхжүүлэхийн тулд энэ татвар, нийгмийн даатгалын цогц бодлогоо явуулах, уул уурхайгаас үл хамааралтай болох буюу эдийн засгаа сэргээх томоохон төслүүдээ явахгүй бол ерөөсөө яг одоо бид нар нэг ийм яг тодорхой төсөв, тодорхой уул уурхайн бүтээгдэхүүнээс хамаараад ингээд улсын эдийн засгаараа зогсож байдаг, гацах ийм эрсдэл рүү явж байна. Одоо бид нарын хувьд ч гэсэн ДНБ-д эзэлж байгаа төсвийн болон төрийн оролцооны дүн асар их байгаад байна.

Дээрээс нь эндээс бас нэг харагдаж байгаа зүйл бол нийслэлийн төсвийн тухай асуудал, бас орон нутгийн төсвийн тухай асуудал яригдаж байна. 2024 онд байх нийслэлээс 1.8 их наядын татаас, татвар авдаг байсан бол одоо тэрийгээ авахаа больсон. Одоо энэ жил бас авахаа болиод ингээд төлөвлөж байхад дахиад цаашаагаа 2.6 их наядаар ингээд зардлаа нийслэлд нэмэгдүүлж байгаа энэ дүр зураг нь бид нар энэ төвлөрсөн төсөв рүүгээ буюу нэгдсэн төсөв рүүгээ татаж байгаа татаасаа дахиж эргэж харах, хэрвээ энэ татаасыг хэвээр нь байлгасан бол бид нар энэ төсвийн алдагдалд хүрэхгүй ч байх ийм үр дүнд хүрэх байсан юм болов уу гэж ингэж харж байна.

Тэгэхлээр бид нарын зардал, гаргаад байгаа зардал эдийн засгаа дэмнэх биш ерөөсөө л нэг ийм механик үйлдлүүд болоод цаашдаа эдийн засгийн өөрийн идэвхжилийг дэмжих чадваргүй байгаад байна гэдгийг эндээс ингэж харагдаад байгаад байгаа юм.

Тэгэхлээр ерөөсөө энэ төлөвлөлтийн асуудал дээр бид нар яаж улсын төсвийг дотоодын нөхцөлд эзлэх хувийг багасгах вэ гэхлээр энэ хамгийн түрүүнд хийгдэх ажил бол татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийн дараа ТӨК-ийн асуудлууд ялт ч үгүй яригдаж эхэлж байна. Энэ бол эдийн засгийн идэвхжилтийг хаасан, бусад өөрөө өсөх иргэдийн бизнес хийх боломжийг хязгаарласан байгаад байгаа учраас энэ 26 онд ТӨК-удыг цөөлөх, энийг хувьчлах, эндээс тодорхой мөнгө оруулж ирж энэ 26 онд эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх ийм бодлогуудыг оруулж ирээч гэдгийг бас тодорхой санал болгож байна.

Ер нь цаашаагаа уул уурхайгаас хамаарал багатай иргэдийн бизнесийг дэмжих төсвийн бодлого, төлөвлөлтийн асуудал бол бид нарын эдийн засгийн амин чухал асуудал болоод байна гэдгийг энэ өнөөдрийн бид нарын эдийн засгийн нөхцөл байдал харуулаад байгаа гэдгийг та бүхэн бас ойлгож байгаа байх.

Н.Наранбаатар: Сангийн сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын мэдээллийг Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

17.10 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

